



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙГ ХӨГЖҮҮЛЭХ СТРАТЕГИ

Улаанбаатар хот
2016 он





Монголбанкны Ерөнхийлөгч
Н.Баяртсайхан

Төлбөр тооцооны үндэсний зөвлөлийн эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн зах зээлийн найдвартай, үр ашигтай, тасралтгүй ажиллагаа бүхий дэд бүтцийг хөгжүүлэх үйл хэрэгт хамтран зүтгэж буй Та бүхэнд Монголбанкны нэрийн өмнөөс болон хувиасаа чин сэтгэлийн халуун мэнд хүргэе.

Монгол Улсын Үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэхэд Монголбанкнаас ихээхэн ач холбогдол өгсөөр ирсэн бөгөөд төлбөрийн системийг мэдээллийн технологийн хурдацтай хөгжил, хууль эрх зүй, зохицуулалтын орчинтой харилцан уялдаатай цогц байдлаар хөгжүүлэх бодлогыг баримтлан ажиллаж ирлээ.

Ингэхдээ бид та бүхний хамтын оролцоотойгоор дотоод нөөц бололцоондоо тулгуурлан шинэчлэлт, сайжруулалтыг хийхийн зэрэгцээ гадаад хамтын ажиллагаандаа түшиглэн олон улсын байгууллагуудтай төсөл хөтөлбөр хэрэгжүүлж, тодорхой үр дүнд хүрч байна.

Үндэсний төлбөрийн системийн цаашдын хөгжлийн чиг баримжааг тодорхойлох, эрх зүйн орчинг бэхжүүлэх зорилготойгоор Монголбанк, Дэлхийн банкны хамтран хэрэгжүүлж буй техник туслалцааны төслийн эхний үе шатны үр дүн буюу “Монгол Улсын үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэх стратеги”-ийг өнөөдөр та бүхэнд толилуулж буйг албан ёсоор мэдэгдэхэд таатай байна.

Энэхүү стратегийг боловсруулахад үнэтэй хувь нэмэр оруулсан Дэлхийн банк, түүний чадварлаг багт чин сэтгэлийн талархал илэрхийлж байна. Түүнчлэн уулзалт, семинарт идэвхтэй оролцож, нөхцөл байдлыг бодитоор үнэлэхэд туслалцаа үзүүлсэн ТТҮЗ-ийн гишүүн байгууллагуудад талархал илэрхийлье.

Үндэсний төлбөрийн системийн стратегийн баримт бичигт олон улсын хандлага, сайн туршлагыг үндэслэн авах арга хэмжээний төлөвлөгөөг хууль эрх зүйн тогтолцоо, их дүнтэй бөгөөд хугацааны хувьд чухал төлбөр тооцооны зохицуулалт, жижиглэнгийн төлбөр тооцооны систем, олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, Засгийн газрын төлбөр, үнэт цаасны төлбөр тооцооны зохицуулалт, валютын арилжаа, банк хоорондын зах, төлбөрийн системийн хяналт, хамтын ажиллагаа гэсэн 9 тулгуур чиглэлээр авч үзсэн.

Монголбанк энэхүү стратегийн хүрээнд хууль, эрх зүйн орчныг сайжруулахад шаардлагатай Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн төслийг боловсруулж байгаа болно.

Уг стратегийг амжилттай хэрэгжүүлэхэд ТТҮЗ-ийн бүх гишүүн байгууллага үүрэг хүлээх бөгөөд тулгуур чиглэлийн дагуу хийгдэх ажлуудыг Та бүгд холбогдох төлөвлөгөөндөө тусгаж, Монголбанктай хамтран ажиллана гэдэгт итгэж байна.

Түүнчлэн, Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй “Төлбөрийн системийн шинэчлэл” төслийн хүрээнд хийгдэх төлбөр тооцооны системийн дэд бүтцийг олон улсын жишигт нийцүүлэх ажлыг эхлүүлээд байна. Энэхүү төслийн үр дүнд банк, санхүүгийн байгууллагын бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл нэмэгдэж, шинэ дэвшилтэт технологид суурилсан төлбөрийн хэрэгслүүдийг ашиглах таатай боломж бүрдэх юм.

Ингээд та бүхний Монгол Улсын Үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэх үйлсэд өндөр амжилт хүсэж ТТҮЗ-ийн 16 дугаар ээлжит хуралдаан, Монгол Улсын үндэсний төлбөрийн системийн хөгжлийн стратегийг танилцуулах ёслолын ажиллагааг нээснийг мэдэгдье.



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙГ ХӨГЖҮҮЛЭХ СТРАТЕГИ

2016 оны 8 дугаар сар

4	АГУУЛГА	МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙГ ХӨГЖҮҮЛЭХ СТРАТЕГИ
---	---------	--

Товчилсон нэр томъёо	5
I Товч хураангуй	7
II Үндэслэл	16
III Үндэсний төлбөрийн системийн стратегийг боловсруулсан арга зүй	17
IV Үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэх стратеги болон	
Хэрэгжүүлэх төлөвлөгөө	20
4.1 Зорилго, зорилтууд	20
4.2 Үндэсний төлбөрийн системийн онцлог шинж чанарууд	20
4.3 Суурь зарчмууд	21
4.4 Амжилтын хүчин зүйлс	21
4.5 Хэрэгжүүлэх стратеги	22
Багана I. Хууль, эрх зүйн тогтолцоо	22
Багана II. Их дүнтэй бөгөөд хугацааны хувьд чухал төлбөрүүдэд зориулсан	
төлбөр тооцооны механизм	25
Багана III. Жижиглэнгийн төлбөр тооцооны системүүд	28
Багана IV. Засгийн газрын төлбөрүүд	32
Багана V. Үнэт цаасны хадгаламжийн төв, клиринг, төлбөр тооцооны	
зохицуулалт	33
Багана VI. Валютын арилжаа, банк хоорондын мөнгөний зах зээл	37
Багана VII. Олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	38
Багана VIII. Хяналтын тогтолцоо	40
Багана IX. Хамтын ажиллагаа	43
Хавсралт 1: Хэрэгжүүлэх төлөвлөгөө	45
Хавсралт 2: ТЗЗДБХ-ҮЦХОУБ-аас гаргасан Санхүүгийн зах зээлийн	
дэд бүтцийн зарчмууд (СЗЗДБЗ)	58
Хавсралт 3: Жижиглэнгийн төлбөр тооцооны цогц стратегийг боловсруулах	
удирдамж	62
Хавсралт 4: Олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээний ерөнхий зарчмууд	63
Хавсралт 5: Үр дүнтэй хяналтын ерөнхий зарчмууд	64
Хавсралт 6: Төлбөрийн системийг хөгжүүлэх ерөнхий удирдамж	65
Хүснэгт	
Хүснэгт 1: ҮТС-ийн стратегийн тулгуур баганууд	11
Шигтгээ	
Шигтгээ 1: ТЗЗДБХ-ны Үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэх	
ерөнхий удирдамж	19

ACH/АКТ	Автоматжуулсан клирингийн төв
АТМ	Автомат теллер машин
AML/CFT	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх
BCP	Тасралтгүй ажиллагааны төлөвлөгөө
BIS/ОУТТБ	Олон улсын төлбөр тооцооны банк
CBBS/ТБҮЦ	Төв банкны үнэт цаас
CPMI/ТЗЗДБХ	Төлбөрийн болон зах зээлийн дэд бүтцийн хороо
CRC/ХХЗХ	Харилцаа холбооны зохицуулах хороо
DNS	Тодорхой цагийн үр дүнгийн тооцоо
DR	Онцгой байдлын төлөвлөгөө
DvP/ТЭН	Төлбөрийн эсрэг нийлүүлэлт
FIFO	Эхэлж авснаа эхэлж зарлагадах
FMI/СЗЗДБ	Санхүүгийн зах зээлийн дэд бүтэц
FRC/СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
FSAP	Санхүүгийн салбарын үнэлгээний програм
FSC/СТБЗ	Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл
GP	Олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээний ерөнхий зарчмууд
IETS	Банк хоорондын цахим арилжааны систем
ILF	Өдөр дундын төлбөр түргэн гүйцэтгэх чадварын хэрэгсэл
IMF/ОУВС	Олон улсын валютын сан
IOSCO/ҮЦХОУБ	Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага
IPCCN/KHC	Банк хоорондын төлбөрийн картан нэгдсэн сүлжээ
ITD/MTG	Монголбанкны Мэдээллийн технологийн газар
KYC	Харилцагчийг таних
LVPS/БДТТС	Бага дүнтэй төлбөр тооцооны систем
MBA/МБХ	Монголын банкны холбоо
MD	Монголбанкны Зах зээлийн газар
MNT	Төгрөг
MFI	Бичил санхүүгийн байгууллага
MOF/СЯ	Сангийн яам
MoU	Харилцан ойлголцлын санамж бичиг
MPD/МБГ	Мөнгөний бодлогын газар
MSE/МХБ	Монголын хөрөнгийн бирж
MTO	Мөнгө шилжүүлэх оператор
NETC/ҮЦГТ	Үндэсний цахим гүйлгээний төв
NGO/ТББ	Төрийн бус байгууллага
NPS/ҮТС	Үндэсний төлбөрийн систем
NPSC/ТТҮЗ	Төлбөр тооцооны үндэсний зөвлөл
NPSS/ҮТТС	Үндэсний төлбөр тооцооны стратеги
PAD/ТТБГ	Монголбанкны Төлбөр тооцоо, бүртгэлийн газар
PFMI/СЗЗДБЗ	Санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн зарчмууд
POS/ПОС	ПОС төхөөрөмж
PSOU	Төлбөрийн системийн хяналтын нэгж
PPRD/ТБЗХ	Төлбөрийн бодлого, зохицуулалтын хэлтэс

PSDG	Дэлхийн банкны Төлбөрийн системийг хөгжүүлэх баг
PvP/Тэт	Төлбөрийн эсрэг төлбөр
RMU	Эрсдэлийн удирдлагын нэгж
RSP	Мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэгч
RTGS	Бодит цагийн горимоор, нэг бүрчлэн хийх төлбөр тооцооны систем буюу Банксүлжээ систем
SCCs/X3X	Хадгаламж зээлийн хоршоо
SCHCD/ҮЦТТТХТ	Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв
SIPS	Системийн хувьд чухал төлбөрийн систем
T-Bills	ЗГ-ын богино хугацаат үнэт цаас
T-Bonds	ЗГ-ын урт хугацаат үнэт цаас
USD	Америк доллар
WB/ДБ	Дэлхийн банк
WBG	Дэлхийн банкны баг

I. Товч хураангуй

Монголбанкнаас Монгол Улсын Үндэсний төлбөрийн системийг 2015-2020 онд хөгжүүлэх Стратегийн баримт бичиг (цаашид ҮТС-ийг хөгжүүлэх стратеги буюу Стратеги гэх)-ийг боловсрууллаа. Монголбанк нь 2009-2014 онд хэрэгжүүлэхээр тодорхойлсон үндэсний төлбөр тооцооны стратеги (ҮТТС)-ийн зорилтуудыг амжилттай хэрэгжүүлсэн билээ. ҮТТС-ийн гол амжилтуудаас дурдвал: Төлбөрийг бодит цагийн горимоор, нэг бүрчлэн гүйцэтгэх төлбөр тооцооны систем буюу Банксүлжээ системийг нэвтрүүлсэн; Монголбанкнаас төлбөрийн системийн талаар баримтлах бодлого болон Төлбөрийн системийн хяналтын бодлогыг тодорхойлсон; Төлбөрийн системийн оролцогч хоорондын их дүнтэй болон бага дүнтэй төлбөр тооцооны журмыг тус тус гаргасан; Бага дүнтэй төлбөр тооцоотой холбоотой хийгддэг залиланг бууруулж чадсан; Цахим төлбөрийн хэрэгслийн хэрэглээг нэмэгдүүлсэн; Төлбөрийн системийн хяналт хариуцсан Төлбөрийн бодлого, зохицуулалтын хэлтсийг бий болгосон зэрэг явдал юм.

Монгол Улсын санхүүгийн салбар, эдийн засгийг хөгжүүлэхэд санхүүгийн зах зээлийн найдвартай, үр ашигтай дэд бүтцийг бий болгох явдал чухал юм. Төлбөрийн, мөнгөн гуйвуулгын, үнэт цаасны төлбөр тооцооны систем үр ашигтай, тасралтгүй ажилласнаар иргэн, аж ахуй нэгж, байгууллага хоорондын санхүүгийн үүрэг, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг найдвартай хийгдэх боломжтой болно. Үндэсний төлбөрийн системийн шинэчлэлийг хэрэгжүүлэхэд Монголбанк болон Төлбөр тооцооны үндэсний зөвлөл (ТТҮЗ) гол үүрэг гүйцэтгэсэн. Монголбанкнаас төлбөр тооцооны системүүдийн найдвартай, тогтвортой, үр ашигтай ажиллагааг хангах, бэлэн бус төлбөрийн хэрэглээг дэмжих, санхүүгийн зах зээлийн дэд бүтцийг хөгжүүлэх бодлого баримталж байна. Монгол Улсын эдийн засгийн хурдацтай өсөлтийн үр дүнд ҮТС-ийн ач холбогдол төдийгүй Монголбанкнаас төлбөрийн системийг удирдан зохицуулж, хяналт тавих чадавх сайжирсаар байна.

ҮТС-ийн Стратегид тусгах зорилтуудыг тодорхойлохдоо дэлхий нийтийн хандлага болон Монгол Улсын санхүүгийн салбарын зарим онцлогийг харгалзан үзсэн болно. Монгол Улсын эдийн засгийн тэлэлт, санхүүгийн салбарын хөгжилтэй холбоотойгоор төлбөрийн системээр дамжин хийгдэж буй гүйлгээний тоо жилээс жилд нэмэгдэж байна. Түүнчлэн цахим худалдаа хурдацтай өсөж, интернет болон гар утсыг төлбөр төлөхөд өргөнөөр ашиглаж байгаатай холбоотойгоор дараах зүйлсийг авч үзэх зайлшгүй шаардлага тулгарч байна. Үүнд: (i) олон төрлийн цахим төлбөрийн хэрэгсэл боловсруулах чадавхтай ҮТС-ийг хөгжүүлэх; (ii) Монгол Улсад цахим худалдааг хөгжүүлэх зохицуулалтыг нэвтрүүлэх; (iii) мобайл болон интернетээр хийх төлбөр, урьдчилсан төлбөрт карт зэрэг орчин үеийн төлбөрийн механизмыг дэмжих. Эдгээр сайжруулалтын арга хэмжээг авснаар нийт ҮТС-ийн үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх, Монгол Улсад цахим төлбөрийг өргөн хүрээнд нэвтрүүлэх, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах явцыг хурдасгана.

Монгол Улсын 2015-2020 оны ҮТС-ийн стратегид тусгах зорилтуудыг ҮТС-ийг хөгжүүлэх үндсэн есөн тулгуур багана болгон тодорхойлсон. (i) Хууль, эрх зүйн тогтолцоо; (ii) Их дүнтэй бөгөөд хугацааны хувьд чухал төлбөрүүдэд зориулсан төлбөр

тооцооны механизм; (iii) Жижиглэнгийн төлбөр тооцооны системүүд; (iv) Засгийн газрын төлбөрүүд; (v) Валютын арилжаа, банк хоорондын мөнгөний зах зээл; (vi) Үнэт цаасны хадгаламжийн төв, клиринг, төлбөр тооцооны зохицуулалт; (vii) Олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээ; (viii) Хяналтын тогтолцоо; (ix) Хамтын ажиллагаа. Энэхүү стратеги нь дараах өргөн хүрээ бүхий асуудлуудад төвлөрсөн байна: (i) Хууль, эрх зүйн тогтолцоог бэхжүүлэх; (ii) Үндэсний төлбөрийн системийн тогтвортой, найдвартай байдлыг сайжруулах; (iii) Цахим төлбөр, орчин үеийн төлбөрийн хэрэгслийн хэрэглээг тэлж, санхүүгийн үйлчилгээний хүртэмжийг нэмэгдүүлэх; (iv) Үнэт цаасны клиринг болон төлбөр тооцооны системийг боловсронгуй болгох; (v) ҮТС-ийн хэмжээнд үр ашигтай хяналт, хамтын ажиллагааг хөгжүүлэх.

Үндэсний төлбөрийн системийн тухай хууль, холбогдох журмуудыг боловсруулж, мөрдүүлэх замаар ҮТС-ийн хууль, эрх зүйн болон зохицуулалтын тогтолцоог бэхжүүлэх шаардлагатай. Эрх бүхий байгууллагууд болон зах зээлийн оролцогчид ойрын хугацаанд төлбөрийн системийн хууль, эрх зүйн тогтолцоог цогц байдлаар боловсронгуй болгох шаардлагатай гэж санал нэгтгэйгээр үзсэн. Одоогийн хууль, эрх зүйн болон зохицуулалтын тогтолцоо нь төлбөр тооцооны системүүдтэй холбоотой гол асуудлуудыг зохистойгоор шийдвэрлэхэд хангалттай бус байна. Үүнд дараах асуудлууд хамаарна: (i) төлбөр тооцоог эцэслэх, үр дүнгийн тооцооллыг хүлээн зөвшөөрөх, оролцогч эсхүл кастодиан төлбөрийн чадваргүй болсон нөхцөлд барьцаа хөрөнгийг хамгаалах тухай хууль, эрх зүй тодорхой байх асуудал; (ii) цахим төлбөрийн хэрэгслийн хувьд төлбөр гүйцэтгэгч ба төлбөр хүлээн авагчийн ашиг сонирхлыг хамгаалах; (iii) төлбөрийн систем, хэрэгсэл, үйлчилгээг зохицуулах, хянах Монголбанкны бүрэн эрхийн хууль, эрх зүйн үндэслэл тодорхой байх, (iv) зохицуулалтын хүрээнд орчин үеийн шинэ дэвшилтэт төлбөрийн хэрэгсэл, үйлчилгээг дэмжих. Эдгээр асуудлыг цогц байдлаар шийдвэрлэхийн тулд Үндэсний төлбөрийн системийн тухай цогц хуулийг (Багана I) батлуулах шаардлагатай юм.

Монголбанк нь нэвтрүүлсэн болон нэвтрүүлэхээр төлөвлөж буй системүүдийн эрсдэлийн удирдлагыг сайжруулах шаардлагатай. Монголбанкнаас кредит шилжүүлгийн Банксүлжээ систем (RTGS) болон бага дүнтэй төлбөр тооцооны системийг Монгол Улсад системийн хувьд нэн чухал гэж үзэж байна. Түүнчлэн санхүүгийн зах зээл дээр үйлчилгээ явуулдаг Үнэт цаасны төлбөр тооцооны систем (ҮЦТТС) болон Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв (ҮЦТХТ)-ийг олон улсын стандартын дагуу системийн хувьд чухал ач холбогдолтой гэж үздэг. Иймд эдгээр бүх систем нь эрсдэлийн удирдлагын механизмтай байх ёстой бөгөөд СЗЗДБЗ-ыг мөрдөж, системийн ажиллагааг цогц журмаар зохицуулах шаардлагатай. Хэдийгээр Монголбанкны системүүд доголдолгүй, найдвартай ажиллаж байгаа ч СЗЗДБЗ-ын дагуу хийсэн өндөр түвшний үнэлгээгээр болзошгүй эрсдэлийг удирдах асуудлаар тодорхой арга хэмжээ авч, системийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог бэхжүүлснээр уг СЗЗДБ-ийн аюулгүй, найдвартай, үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх боломжтой гэсэн дүгнэлтэд хүрсэн. Эдгээр асуудлуудыг Багана II, III, V-д тусгасан болно.

Орчин үеийн Автоматжуулсан клирингийн төвийг байгуулснаар цахим төлбөрийн хэрэгслийн хэрэглээ нэмэгдэнэ. ҮЦГТ-ийн ажиллуулж буй одоогийн бага дүнтэй төлбөр тооцооны систем нь шууд дебит болон шинэ дэвшилтэт төлбөрийн хэрэгслийн

клирингийг хийх боломжгүй. Иймээс олон төрлийн цахим төлбөрийн хэрэгслийн клирингийг хийх орчин үеийн Автоматжуулсан клирингийн төв (АКТ)-ийг байгуулж, Банксүлжээ системтэй холбох шаардлагатай юм. Одоогийн 24/7 ажиллагааг хэвээр хадгалж, эрсдэлийн удирдлагын иж бүрэн, цогц дүрмийг нэвтрүүлэх шаардлагатай. Түүнээс гадна Монголбанкнаас АКТ-ийг загварчлахдаа олон улсын стандартыг харгалзан үзэх шаардлагатай ба шинэ системийг нэвтрүүлснээр олон төрлийн цахим төлбөрийн хэрэгслийн клиринг, төлбөр тооцоог хийх баталгаатай, хурдтай, үр ашигтай механизм бий болж, иргэн, аж ахуйн нэгж болон Засгийн газрын бага дүнтэй, цахим төлбөрийн хэрэглээ нэмэгдэнэ. Монголбанкнаас шинэ системийн үйл ажиллагааны болон техникийн ажлын даалгаврыг боловсруулах ажлыг эхлүүлээд байна.

Монголбанк нь бага дүнтэй, цахим төлбөртэй холбогдсон залилантай холбоотой болон мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн удирдлагыг сайжруулах шаардлагатай юм. Үүний тулд Монголбанк өөрийн ажиллуулдаг системүүдэд тавигдах стандартыг тодорхойлж нэвтрүүлэх, салбарын шилдэг туршлагыг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Түүнчлэн Засгийн газрын цахим төлбөрийн хэрэгслийн хэрэглээг нэмэгдүүлэх шаардлагатай. Цахим төлбөр нь засгийн газрын хөтөлбөрийн зардлыг бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, цаашдын хэрэгжилтэд үр нөлөөтэй. Дэлгэрэнгүй мэдээллийг Багана III, IV-т тусгав.

Монголбанк нь Монгол Улсын хэмжээнд шинэ дэвшилтэт төлбөрийн хэрэгслийн хэрэглээг дэмжсэн санаачлагыг хэрэгжүүлэх шаардлагатай. Монгол Улсад сүүлийн таван жилийн хугацаанд бэлэн бус төлбөрийг дэмжсэн нийгэм бий болгох чиглэлд томоохон ахиц дэвшил гарсан. Бэлэн бус төлбөрт шилжих шилжилтийг улам эрчимжүүлэхийн тулд Монголбанкны зүгээс шинэ дэвшилтэт төлбөрийн зохицуулалт болон банк бус санхүүгийн байгууллага (ББСБ)-ыг дэмжсэн журмыг ҮТС-ийн тухай хууль (төсөл)-д нийцүүлэн боловсруулах шаардлагатай байна. Үүний тулд Монголбанк нь ББСБ-ыг зохицуулж байгаа СЗХ-той хамтран ажиллах ёстой. Шууд дебит, интернетээр хийх төлбөр, мобайлаар хийх төлбөр гэх мэт төлбөрийн шинэ механизмыг хөгжүүлэх, эдгээрийн дэд бүтцийг орчин үеийн АКТ, Банк хоорондын төлбөрийн картын нэгдсэн сүлжээ (КНС)-гээр нэгтгэх нь иргэн, аж ахуй нэгж, Засгийн газрын шинэ дэвшилтэт төлбөрийн хэрэгслийн хэрэглээг нэмэгдүүлэх, харилцан зохицолдоог хангах, цахим худалдааг дэмжих, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх санаачлага болох юм. Түүнчлэн Монголбанк нь: (i) ПОС төхөөрөмж зэрэг төлбөрийн картын дэд бүтцийг хөдөө орон нутагт хөгжүүлэх хөшүүргийг бий болгох; (ii) Засгийн газрын гүйлгээнд цахим төлбөрийг нэвтрүүлэх ажлыг цаашид дэмжих; (iii) иргэн, аж ахуй нэгжийн цахим төлбөрийн механизмын хэрэглээг өдөөсөн хөшүүргийг бий болгох бодлогыг дэмжих шаардлагатай. Эдгээр санаачлагыг багана III, IV-т тусгав.

Үнэт цаасны болон валютын арилжааны гүйлгээний клиринг, төлбөр тооцооны дэд бүтцийг боловсронгуй болгож, үр ашигтай, найдвартай байдлыг нэмэгдүүлэх боломжтой. Монголбанкнаас нээлттэй зах зээл, банк хоорондын репо арилжаа, Банксүлжээ системийн үйл ажиллагаатай холбоотой төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжих санхүүгийн зах зээлийн оновчтой дэд бүтцийг хөгжүүлэх ёстой. Одоогийн байдлаар үнэт цаасны гүйлгээнд Үнэт цаасны төлбөр тооцооны систем (ҮЦТТС)-ийг хариуцаж байгаа АТТ, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв (ҮЦТХТ) оролцож байна. Монголбанк

нь Төв банкны үнэт цаасны (ТБҮЦ) системийг ажиллуулж байгаа бол ҮЦТХТ нь Засгийн газрын үнэт цаасны (ЗГ-ын богино хугацаат ба урт хугацаат үнэт цаас) төлбөр тооцооны систем (ҮЦТТС) болон төвлөрсөн хадгаламжийн төв (ҮЦТХТ) болж байна.¹ Үнэт цаасны төлбөр тооцооны систем болон төвлөрсөн хадгаламжийн төвийг бүрэн автоматжуулж, үйл ажиллагааны найдвартай, баталгаат байдлыг ханган, Банксүлжээ системд бодит цагийн горимоор холбосон байхын зэрэгцээ төлбөрийн болон үнэт цаасны гүйлгээг нэгэн зэрэг гүйцэтгэх Төлбөрийн эсрэг нийлүүлэлт (DvP)-ийн зарчмаас гадна СЗЗДБ-ийн зарчимд нийцсэн эрсдэлийн удирдлагын бусад механизмуудыг бий болгох шаардлагатай юм. ТБҮЦ, Засгийн газрын үнэт цаасны клиринг, төлбөр тооцооны зохицуулалтын орчин маш тодорхой байх ёстой. Бирж дээр арилжаалагддаг үнэт цаас, ялангуяа тэдгээрийн мөнгөн хөрөнгийн клиринг, төлбөр тооцооны системийн эрсдэлийн удирдлага, үр ашигтай байдлыг бэхжүүлэх шаардлагатай. Түүнчлэн Монголбанк нь Монгол Улсын гадаад валютын зах зээл дэх валютын арилжааны төлбөр тооцооны эрсдэлийг үнэлж, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авах ёстой. Багана V, VI-д тусгав.

Монголбанк нь ҮТС-ийн хяналтын нэгдсэн тогтолцоог хөгжүүлж, хяналтын чиг үүргийг үр дүнтэй хэрэгжүүлэх оновчтой бүтэц зохион байгуулалт, чадавхыг бий болгох замаар төлбөрийн системийн хяналтыг бэхжүүлэх шаардлагатай. Монголбанк нь ҮТС-ийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлснээр ҮТС-ийн аюулгүй, найдвартай, үр ашигтай байдлыг баталгаажуулж, 2015-2020 онд хэрэгжүүлэх ҮТС-ийн шинэ Стратегийн биелэлтийг хангах боломжтой болно. Төв банкнаас тавих төлбөрийн системийн хяналтын зохицуулалтад хамаарах нийтлэг зарчмыг мөрдөх зорилгоор Монголбанкны зүгээс хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх талаар тодорхой алхмуудыг хийж эхлээд байна. Монголбанк нь төлбөрийн системийн хяналт хариуцсан Төлбөрийн бодлого, зохицуулалтын хэлтсийг байгуулж, Төлбөрийн системийн хяналтын бодлого болон бусад хэд хэдэн баримт бичгийг гаргасан. Төлбөрийн системийн хяналтын журмыг боловсруулан гаргах, хяналтын бодлогыг шинэчлэх, хяналт тавих арга хэрэгслийг боловсронгуй болгох, тогтмол үнэлгээ хийх, чадавхыг бэхжүүлэх замаар Монголбанкнаас төлбөрийн системд тавих хяналтыг улам бэхжүүлэх боломжтой. Хяналтын ерөнхий тогтолцоо нь хяналтын бодлого, зорилтуудыг дэлгэрэнгүй тодорхойлж, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчид зөвшөөрөл олгох, мэдээлэл цуглуулах, газар дээр шалгалт хийх зэрэг хяналтын үйл ажиллагааны арга хэрэгсэл, хяналт тавих журам, эрсдэлийн удирдлага, зохион байгуулалтын шаардлагатай зохицуулалтын хэрэгжилт зэргээс бүрдэнэ. Мөн хяналтын тогтолцоонд эрх бүхий бусад байгууллага (тухайлбал, СЗХ)-тай хамтран хяналт шалгалт хийх харилцаа, хамтын ажиллагааг албан ёсоор зохицуулах нь зүйтэй юм. Цаашид Монголбанк нь Төлбөрийн систем хариуцсан газрын бүтцэд Төлбөрийн системийн хяналтын хэлтсийг бий болгож, түүний үйл ажиллагаа, хариуцлага болон тайлагналын чиг үүргийг баримт бичигт тусган албажуулж, Банксүлжээ системийн үйл ажиллагаанаас тусгаарлах шаардлагатай юм. Холбогдох стратегийг VIII, IX-т нарийвчлан тусгав.

Монгол Улсын 2015-2020 онд хэрэгжүүлэх ҮТС-ийн Стратегид тусгах асуудлуудыг Хүснэгт 1-д үзүүлэв. Хүснэгтийг стратегийн гол асуудлуудын хүрээнд есөн тулгуур баганад тулгуурлан зохион байгуулав.

¹ Засгийн газрын 2014 оны 292 дугаар тогтоолоор (Засгийн газрын 2015 оны 147 дугаар тогтоолоор шинэчлэгдсэн) Монгол улсын Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төвийг төлбөр тооцооны болон төвлөрсөн хадгаламжийн төв гэсэн хоёр байгууллагад хуваах шийдвэр гарсан.

Хүснэгт 1: UTC-ийн Стратегийн тулгуур баганууд

Багана	Хэрэгжүүлэх стратеги
I. Хууль, эрх зүйн тогтолцоо	Стратеги #1: Төлбөрийн болон төлбөр тооцооны систем, төлбөрийн хэрэгсэл, төлбөрийн үйлчилгээний хууль, эрх зүйн зохицуулалтын орчинг бэхжүүлэх - Төлбөрийн болон төлбөр тооцооны систем, төлбөрийн хэрэгсэл, төлбөрийн үйлчилгээтэй холбоотой бүхий л харилцаа, асуудлыг цогц байдлаар зохицуулах Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийг нэвтрүүлэх. - Мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлэг, төлбөрийн системийн хяналт, агент банкны үйлчилгээний журам боловсруулж нэвтрүүлэх. - Шууд дебит, цахим худалдааны гүйлгээ, шинэ дэвшилтэт төлбөрийн хэрэгслүүдийг боловсруулах зохицуулалтын тогтолцоог бий болгох. БДТТС ба КНС-ний журам, үйл ажиллагааны дүрэм, системийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж эрсдэлийн удирдлага, оролцогчдод тавих шаардлага, маргаан шийдвэрлэх тухай зүйл заалтуудыг тодорхой болгох. - Төв банкны үнэт цаасны хувьд Монголбанкны ҮЦТТС ба ҮЦТХТ болж байгаа чиг үүргийг журамд тодорхой тусгах. - Засгийн газрын үнэт цаасны клиринг, төлбөр тооцоотой холбоотой зохицуулалтын орчинг шинэчлэх. - Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (AML/CFT) шаардлагыг бүх төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч болон төлбөрийн операторт таниулах.
II. Их дүнтэй бөгөөд хугацааны хувьд чухал төлбөрүүдэд зориулсан төлбөр тооцооны механизм	Стратеги #2: Банксүлжээ системийн эрсдэлийн удирдлага, үр ашгийг сайжруулах - Төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангуулах зорилгоор Монголбанкаас олгох өдрийн зээлийн шат дамжлагыг автоматжуулах. Зөвшөөрөгдсөн барьцаа хөрөнгийг үндэслэн оролцогч талуудад төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангуулах өдрийн зээлийг шууд олгох. - Жижиглэнгийн төлбөр тооцооны системүүдийн үр дүнгийн тооцооллыг баталгаатай гүйцэтгэх механизмыг нэвтрүүлэх замаар Банксүлжээ систем болон бага дүнтэй төлбөр тооцооны системийн харилцан хамаарлыг шийдвэрлэх. - Ажиллах цагийг байнга сунгаж байгаа шалтгааныг дахин анхаарч үзэх. Үйл ажиллагааны алдаа, саатлыг бууруулах санхүүгийн хөшүүргийг нэвтрүүлэх. - Банксүлжээ систем (болон жижиглэнгийн төлбөр тооцооны системүүд)-д Хэрэглэгчдийн Групп үүсгэх замаар оролцогчдын зүгээс Банксүлжээ системийн найдвартай, үр ашигтай байдлыг сайжруулах талаар санал өгөх механизмыг хөгжүүлэх. - Банксүлжээ системд зориулсан эрсдэлийн удирдлагын цогц баримт бичиг боловсруулах. - Банксүлжээ системд төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хадгалах механизм нэвтрүүлэх асуудлыг судлах (RTGS-ийн хоёрдугаар үе шат).

	Стратеги #3: Банксүлжээ системийн үйл ажиллагааны найдвартай, аюулгүй байдлыг сайжруулах • Банксүлжээ системийн Тасралтгүй ажиллагааны төлөвлөгөө (BCP)-г бэхжүүлэх. Монголбанкнаас системийн аливаа саатлын дараах нөхөн сэргээх хугацааг бууруулж, дахин эхлүүлэх, нөхөн сэргээх хэмжигдэхүйц зорилтыг тодорхойлох. • Банксүлжээ системийн тасралтгүй ажиллагааны төлөвлөгөө, гамшгийн дараах нөхөн сэргээх зохицуулалтыг тогтмол турших, туршилтыг системийн хэмжээнд жилд нэгээс доошгүй удаа хийх (бүх оролцогч талууд, холбогдсон төлбөр тооцооны бүх системийг хамруулна). • Шийдвэрлэх нөхцөлд мэдээлэл солилцох төлөвлөгөөг боловсруулж баримтжуулах, оролцогч талуудыг бүрэн хамруулах. • Банксүлжээ системийн үйл ажиллагааг хариуцсан ажилтнуудын тоог нэмэгдүүлэх талаар шаардлагатай арга хэмжээг авах.
III. Жижиглэнгийн төлбөр тооцооны системүүд	Стратеги #4: Бэлэн бус төлбөрийн хэрэгслийн хэрэглээг дэмжих. Харилцан зохицолдоо, стандартчлал, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг дэмжих. • Кредит болон шууд дебит шилжүүлгийн орчин үеийн Автоматжуулсан клирингийн төв (АКТ)-ийг нэвтрүүлэх. АКТ нь шинэ дэвшилтэт төлбөрийн хэрэгслийн клирингийг хийх чадавхтай байх. • Шинэ АКТ-д холбогдох стандартыг (тухайлбал, ISO20022) нэвтрүүлж, Банксүлжээ системд нийцүүлэх. • Монгол Улсын бүх банкинд IBAN стандартыг хэрэгжүүлэх асуудлыг авч үзэх. • Корпорациудад зориулсан гарцыг хөгжүүлэх. • Цахим худалдааны гүйлгээ, интернэтээр болон мобайлаар хийх төлбөр зэрэг шинэ дэвшилтэт төлбөрийн хэрэгслүүдийг дэмжих боломжтойгоор КНС-г сайжруулах. • Салбарын хэмжээнд зөвлөлдсөний үндсэн дээр цахим төлбөрийн механизмыг нэвтрүүлэх, жижиглэнгийн төлбөрүүдийг хүлээж авах дэд бүтцийг өргөтгөх, хөдөө орон нутагт хүрч ажиллах хөшүүрэг бий болгох арга замыг эрэлхийлэх. • ҮЦГТ-ийг Монголбанкнаас тусдаа бие даасан байгууллага хэлбэрээр зохион байгуулах боломжит гарцыг эрэлхийлэх. • Цахим төлбөрийн хэрэгслийн ашиг тусын талаарх хэрэглэгчдийн мэдлэгийг нэмэгдүүлэх. Стратеги #5: Жижиглэнгийн төлбөр тооцооны системүүдийн эрсдэлийн удирдлагыг бэхжүүлэх. • Жижиглэнгийн төлбөр тооцооны системүүдийн үйл ажиллагааны дүрэм, журмыг боловсронгуй болгох. Цэвэр дебит хязгаар тогтоох, хөрөнгийн нөөц буюу барьцаатай холбоотой зохицуулалт хийх, оролцогч талуудад цаг тухайд нь мэдээлэл хүргэх зэргээр Бага дүнтэй төлбөр тооцооны систем (БДТТС), КНС-д төлбөр тооцооны эрсдэлийг бууруулах механизм нэвтрүүлэх. • БДТТС буюу шинэ АКТ-өөр тухайн өдөр дамжсан төлбөрүүдийн үр дүнгийн тооцооллыг өдөрт нь багтаан гүйцэтгэх механизмыг нэвтрүүлэх.

	- Тасралтгүй ажиллагааны төлөвлөгөө, гамшгийн дараах нөхөн сэргээх зохицуулалтыг тогтмол шалгах, системийн оролцогчдын хамт жилд нэг удаа турших. Шийдвэрлэх нөхцөлд мэдээлэл солилцох төлөвлөгөөг боловсруулах. - Жижиглэнгийн төлбөр тооцооны системүүдийн маргаан шийдвэрлэх процессыг бэхжүүлж, нарийвчлан боловсруулах. Стратеги #6: Залилантай холбоотой болон мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн удирдлагыг сайжруулах - Монголбанкнаас жижиглэнгийн төлбөрийн хэрэгслийн мэдээллийн аюулгүй байдлын суурь стандартыг тодорхойлж, мөрдүүлэх.
IV. Засгийн газрын төлбөрүүд	Стратеги #7: Засгийн газрын гүйлгээнд цахим төлбөр нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх - Засгийн газрын төлбөрүүдэд зориулсан интернет порталыг (төрийн цахим үйлчилгээ) нэвтрүүлж, төрийн үйлчилгээний онлайн төлбөрийг өргөжүүлэх. - Засгийн газрын бүх орох, гарах төлбөрийг цахим төлбөрийн хэрэгсэлд шилжүүлэх.
V. Үнэт цаасны хадгаламжийн төв, клиринг, төлбөр тооцооны зохицуулалт	Стратеги #8: Төв банкны үнэт цаасны клиринг болон төлбөр тооцооны системийн дүрэм журмыг боловсронгуй болгох - Монголбанкны нээлттэй зах зээлийн үйл ажиллагаа, Монголбанкны өдрийн болон овернайт зээл, банк хоорондын зах зээлийг хөгжүүлэхийн тулд Төв банкны үнэт цаасны бүрэн автоматжуулсан ҮЦТТС, ҮЦТХТ-ийг бий болгох. ҮЦТТС, ҮЦТХТ-ийг Банксүлжээ системтэй бодит цагийн горимоор холбох. ҮЦТТС, ҮЦТХТ-ийг Банксүлжээ системтэй бүрэн холбон нэгтгэсэн сонголтод үнэлгээ хийх. - Төв банкны үнэт цаасны клиринг болон төлбөр тооцооны зохицуулалтын орчин, эрсдэлийн удирдлагыг боловсронгуй болгох. - Засгийн газрын үнэт цаасны репо үйл ажиллагааг бүрэн автоматжуулах. - Монголбанкны мөнгөний бодлогын хэрэгслүүд болон банк хоорондын репо арилжааг дэмжихийн тулд төв банкны үнэт цаас болон ЗГ-ын репо арилжааны ҮЦТТС/ҮЦТХТ-ийг бүрэн автоматжуулах (Стратеги #2). Стратеги #9: Бирж дээр арилжаалагдаж байгаа үнэт цаасны хувьд ҮЦТТС, ҮЦТХТ-ийн эрсдэлийн удирдлага, үр ашгийг сайжруулах - ҮЦТТХТ хуваагдсанаар бий болсон санхүүгийн зах зээлийн шинэ дэд бүтэц бүрийн бодлого, зарчим, журмыг боловсруулах (шинэ арилжааны төлбөр тооцоо ба төвлөрсөн хадгаламжийн төв). - Монголын хөрөнгийн бирж, шинээр байгуулагдсан арилжааны төлбөр тооцоо, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн мөнгөн хөрөнгийн болон үнэт цаасны клиринг, төлбөр тооцоотой холбоотой дүрэм журам, эрсдэлийн удирдлагын механизмыг нягтлан үзэж, сайжруулах. - Үндэсний төлбөрийн системийн тухай хууль болон холбогдох журам зэрэг хууль, эрх зүйн зохицуулалтын тогтолцоонд үнэт цаасны клиринг, төлбөр тооцоотой холбоотой бүхий л асуудлыг тусгасан байх.

	• ҮЦТТС, ҮЦТХТ болон Монголбанкны дүрэм, журамд биржийн бус зах зээл дээр арилжаалагдаж буй Засгийн газрын үнэт цаасны клиринг, төлбөр тооцооны талаар тодорхой тусгасан байх. • ҮЦТТС, ҮЦТХТ-ийн системийн үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын тогтолцоо ялангуяа Тасралтгүй ажиллагааны төлөвлөгөө, гамшгийн дараах нөхөн сэргээх зохицуулалтыг олон улсын жишгийн дагуу бэхжүүлэх.
VI. Валютын арилжаа, банк хоорондын мөнгөний зах зээл	Стратеги #10: Валютын арилжааны гүйлгээний клиринг, төлбөр тооцоог бүрэн автоматжуулах. Валютын арилжааны төлбөр тооцоог ТэТ (PvP) зарчмын дагуу гүйцэтгэх.
VII. Олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	Стратеги #11: Олон улсын мөнгөн гуйвуулгын үр ашигтай үйлчилгээг дэмжих • Мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлдэг банк бус болон бусад санхүүгийн байгууллагуудаас мөнгөн гуйвуулгын үйлчилгээний тухай мэдээллийг тогтмол авах орчинг бүрдүүлэх. • Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний үнэ тарифыг (илгээсэн, хүлээж авсны шимтгэл, валютын арилжааны ханш, хэрэглэгчид ногдуулах бусад хураамж, шимтгэл) нийтэд мэдээлэх замаар ил тод байдлыг сайжруулах. Гуйвуулгын үнэ тарифын мэдээллийн сан ажиллуулах. • Монгол Улс дахь мөнгөн гуйвуулгын зах зээлийн албан ёсны үнэлгээг Төлбөрийн болон зах зээлийн дэд бүтцийн хороо (ТЗЗДБХ)-Дэлхийн банкны Ерөнхий зарчмуудын дагуу хийдэг болох.
VIII. Хяналтын тогтолцоо	Стратеги #12: Монгол Улсын Үндэсний төлбөрийн системийг бүхэлд нь үр дүнтэйгээр хянах • Үндэсний төлбөрийн систем, төлбөрийн хэрэгсэл, төлбөрийн үйлчилгээ (ББСБ-ын үзүүлж буй төлбөрийн үйлчилгээг хамруулан)-г бүхэлд нь хянах Монголбанкны хууль ёсны бүрэн эрх, эрх мэдлийг ил тодоор тогтоох (Үндэсний төлбөрийн системийн тухай шинэ хуулиар тодорхойлон). • Хяналтын зорилт, хамрах хүрээ, стандарт болон арга хэрэгслийг цогц байдлаар тусгаж, хяналтын бодлогыг шинэчлэх. • Хяналтын чиг үүргийн горимыг албан ёсны болгох. Хяналт тавих арга хэрэгслийг боловсруулж, баримтжуулах. • Холбогдох системүүдийн үнэлгээг хийх удирдамж боловсруулах. Жижиглэнгийн төлбөр тооцооны системүүд болон төлбөрийн хэрэгслийн стандартыг тодорхойлох. Шинэ дэвшилтэт төлбөрийн схемийн эрсдэлийн үнэлгээний суурийг боловсруулах. • Холбогдох системүүдийн үнэлгээг СЗЗДБЗ-д нийцүүлэн тогтмол хийх. Үүнд системийн хувьд нэн чухал Банксүлжээ систем, системийн хувьд нэн чухал жижиглэнгийн төлбөр тооцооны системүүд, Төв банкны үнэт цаасны ҮЦТХТ, ҮЦТТС, түүнчлэн Засгийн газрын болон бусад үнэт цаасны ҮЦТХТ, ҮЦТТС хамаарна. • Төлбөрийн системийн хяналтын чиг үүргийг Банксүлжээ системийн үйл ажиллагаанаас албан ёсоор тусгаарласан зохион байгуулалтын оновчтой зохицуулалтыг бий болгох. • Төлбөрийн системийн хяналтын нэгжийн ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг нарийвчлан боловсруулах, чадавхыг бэхжүүлэх сургалтад хамруулах замаар хяналтын нэгжийг чадваржуулах.

	- Төлбөрийн системийн хороог Монголбанк дотор үүсгэн байгуулах талаар авч үзэх. Стратеги #13: Төв банкнаас төлбөрийн системд тавих хяналтын ил тод байдал, хариуцлагыг нэмэгдүүлэх - Төлбөрийн системийн хяналтын тайланг тогтмол нийтлэх. Энэхүү тайланг санхүүгийн тогтвортой байдлын тайлантай нэгтгэн гаргаж болно. Төлбөрийн системийн үйл ажиллагаа, төлбөрийн хэрэгслийн улирлын мэдээг нийтлэх.
IX. Хамтын ажиллагааны хамрах хүрээ	Стратеги #14: Эрх бүхий байгууллагууд болон салбарын бусад байгууллагатай хамтран ажиллах зохицуулалтыг сайжруулах - Санхүүгийн зохицуулах хороо болон холбогдох бусад байгууллагатай төлбөр тооцоотой холбоотой асуудлаар хамтран ажиллах тухай тусгасан Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулах (эсхүл, үйлчилж буй санамж бичигт нэмэлт өөрчлөлт оруулах). Монголбанк нь Санхүүгийн зохицуулах хороотой төлбөрийн систем болон төлбөр тооцооны системүүдэд хийсэн үнэлгээний үр дүнг солилцох. - ТТҮЗ-ийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, дэмжих. Бага дүнтэй төлбөр тооцоо, Банксүлжээ систем хариуцсан Ажлын хэсэг байгуулах.

II. Үндэслэл

1. Монгол Улсын санхүүгийн салбар, эдийн засгийг хөгжүүлэхэд санхүүгийн зах зээлийн найдвартай, үр ашигтай дэд бүтцийг хөгжүүлэх явдал чухал юм. Төлбөрийн, мөнгөн гуйвуулгын, үнэт цаасны төлбөр тооцооны системүүд үр ашигтай, тасралтгүй ажилласнаар иргэн, аж ахуй нэгж, байгууллага хоорондын санхүүгийн үүрэг болон мөнгөн хөрөнгийн шилжүүлэг найдвартай хийгдэх боломжтой болно. Монголбанкнаас төлбөр тооцооны системүүдийн найдвартай, тогтвортой, үр ашигтай ажиллагааг хангах, бэлэн бус төлбөрийн хэрэглээг дэмжих, санхүүгийн зах зээлийн дэд бүтцийг хөгжүүлэх бодлого баримталж байна. Монгол Улсын эдийн засгийн хурдацтай өсөлтийн үр дүнд ҮТС-ийн ач холбогдол төдийгүй Монголбанкнаас төлбөрийн системийг удирдан зохицуулж, хяналт тавих чадавх нэмэгдсээр байна.

2. Монголбанк Үндэсний төлбөрийн систем (ҮТС)-ийн шинэчлэлд гол үүрэг гүйцэтгэж ирсэн. Монголбанк төлбөрийн системийн шинэчлэлийг анх 2006 онд эхлүүлсэн. Дэлхийн банкны санхүүжилттэйгээр хэрэгжүүлсэн Санхүүгийн чадавхыг шинэчлэх төслийн хүрээнд Монголбанкны Төлбөр тооцооны төвийг² үүсгэн байгуулсан нь шинэчлэлийн анхны алхам болсон. Уг төслөөр 2006 онд кредит шилжүүлгийн цахим системийг, 2010 онд картын нэгдсэн сүлжээг тус тус нэвтрүүлсэн билээ. Эдгээр системийг нэвтрүүлснээр банк хооронд хийгдэж буй төлбөрийн аюулгүй байдлыг сайжруулж, хурдыг нэмэгдүүлэн, эрсдэлийг бууруулж чадсан. Өмнө нь их дүнтэй болон бага дүнтэй кредит шилжүүлгийг нэг системээр дамжуулан боловсруулж байсан. Монголбанк нь 2009 онд их дүнтэй бөгөөд хугацааны хувьд чухал төлбөрүүдэд зориулсан бодит цагийн нэг бүрчилсэн төлбөр тооцооны Банксүлжээ системийг нэвтрүүлсэн бөгөөд 1.0 сая төгрөгөөс дээш мөнгөн дүнтэй бүх төлбөрийг шинэ системээр дамжуулах болсон.

3. Монголбанк 2009-2014 оны Монгол Улсын Үндэсний төлбөр тооцооны стратеги (ҮТТС)-ийн ихэнх зорилтыг амжилттай хэрэгжүүлсэн. Монголбанк нь 2009 онд банкуудтай хамтран 2009-2014 онд хэрэгжүүлэх ҮТТС-ийг боловсруулсан бөгөөд Төлбөр тооцооны үндэсний зөвлөл (ТТҮЗ)-өөс уг стратегийг батлан гаргасан. ҮТТС-ийн үндсэн зорилго нь “мөнгөний эргэлтийн өсөлтийг хурдасгах, Монгол Улсын санхүүгийн зах зээлийн тогтвортой, найвартай, аюулгүй байдлыг сайжруулах” явдал байсан юм. Тухайн үед ҮТТС нь “төлбөр тооцоонд оролцогч талуудын хувьд санхүүгийн зах зээлийн найдвартай, аюулгүй байдлыг дараагийн шатанд хүргэх” асуудалд анхаарч байсан. Энэхүү ҮТТС нь төлбөр гүйцэтгэх хурдыг нэмэгдүүлэх, бэлэн мөнгөөр хийх гүйлгээг бууруулах зорилтыг агуулж байсан. 2009-2014 онд хэрэгжүүлсэн ҮТТС-ийн гол амжилт нь: Төлбөрийг бодит цагийн горимоор, нэг бүрчлэн гүйцэтгэх төлбөр тооцооны систем буюу Банксүлжээ системийг нэвтрүүлсэн; Монголбанкнаас төлбөрийн системийн талаар баримтлах бодлого болон Төлбөрийн системийн хяналтын бодлогыг тодорхойлсон; Төлбөрийн системийн оролцогч хоорондын их дүнтэй болон бага дүнтэй төлбөр тооцооны журмыг тус тус батлан гаргасан; Бага дүнтэй төлбөр тооцоотой холбоотой хийгддэг залиланг бууруулж чадсан зэрэг юм. Түүнчлэн, Монголбанк Төлбөрийн системд хяналт тавих чиг үүрэг бүхий нэгжийг бий болгосноор ҮТС-д хяналт тавих зохион байгуулалтын зохицуулалтыг нэгэн зэрэг бэхжүүлж чадсан.

² Дараа нь тус Төвийн нэрийг Үндэсний цахим гүйлгээний төв (ҮЦГТ) болгон өөрчилсөн.

4. Монголбанкнаас Монгол Улсын үндэсний төлбөрийн системийг 2015-2020 онд хөгжүүлэх Стратегийн баримт бичиг (цаашид ҮТС-ийг Хөгжүүлэх Стратеги буюу Стратеги гэх)-ийг боловсрууллаа. Монголбанкны зүгээс энэхүү Стратегийг боловсруулахад дэмжлэг үзүүлсэн Дэлхийн банкны Төлбөрийн системийн хөгжлийн групп (ТСХГ)³-д чин сэтгэлийн талархал илэрхийлж байна. Дэлхийн банкнаас Монгол Улсад үзүүлж буй Төлбөрийн системийн техник туслалцааны төслийг Санхүүгийн салбарыг шинэчлэх, бэхжүүлэх санаачлагын (FIRST) санхүүжилттэйгээр хэрэгжүүлж байгаа билээ.⁴

III. Үндэсний төлбөрийн системийн стратегийг боловсруулсан арга зүй

5. Үндэсний төлбөрийн системд төлбөр болон үнэт цаасны гүйлгээг хийх, боловсруулахтай холбоотой тухайн улсын бүхий л институцын болон дэд бүтцийн зохицуулалтын матриц хамаарна. Аливаа төлбөрийн систем нь дараах элементүүдээс бүрддэг. Үүнд: (i) Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд; (ii) Төлбөр тооцооны системийг ажиллуулдаг байгууллагууд; (iii) Хууль, эрх зүйн тогтолцоо; (iv) Дүрэм, журам, гэрээ хэлцэл; (v) Төлбөрийн хэрэгсэл; (vi) Технологийн дэд бүтэц; (vii) Клирингийн болон төлбөр тооцооны механизм; (viii) Хяналтын тогтолцоо.

6. Үндэсний төлбөрийн системийн шинэчлэлийг дараах үндсэн тулгуур багануудын хүрээнд хийдэг. Үүнд: i) Хууль, эрх зүйн зохицуулалтын хүрээ; ii) Их дүнтэй бөгөөд хугацааны хувьд чухал төлбөрүүдэд зориулсан төлбөр тооцооны механизм; iii) Жижиглэнгийн төлбөр тооцооны системүүд; iv) Засгийн газрын төлбөрүүд; v) Банк хоорондын мөнгөний зах зээл ба валютын арилжааны зах зээл; vi) Үнэт цаасны хадгаламж, клиринг, төлбөр тооцооны зохицуулалт; vii) Олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээ; viii) Хяналтын тогтолцоо; ix) Хамтын ажиллагаа.

7. Дэлхийн банкны туршлагаас харахад ҮТС-ийн шинэчлэлийг дараах гурван шат дарааллыг үргэлжлүүлэн давтах байдлаар хэрэгжүүлдэг. Үүнд: (i) Нөхцөл байдлын үнэлгээ хийх; (ii) Үндэсний төлбөрийн системийн стратеги, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулах: нөхцөл байдлын үнэлгээг хийх явцад илэрсэн асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн зорилтуудыг эрэмбэ дараалалтайгаар төлөвлөж, тэдгээрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг авах шаардлагатай оролцогч талуудын жагсаалтыг гаргах; (iii) Үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэх төлөвлөгөөг хэрэгжүүлэх, хяналт шинжилгээ хийх явц. Энэ утгаараа одоогийн ҮТС-ийг хөгжүүлэх Стратегийг Үндэсний төлбөрийн системийг шинэчлэх 2 дугаар үе шат гэж үзэж болох юм. 1 дүгээр үе шат дуусгавар болсон бөгөөд 2 дугаар үе шатанд оруулах шаардлагатай стратегийн элементүүдийг энэхүү баримт бичигт тусгасан болно.

1 дүгээр үе шат: Нөхцөл байдлын үнэлгээ

Үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэх хөтөлбөрийн хувьд нөхцөл байдлын үнэлгээ хийх нь нэн чухал эхний алхам болдог. Энэ шатанд холбогдох мэдээллийг цуглуулж, төлбөрийн системийн одоо байгаа нөхцөл байдлын үнэлгээг олон улсын жишиг, шилдэг

³ ТСХГ нь Дэлхийн банкны группийн Санхүү, зах зээлийн дэлхийн практикийн бүрэлдэхүүнд хамаардаг.

⁴ FIRST буюу Санхүүгийн салбарыг шинэчлэх, бэхжүүлэх санаачлага.

туршлагатай харьцуулан хийдэг. Монгол Улсын хувьд Банксүлжээ систем, ҮЦТХТ-ийн төвлөрсөн хадгаламжийн төв, төлбөр тооцооны систем болон Төв банкны үнэт цаасны зохицуулалт зэрэг санхүүгийн зах зээлийн нэн чухал дэд бүтцийг үнэлэхэд ТТСХ⁵-ҮЦХОУБ-аас гаргасан СЗЗДБЗ-ыг ашиглаж ирсэн (Хавсралт 2-ыг харна уу).⁶ Жижиглэнгийн төлбөр болон Засгийн газрын төлбөрийн хувьд олон улсын шилдэг туршлагыг тусгасан зөвлөмжийг Дэлхийн банкнаас 2012 онд боловсруулан нийтэлсэн. Дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 3-аас харна уу. Олон улсын мөнгөн гуйвуулгын үнэлгээг хийхэд Олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээний тухай ТТСХ-Дэлхийн банкны гаргасан Ерөнхий зарчмыг баримталсан (Хавсралт 4-ийг харна уу). Төлбөрийн системийн хяналтын хувьд Үндэсний төлбөрийн системд Төв банкнаас хяналт тавих тухай ТТСХ-ны тайлан болон СЗЗДБЗ-д тусгасан эрх бүхий байгууллагуудын таван үүрэг хариуцлагыг баримталж ирсэн (Хавсралт 2, Хавсралт 5). Үндэсний төлбөрийн системийн стратегид санал оруулахдаа ТТСХ-ноос 2006 онд гаргасан Үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэх ерөнхий удирдамж болон Дэлхийн банкнаас гаргасан Жижиглэнгийн төлбөрийн цогц стратегийг хөгжүүлэх удирдамжийг баримталсан (Хавсралт 6, Хавсралт 3). Түүнчлэн Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн онцлог, санхүүгийн салбарын бүтэц, Үндэсний төлбөрийн системийн олон улсын чиг хандлагыг харгалзан үзэж үнэлгээ, шинжилгээг хийсэн.

2 дугаар үе шат: ҮТС-ийг хөгжүүлэх Стратеги, төлөвлөгөөг боловсруулах

ҮТС-ийг хөгжүүлэх стратеги, шинэчлэлийн төлөвлөгөө боловсруулахад дараах үндсэн шат дарааллыг баримталдаг. Үүнд:

- ҮТС-ийн стратегийн зорилго, зорилтуудыг тодорхойлох;
- ҮТС-ийн зорилтот онцлогуудыг тодорхойлох;
- ҮТС-ийн загварыг боловсруулахад баримтлах үндсэн зарчмуудыг тодорхойлох;
- Амжилтын хүчин зүйлсийг тодорхойлох;
- Хэрэгжүүлэх стратегийг тодорхойлох;
- Тэргүүлэх зорилтууд, зорилтот хугацааг тохирох.

Эдгээр шат дараалсан алхмуудын дагуу дээр дурдсан бүхий л асуудлыг хамарч чадах, ҮТС-ийг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулдаг байна.

ҮТС-ийн шинэчлэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа өргөн хүрээний хүчин зүйлсийг авч үзэх шаардлагатай. ҮТС-ийн тогтвортой хөгжлийг хангахын тулд зах зээлийн дэд бүтэц, хууль, эрх зүйн зохицуулалтын орчин, төлбөрийн хэрэгсэл, технологи, системийн загвар, түүнчлэн төлбөрийн дэд бүтэц болон институцын зохицуулалт хоорондын олон талт харилцан хамаарал зэрэг ҮТС-ийн гол элементүүдийг тусгайлан авч үзсэн байх шаардлагатай. Системийг хөгжүүлэх санал санаачлага нь шинээр гарч ирж буй төлбөр

⁵ Төлбөр тооцооны системийн хороо (ТТСХ) нь 2014 оны 9 дүгээр сард нэрээ Төлбөрийн ба зах зээлийн дэд бүтцийн хороо (ТЗЗДБХ) болгон өөрчилсөн. ТЗЗДБХ нь Швейцарын Базел дахь Олон улсын төлбөр тооцооны банкны дэргэдэх төлбөр тооцооны системийн стандартыг тогтоодог байгууллага юм.

⁶ Төлбөр тооцооны системийн хороо (ТТСХ) болон Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага (ҮЦХОУБ)-аас боловсруулсан Санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн зарчмууд (СЗЗДБЗ)-ыг 2012 оны 4 дүгээр сард нийтэлсэн. Энэ нь СЗЗДБЗ-ын тодорхойлолт, төв банк, зах зээлийн зохицуулагч агентлагууд, Санхүүгийн зах зээлийг удирдах, хянах, зохицуулах эрх бүхий холбогдох байгууллагуудын үүрэг хариуцлагыг тусгасан тайлан.

тооцооны хэрэгцээ шаардлага, эдийн засгийн боломж бололцоон дээр тулгуурласан байж стратегийн хувьд төлөвлөгдсөн, эрэмбэлэгдсэн байх ёстой. Төлбөр тооцооны системүүдийн харилцан хамаарлыг эхлэлийн шатанд хангаж, дэд бүтцүүдийн цаашдын хөгжлийг уялдуулах ёстой. ҮТС-ийг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулах талаарх ТЗЗДБХ-ны удирдамжийг товчлон Шигтгээ 1-т тусгав.⁷

Шигтгээ 1: ТЗЗДБХ-ны Үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэх ерөнхий удирдамж

Удирдамж 3. Цогц байдлаар төлөвлөх: төлөвлөгөөг боловсруулахад Үндэсний төлбөрийн системийн үндсэн элемент тус бүрийг, түүний хөгжилд нөлөөлөх зарчмын хүчин зүйлсийг цогц байдлаар ойлгох.

Удирдамж 4. Хэрэгцээнд тулгуурлах: Үндэсний төлбөрийн системийн бүхий л хэрэглэгчдийн төлбөрийн хэрэгцээ шаардлага, эдийн засгийн чадамжийг тодорхойлж, удирдлага болгох.

Удирдамж 5. Зорилтуудыг тодорхой эрэмбэ дараалалд оруулах: Үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэхдээ стратегийн үндсэн дээр төлөвлөж, үйл ажиллагааг эрэмбэлэх.

Удирдамж 6. Хэрэгжүүлэлт хамгийн чухал нь байх: стратегийн төлөвлөгөөг үр дүнтэй хэрэгжүүлэх.

3 дугаар үе шат: Үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилт, хяналт шинжилгээний процесс

Энэхүү шатанд шаардлагатай зохион байгуулалт, санхүүгийн нөөц, хяналт шинжилгээний зохицуулалтыг хийж төлөвлөгөөг хэрэгжүүлэх аргыг сонгоно. Үүний дараагаар хэрэгжүүлэх баг (заримдаа Төслийн удирдлагын баг гэж нэрлэдэг) төлөвлөгөөг хэрэгжүүлнэ. Төлөвлөгөөний хэрэгжилт олон үе шат дамжиж, олон жил үргэлжилж болох учраас хэрэгжүүлэлтийн явц байдалд хийх хяналт шинжилгээ, үнэлгээ маш чухал юм. Үндэсний төлбөрийн системийн гүйцэтгэлийг дүгнэх шалгуур үзүүлэлтийг тодорхойлох нь хэрэгжилтийн үндсэн элемент болно. Кирасино, Гарсиа нарын боловсруулсны дагуу Дэлхийн банкнаас нийтэлсэн “Төлбөрийн системийн хөгжлийг хэмжих нь”⁸ гарчигтай нийтлэлд аливаа улс орны Үндэсний төлбөрийн системийг үнэлэх 6 шалгуур үзүүлэлтийг тусгасан байдаг. Эдгээр шалгуур үзүүлэлтүүд нь дараах чиглэлийг хамарсан байна. Үүнд:

- а. Хууль, эрх зүйн зохицуулалтын орчин;
- б. Их дүнтэй төлбөр тооцооны системийн загвар ба бодлого;
- в. Их дүнтэй төлбөр тооцооны системийн хэрэглээ;
- г. Жижиглэнгийн төлбөр тооцооны системүүдийн дэд бүтэц, бодлого;
- д. Жижиглэнгийн төлбөрийн хэрэгслийн үр өгөөж, бэлэн бус төлбөр тооцооны хэрэгслийн хэрэглээний цар хүрээ;
- е. Хяналтын чиг үүрэг.

⁷ ТТСХ-ны Үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэх тухай Ерөнхий Зөвлөмж, 2006 он.

⁸ М. Кирасино, Ж. Гарсиа, “Төлбөр тооцооны системийн хөгжлийг хэмжих нь”, Дэлхийн банк, Вашингтон, 2009 оны 1 дүгээр сар.

IV. Үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэх стратеги болон хэрэгжүүлэх төлөвлөгөө

4.1 Зорилго, зорилтууд

8. Монгол Улсын Үндэсний төлбөрийн системийн үндсэн зорилго нь мөнгөний эргэлтийг сайжруулах⁹, Монгол Улсын хэмжээнд болон хил дамнан хийгдэж буй санхүүгийн гүйлгээний төлбөр тооцоог гүйцэтгэх найдвартай, үр ашигтай дэд бүтцийг бий болгоход оршино. Монголбанк нь дараах үндсэн зорилтуудын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг. Үүнд:

- Төлбөрийг түргэн шуурхай гүйцэтгэх, найдвартай байдлыг нэмэгдүүлэх замаар гүйлгээнд оролцогч талуудын хооронд мөнгөн хөрөнгийг шилжүүлэх үр дүнтэй механизмыг бүрдүүлэх;
- Улс орны санхүүгийн тогтвортой байдал, эдийн засгийн өсөлтөд үр дүнтэй хувь нэмэр оруулахуйц системийг хөгжүүлэх;
- Цахим төлбөрийн хэрэгслийн давуу талыг ашиглах, ингэснээр бэлэн мөнгөөр хийгдэж буй гүйлгээг бууруулах;
- Системийн эрсдэл төдийгүй төлбөрийн болон үнэт цаасны төлбөр тооцооны системтэй холбоотой бусад эрсдэлийг хянах, удирдах, бууруулах, хязгаарлах арга хэмжээ авах;
- Төлбөрийн үйлчилгээг өргөн хүрээнд нэмэгдүүлж, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг дэмжих.

4.2 Үндэсний төлбөрийн системийн онцлог шинж чанарууд

9. Үндэсний төлбөрийн системд байх үндсэн шинж чанаруудыг тодорхойлохдоо бүх оролцогч талуудтай уулзалт хийж, санал нэгдсэн байх шаардлагатай бөгөөд Монгол Улсын хэмжээнд төлбөр тооцооны үйл ажиллагааг тодорхойлох бодлого, үйл ажиллагааны болон техникийн бүхий л асуудлуудыг тусгасан байна. Үндэсний төлбөрийн системийн шинж чанарт дараах зүйлс хамаарна:

- Дотоодод хийгдэж буй банк хоорондын төлбөр тооцооны үр дүнгийн тооцооллыг тухайн өдөрт нь хийж, төлбөр тооцоог эцэслэдэг байх;
- Үндэсний төлбөрийн систем нь хүртээмжтэй, үр ашигтай байх;
- Төлбөрийн, клирингийн болон төлбөр тооцооны системүүд, цахим төлбөрийн хэрэгсэл, төлбөрийн үйлчилгээний хууль, эрх зүйн орчинг бүрэн бүрдүүлсэн байх;
- Жижиглэнгийн болон бөөний төлбөр тооцоо, гадаад валютын арилжаа, хөрөнгийн зах зээл, мөнгөний зах зээлтэй холбоотой гүйлгээг хийхэд тохирох дэд системүүдийг бий болгосон байх;
- Төрөл бүрийн төлбөрийн хэрэгсэл, тэдгээрийг ашиглах сувгуудыг нэвтрүүлсэн байх;

⁹ Энд Мөнгө гэдэг үг хамгийн өргөн утгаараа орсон бөгөөд үүнд бэлэн мөнгө, төлбөрийн карт, дебит болон кредит цахим шилжүүлэг, төлбөрийн шинэ хэрэгслүүд бүгд хамаарна.

- Иргэн, аж ахуйн нэгж, Засгийн газрын төлбөр хийх хэрэгцээ шаардлагад нийцсэн, төлбөр тооцоог саадгүй, эцсийн байдлаар гүйцэтгэх боломжтой түргэн шуурхай, үр ашигтай, найдвартай цахим шийдлүүдийг бий болгосон байх;
- Төлбөр тооцооны одоогийн болон шинэ систем (платформ)-үүдийн харилцан зохицолдоог хангасан байх;
- Төлбөр тооцооны системийн оролцогчид нь төлбөр тооцооны үүргээ биелүүлэх хангалттай мөнгөн хөрөнгөтэй байх;
- Засгийн газрын төлбөрүүд нь цахим системд суурилсан байхын зэрэгцээ YTC-д бүрэн нэгдсэн байх;
- Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдийн хооронд үйлчилгээний чанар, үр ашиг, технологийн шинэчлэлтийг дэмжсэн эрүүл өрсөлдөөнтэй байх;
- YTC нь үнэт цаасны гүйлгээнд Төлбөрийн эсрэг нийлүүлэлт (ТЭН) буюу DvP, гадаад валютын арилжааны гүйлгээнд Төлбөрийн эсрэг төлбөр (ТЭТ) буюу PvP зарчмуудыг дэмждэг байх;
- YTC нь боломжит төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг оновчтой ашигладаг байх;
- YTC нь олон улсын жишиг, шилдэг туршлагыг нэвтрүүлдэг байх;
- YTC нь санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг дэмждэг байх;
- Монголбанк нь төлбөрийн систем, хэрэгслүүдийн найдвартай, үр ашигтай байдлыг хангахын тулд зохицуулах, хяналт шалгалт хийх бусад эрх бүхий байгууллагатай хамтран ажиллаж, хяналтын бүрэн эрхээ үр дүнтэй хэрэгжүүлдэг байх;
- Олон нийт нь YTC-ийн талаар мэдлэг ойлголттой байх;
- Олон улсын байгууллагуудын зүгээс YTC-ийн үр ашигтай байдлыг үнэлдэг байх.

4.3 Суурь зарчмууд

10. YTC-ийг хөгжүүлэхэд дараах суурь зарчмуудыг баримтална:

- Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх нь гагцхүү банкны эрх, үүрэг биш;
- YTC-ийн дэд бүтцийг хөгжүүлэх нь хамтын хариуцлага мөн;
- Оролцогч талууд YTC-д учруулж буй эрсдэлд хариуцлага хүлээнэ;
- Эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа, эрсдэлээс үүсэх өртөг зардлын тэнцвэрийг хадгална;
- Төв банк YTC-тэй холбоотой аливаа асуудалд аль нэг оролцогчийн төлөө бус, нийт системийн ашиг сонирхлын төлөө оролцоно;
- YTC-ийн аюулгүй, найдвартай болон тогтвортой байдлыг хангахад зохистой хяналт шаардлагатай.

4.4 Амжилтын хүчин зүйлс

11. YTC-ийн дэд бүтцийг хөгжүүлэхэд төв банк гол үүрэг гүйцэтгэх хэдий ч энэ нь төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлэгч, системийн оролцогч, төрийн байгууллагууд

зэрэг бүх оролцогч талуудын хамтын хариуцлага мөн гэдгийг ойлгох нь ҮТС-ийн стратегийг амжилттай хэрэгжүүлэхийн үндэс юм. Системийг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулахдаа зорилтуудыг эрэмбэ дараалалтайгаар тодорхой тусгаж, хэрэгжүүлэх зорилтот хугацааг товлон, хариуцах эзнээр холбогдох байгууллагуудыг оноосон байх нь амжилтын томоохон хүчин зүйлд хамаарна. Ингэхдээ ойрын, богино хугацааны, дунд хугацааны зорилтуудыг тодорхойлж, шат дараалсан аргачлалыг баримтлах нь зүйтэй. Түүнчлэн, оролцогч талууд дараах асуудлуудыг анхаарах хэрэгтэй юм. Үүнд:

- Аливаа шинэ системийг нэвтрүүлэхэд бизнесийн загвар, өртөг нөхөх бүтцийг боловсруулсан байх. Оролцогч талууд аливаа шинэчлэлийг хийх тооцоологдсон болон нэмэгдэж болзошгүй өртөг, зардлын талаар тодорхой ойлголттой байх ёстой (програм хангамж, тоног төхөөрөмж, ажиллах хүч, сургалт, зөвлөх үйлчилгээ, хяналт шинжилгээ, нэмэлт шаардлага гэх мэт);
- Тодорхой байгууллагууд болон оролцогч талуудын бүтэц, чиг үүрэг, хүлээх хариуцлага, харилцан хамаарлыг боловсруулж, хэрэгжүүлэх. Төслийн талаар тодорхой ойлголт бүхий хэрэгжүүлэх багийг бүрдүүлэх;
- Зохион байгуулалтын шаардлагатай бүтцийг бий болгох (төв банк болон бусад байгууллагууд дотор, тухайлбал, Стратегийг хэрэгжүүлэх удирдлагын нэгж). ҮТС-ийн шинэчлэлийг хэрэгжүүлэх, хяналт тавих ажилд тохирох хүний нөөцийг томилох;
- Дээд шатны удирдлагыг байнга оролцуулж, мэдээллээр хангах;
- Хэрэгжүүлэх төлөвлөгөөг тогтмол хянаж, сайжруулах.

4.5 Хэрэгжүүлэх стратеги

12. Төлбөр тооцооны одоогийн зохицуулалтыг ҮТС-ийн шинж чанаруудын төсөөлөлтэй дүйцүүлэхийн тулд Монголбанкны зүгээс эрсдэлийг бууруулах, үр ашгийг сайжруулах, орчин үеийн төлбөрийн хэрэгслүүдийн хэрэглээг дэмжих, хууль, эрх зүйн зохицуулалтын эрүүл орчин, практик, үр дүнтэй хяналтыг бий болгоход чиглэсэн хэд хэдэн стратеги, санаачлагуудыг боловсруулсан. Төв банкны манлайлал дор бүх холбогдох талууд эдгээр стратегийг хамтран хэрэгжүүлэх болно. Эдгээр стратегийг ҮТС-ийг хөгжүүлэх үндсэн 9 тулгуур багана болгон хуваасан болно.

Багана I. Хууль, эрх зүйн тогтолцоо

13. Сайн, тэнцвэртэй хууль, эрх зүйн тогтолцоо нь ҮТС-ийн оновчтой, үр ашигтай байхын үндэс гэж үздэг. ҮТС-ийн сайн боловсруулсан, тохиромжтой хууль, эрх зүйн тогтолцоог бий болгоход тухайн улс орны хууль, эрх зүйн орчин нь дараах асуудлуудыг хамарсан байх шаардлагатай: i) төлбөрийн чадваргүй байдал, талуудын хоорондын гэрээний харилцаа зэрэг асуудлуудыг шийдвэрлэхүйц өргөн хүрээг хамарсан хууль тогтоомж; ii) төлбөрийн систем болон хэрэгсэл (тухайлбал цахим гарын үсэг, үр дүнгийн тооцооллын баталгаажилт, төлбөр тооцооны эцэслэлтийг зохицуулсан эрх зүй)-д хамаарах тусгай хууль тогтоомж, зохицуулалт; iii) төлбөрийн системийн оролцогчдын хүлээн зөвшөөрсөн дүрэм, стандарт, горим; iv) бүхий л системийн үйл ажиллагаа болон үйлчилгээнд хяналт тавих төв банк болон зохицуулах бусад байгууллагын хариуцлагыг тодорхой заасан хууль тогтоомж. Эцэст нь төлбөрийн системийн хууль,

эрх зүйн тогтолцооны тогтвортой байдалд нөлөө үзүүлэхээс гадна төлбөрийн хууль, эрх зүйн ерөнхий тогтолцоотой нийцсэн байвал зохих хууль тогтоомжид дараах хуулиуд багтана: төлбөрийн хэрэгслийн ил тод, аюулгүй байдлын тухай хууль, ёс суртахууны үзэл баримтлал, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхэд чиглэсэн монополийн эсрэг хууль, хэрэглэгчийг хамгаалах тухай хууль, нууцлалын тухай хууль.

14. Төлбөрийн системд ерөнхий зорилтыг хэрэгжүүлэх хамгийн оновчтой хэрэгсэл нь хууль байдаг хэдий ч зарим тохиолдолд хяналтын чиг үүрэг бүхий байгууллагын журам нь хурдацтай өөрчлөгдөж буй орчинд хариу үйлдэл үзүүлэх үр дүнтэй арга байж болох юм. Бусад тохиолдолд оролцогчдын хоорондын тодорхой гэрээ хэлэлцээр хангалттай байж болох бөгөөд энэ тохиолдолд эдгээр гэрээ хэлэлцээрийг хэрэгжүүлэх боломжтой эсэхэд зохих ёсны мэргэжлийн үнэлгээ хийх шаардлагатай болдог. Эцэст нь төлбөрийн системд гадаад улсад үүсгэн байгуулагдсан оролцогчид байх эсхүл аливаа төлбөрийн систем хэд хэдэн валютаар эсвэл хилийн чанадад үйл ажиллагаа явуулж болох учраас ҮТС-ийн үйл ажиллагаатай холбоотой дүрэм журам, гэрээ нь хамаарал бүхий бүх улс орон дахь системийн аливаа оролцогч төлбөрийн чадваргүй болсон нөхцөлд хүчин төгөлдөр үйлчлэх боломжтой байх ёстой.

15. Монгол Улсын ҮТС-тэй холбоотой хууль, эрх зүйн үндсэн тогтолцоо нь дараах хууль, эрх зүйн актуудаас бүрдэнэ: Төв банк (Монголбанк)-ны тухай хууль, Банкны тухай хууль, Банк, эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Векселийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Хадгаламж зээлийн хоршооны тухай хууль. Холбогдох бусад баримт бичигт: Монголбанкны их болон бага дүнтэй төлбөр тооцооны журам, Төв банкны үнэт цаасны арилжааны журам болон Засгийн газрын үнэт цаасыг хоёрдогч зах зээлд арилжих журам, ҮЦТТХТ-ийн үнэт цаасны төлбөр, мөнгөн хөрөнгийн гүйлгээний журам тус тус орно.

16. Өнөөгийн хууль, эрх зүйн тогтолцоо нь төлбөр тооцооны системүүдтэй холбоотой гол асуудлуудыг шийдвэрлэж чадахгүй байна. Клиринг, төлбөр тооцооны үйл ажиллагаа, төлбөрийн хэрэгсэл, төлбөрийн үйлчилгээний зарим гол ухагдахуунуудыг ойлгомжтой тодорхойлоогүй эсвэл орхигдуулсан байна. Энэ нь төлбөрийн тодорхой хэрэгсэл, эсвэл зарим төлбөр тооцооны системийг ашиглахад хуулийн тодорхой бус байдлыг үүсгэж энэ нь системийн оролцогчдод төлбөр түргэн гүйцэтгэх чадварын болон зээлийн эрсдэл учруулж болохоор байна. Монгол Улсын төлбөрийн системийн хууль, эрх зүйн зохицуулалтын тогтолцоонд дараах дутагдлууд байна:

- Төлбөрийн системийн гол асуудал болох төлбөрийн эцэслэлт, үл буцаагдах байдал, төлбөр тооцооны системийн барьцаа хөрөнгө, олон талт үр дүнгийн тооцооллыг дампуурлын процедураас хамгаалах зэрэг асуудлууд нь системийн дүрмийн түвшинд зохицуулагдаж байгаа тул эдгээрт дампуурлын тухай, төлбөрийн чадваргүй байдлын тухай зэрэг бие даасан бусад хууль тогтоомж давуу үйлчлэх болдог.
- Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчийн төдийгүй төлбөрийн үйлчилгээний болон төлбөрийн хэрэгслийн хэрэглэгчийн эрх, үүргийг төлбөрийн цахим хэрэгсэл

бүрийн хувьд сайтар тодорхойлоогүй. Дебит болон кредит шилжүүлэг, төлбөрийн карт зэрэг төлбөрийн цахим хэрэгслүүд болон урьдчилсан төлбөрт карт, мобайлаар хийж буй төлбөр зэрэг шинэ дэвшилтэт хэрэгслүүдийг мөнгөн хэлбэрээр хийж буй төлбөртэй ижил түвшинд хамгаалж чадахгүй байна. Хуулиар тодорхой зохицуулсан төлбөрийн цорын ганц хэрэгсэл нь вексель байна.

- Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдийн өмнөөс төлбөрийн үйлчилгээг үзүүлж буй агентуудад тавигдах шаардлага тодорхой бус байна.
- Монголбанкны төлбөрийн системд хяналт тавих бүрэн эрх, хариуцлагын талаар өнөөгийн хууль, эрх зүйн тогтолцоонд тодорхой тусгаагүй. Улс орны хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй бүхий л төлбөрийн систем, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчид, төлбөрийн хэрэгсэл гаргагчдыг бүхэлд нь хянах Монголбанкны бүрэн эрх хуулинд тодорхой тусгагдаагүй.
- Одоо үйлчилж буй хууль, эрх зүйн тогтолцоонд Монголбанкнаас төлбөрийн системийн хяналтын бодлогоо хэрэгжүүлэхэд шаардлагатай хяналтын арга хэрэгслийн тухай тодорхой зүйл, заалт байхгүй.
- Одоо үйлчилж буй Монголбанкны журамд Төв банкны үнэт цаасыг хадгалах Монголбанкны чиг үүрэг, холбогдох клирингийн болон төлбөр тооцооны зохицуулалтууд нарийн тусгагдаагүй.
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх шаардлагууд нь зөвхөн банкуудад хамаарч байна.

Алсын хараа: Монгол Улсын ҮТС нь төлбөрийн болон төлбөр тооцооны зохицуулалтын эрсдэлийг бууруулж, үр ашгийг нэмэгдүүлэхүйц эрүүл, тогтвортой, тодорхой хууль, эрх зүйн орчинд ажиллана.

Хэрэгжүүлэх стратеги

Стратеги #1: Төлбөр тооцооны систем, төлбөрийн хэрэгсэл, төлбөрийн үйлчилгээний хууль эрх зүй, зохицуулалтын орчинг бэхжүүлэх

- Төлбөр тооцооны систем, төлбөрийн хэрэгсэл, төлбөрийн үйлчилгээтэй холбоотой бүхий л харилцааг цогцоор нь шийдвэрлэх Үндэсний төлбөрийн системийн тухай цогц хуулийг бий болгох.
- Мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлэг, төлбөрийн системийн хяналт, агент банкны үйлчилгээг зохицуулсан журмыг боловсруулж хэрэгжүүлэх.
- Шууд дебит, цахим худалдааны төлбөр, шинэ дэвшилтэт төлбөрийн хэрэгслүүдийн зохицуулалтын тогтолцоог бий болгох. БДТТС ба КНС-ний журам, үйл ажиллагааны дүрэм, системийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж, эрсдэлийн удирдлага, оролцогчдод тавигдах шаардлага болон маргаан шийдвэрлэх тухай зүйл заалтуудыг тодорхой зохицуулах.
- Төв банкны үнэт цаастай холбоотойгоор Монголбанкны ҮЦТТС ба ҮЦТХТ-ийн чиг үүргийг журамд тодорхой тусгах.

- Засгийн газрын үнэт цаасны клиринг, төлбөр тооцоотой холбоотой зохицуулалтын тогтолцоог шинэчлэх.
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (AML/CFT) шаардлагыг бүх төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч, төлбөрийн операторт танилцуулах.

Багана II. Их дүнтэй бөгөөд хугацааны хувьд чухал төлбөрүүдэд зориулсан төлбөр тооцооны механизм

17. Их дүнтэй бөгөөд хугацааны хувьд чухал төлбөрийн боловсруулалтыг хийж буй төлбөр тооцооны систем нь ҮТС-ийн хамгийн том бүрэлдэхүүн хэсэг юм. Ийм системийг зөв удирдаж чадаагүй тохиолдолд санхүүгийн салбарт системийн хэмжээний доголдлыг үүсгэх учраас системийн хувьд ач холбогдол бүхий төлбөрийн систем гэж тодорхойлдог. Системийн эрсдэлийг бууруулахын тулд их дүнтэй төлбөр тооцооны системийн онцлогоос хамаарч хэд хэдэн арга хэмжээг нэвтрүүлж болно. Бодит цагийн нэг бүрчилсэн төлбөр тооцооны систем буюу RTGS систем нь өдрийн турш мөнгөн хөрөнгийн шилжүүлэг нэг бүрийн эцсийн төлбөр тооцоог тасралтгүйгээр гүйцэтгэж байдаг учраас банк хоорондын төлбөр тооцооноос үүсэх системийн болон төлбөр тооцооны эрсдэлийг хязгаарлах хүчтэй механизмыг бий болгодог. Түүнчлэн RTGS систем нь мөнгөн хөрөнгө болон үнэт цаасны шилжүүлгийг нэгэн зэрэг хийх төлбөрийн эсрэг нийлүүлэлт (ТэН/DvP), мөнгөн хөрөнгийн шилжүүлгүүдийг нэгэн зэрэг хийх төлбөрийн эсрэг төлбөр (ТэТ/PvP)-ийн зарчмыг бүрдүүлснээр үнэт цаасны болон валютын арилжааны гүйлгээний төлбөр тооцооны эрсдэлийг бууруулах боломж олгодог.¹⁰ Үндсэн RTGS системийн шинэ хувилбар болох, харилцан суутгах төлбөр тооцооны системд байдаг төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хадгалах шийдэл бүхий, холимог систем гэж нэрлэгддэг системийг зарим улс орнуудад нэвтрүүлж эхлээд байна. Төлбөрүүдийн үр дүнгийн тооцооллыг тодорхой цагт тодорхойлдог системийн хувьд эрсдэлийг хянах арга хэмжээ гэдэгт хоёр талын болон олон талын хязгаар, алдагдал хуваах гэрээний хэрэгжилт, нэг буюу түүнээс дээш оролцогч төлбөрийн чадваргүй болох үед асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай барьцаа хөрөнгийг байршуулах зэрэг асуудлууд орно. Системийн хувьд ач холбогдол бүхий төлбөрийн системийн олон улсын стандартад ТЗЗДБХ-ҮЦХОУБ-аас гаргасан Санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн зарчмууд хамаарна. (Хавсралт 2-ыг харна уу).

18. Банксүлжээ нь Монгол Улсын ҮТС-ийн гол тулгуур юм. Нэг сая төгрөгөөс дээш дүнгээр хийсэн төлбөр тооцоо өмнө нь цаасан буюу бусад хэлбэрээр хийгддэг байсан бол одоо Банксүлжээ системээр дамжин цахим кредит шилжүүлгийн хэлбэрээр хийгдэх болсон. Сүүлийн 5 жилийн хугацаанд Банксүлжээ системээр хийгдсэн гүйлгээний дүн, тоо хурдацтай нэмэгдсээр байна. Энэ өсөлт нь Банксүлжээ системийн хэрэглээний өсөлтөөс гадна санхүүгийн зах зээл идэвхэжсэнийг харуулж байгаа юм. Монголбанкны БДТТС болон КНС-ний олон талт үр дүнгийн тооцооллын төлбөр тооцоог хийх зорилгоор эдгээр системүүд нь Банксүлжээ системд холбогдсон. Хөрөнгийн бирж дээр арилжаалагдсан үнэт цаасны гүйлгээний мөнгөн хөрөнгийн эцсийн төлбөр тооцоо нь Банксүлжээ системээр дамжин төлбөр тооцооны дөрвөн банкны хооронд хийгддэг. Банксүлжээ систем нь зээлийн, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын, үйл ажиллагааны эрсдэлийг удирдах олон

¹⁰ Үнэт цаасны төлбөр тооцооны системийн Төлбөрийн эсрэг нийлүүлэлтийн зарчмын тухай ТЗЗДБХ-ны тайлан, 1992.

төрлийн эрсдэлийн удирдлагын механизмтай. Тухайлбал, Монголбанкнаас системийн оролцогчид өдрийн зээл олгон төлбөр түргэн гүйцэтгэх чадварт нь дэмжлэг үзүүлж байна.

19. Монголбанкны Банксүлжээ систем нь тогтвортой, тасралтгүй ажиллаж байгаа хэдий ч анхаарал хандуулах шаардлагатай хэд хэдэн асуудал байна. Үүнд:

- БДТТС, КНС зэрэг жижиглэнгийн төлбөр тооцооны системүүдээс гадна төлбөр тооцооны банкуудаар төлбөр тооцоогоо хийлгэдэг ҮЦТТХТ-ийн олон талт үр дүнгийн тооцооллыг Банксүлжээ системд гүйцэтгэдэг. Гэвч Банксүлжээ системийн дүрэм болон бусад системийн дүрэмд аль нэг оролцогч үр дүнгийн тооцооллын төлбөр тооцооны үүргээ биелүүлэх чадваргүй болох тохиолдолд төлбөр тооцооны баталгааг хангах талаар тодорхой тусгаагүй.
- Оролцогчийн зүгээс Банксүлжээ системийн ажиллах цагийг сунгуулах хүсэлт ирүүлдэг жишиг тогтсон (сард хэд хэдэн удаа). Банксүлжээ системийн үйл ажиллагааг зохицуулдаг их дүнтэй төлбөр тооцооны журамд Монголбанк ажиллах цагийг зөвхөн “байгалийн гамшиг (үер ус, газар хөдлөлт, түймэр гэх мэт) аюулт үзэгдэл, онцгой байдал зэрэг урьдчилж таамаглаагүй явдал тохиолдсон нөхцөлд сунгана” гэж заасан боловч бодит байдал дээр ажиллах цагийг эдгээрээс өөр шалтгаанаар сунгаж байна. Оролцогч нь цаг сунгуулсны төлөө торгууль төлдөг боловч энэ нь маш бага хэмжээтэй. Монголбанкны зүгээс энэ торгуулийн хэмжээг нэмэгдүүлэх талаар авч үзэх боломжтой юм. Үүнийг төлбөрийг эрт илгээхийг дэмжсэн үнийн бодлоготой хослуулж болно. (Монголбанк үдээс өмнө хийсэн төлбөрийн шимтгэлийг багаар, өдрийн эцэс орчим хийсэн төлбөрийн шимтгэлийг өндрөөр тогтоох үнийн бүтцийг нэвтрүүлж болох юм)
- Монголбанкны өдөр дундын төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангуулах үйл ажиллагаанд гар ажиллагаа ордог. Энэ нь үйл ажиллагааны алдаа, саатлыг бий болгож болзошгүй юм.
- Банксүлжээ системд зориулсан эрсдэлийн удирдлагын цогц тогтолцоо бүрдээгүй. Монголбанкны эрсдэлийн удирдлагын ерөнхий зохицуулалтын дагуу системийн асуудлыг Монголбанкны Эрсдэлийн удирдлагын албанд тогтмол мэдээлдэг. Гэвч энэ нь үйл ажиллагаатай холбоотой тохиолдлуудад түлхүү хамаардаг бөгөөд Банксүлжээ системд хамаарах эрсдэл (тухайлбал, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын, зээлийн, төлбөр тооцооны эрсдэл)-үүд ордоггүй.
- Үйл ажиллагааны найдвартай байдал болон саатал, доголдлын дараах нөхөн сэргээлтийн түвшинг тоогоор тодорхойлж, баримтжуулаагүй. Түүнчлэн программ хангамжтай холбоотойгоор үйл ажиллагаанд доголдол үүссэн хэд хэдэн тохиолдолд системийн нийлүүлэгчийн зүгээс хариу өгөлгүй хугацаа алдаж байсан.
- Тасралтгүй ажиллагааны төлөвлөгөөг Мэдээллийн технологийн газартай хамтран жилд хоёр удаа туршдаг боловч энэ нь зөвхөн систем ба оролцогчдын хоорондын сүлжээг шалгах төдий байдаг. Тасралтгүй ажиллагааны төлөвлөгөө нь гамшгийн янз бүрийн болзошгүй нөхцөлүүдийг хангалттай хамарч чадаагүй. Түүнчлэн гамшиг болсны дараа нөөц төв рүү ажиллагааг шилжүүлэн, үйл ажиллагааг бүрэн эхлүүлэх хугацаа олон улсын стандартад зааснаас урт байна. Үүний нэг шалтгаан нь нөөц төвд бэлтгэгдсэн хүний нөөц, мэдээлэл технологийн мэргэжилтэн хангалтгүй байгаатай холбоотой. Банксүлжээ системийн бүх оролцогчдыг хамарсан, шийдвэрлэх нөхцөлд мэдээлэл

солилцох төлөвлөгөө байхгүй.

- Банксүлжээ системийн үйл ажиллагааг хариуцсан нэгжийн чадавх (ажилтнуудын тоо) хангалтгүй байна.

Алсын хараа: Монгол Улсад их дүнтэй бөгөөд хугацааны хувьд чухал төлбөрүүдэд зориулсан төлбөр тооцооны механизм нь найдвартай, үр ашигтай байхын зэрэгцээ Санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн зарчмуудыг бүрэн дагаж мөрддөг байх.

Хэрэгжүүлэх стратеги

Стратеги #2: Банксүлжээ системийн эрсдэлийн удирдлага, үр ашгийг сайжруулах

- Монголбанкнаас өдрийн зээл олгож байгаа шат дамжлагыг автоматжуулах. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварт дэмжлэг үзүүлэхийн тулд оролцогчдод боломжит барьцаа хөрөнгийг үндэслэн шууд олгох.
- Жижиглэнгийн төлбөр тооцооны системүүдийн олон талын үр дүнгийн тооцооллын төлбөр тооцоог баталгаажуулах механизмыг нэвтрүүлэх замаар Банксүлжээ систем болон жижиглэнгийн төлбөр тооцооны системүүдийн харилцан хамаарлын асуудлыг шийдвэрлэх.
- Ажиллах цагийг байнга сунгаж буй шалтгааныг дахин авч үзэх. Үйл ажиллагааны алдаа, саатлыг бууруулахад чиглэсэн санхүүгийн хөшүүргийг нэвтрүүлэх.
- Банксүлжээ систем (болон жижиглэнгийн төлбөр тооцооны системүүд)-ийн Хэрэглэгчдийн Групп үүсгэх замаар оролцогчдын зүгээс Банксүлжээ системийн найдвартай, үр ашигтай байдлыг сайжруулахад чиглэсэн санал авах механизмыг хөгжүүлэх.
- Банксүлжээ системд зориулсан эрсдэлийн удирдлагын цогц баримт бичгийг боловсруулах.
- Банксүлжээ системд төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хадгалах механизм эсвэл төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг оновчтой байлгах механизм (ажлын өдрийн туршид хийгдэж буй төлбөрүүдийн хоёр талын болон/эсвэл олон талын тооцооллыг хийх гэх мэт)-ыг нэвтрүүлэх асуудлыг судалж үзэх (RTGS системийн хоёрдугаар үе).

Стратеги #3: Банксүлжээ системийн үйл ажиллагааны аюулгүй байдал, хамгаалалтыг сайжруулах

- Банксүлжээ системийн Тасралтгүй ажиллагааны төлөвлөгөө (BCP)-г бэхжүүлэх. Монголбанкнаас системийн аливаа саатал, гэмтлийн дараах нөхөн сэргээх хугацааг багасгаж, дахин эхлүүлэх болон нөхөн сэргээх хэмжигдэхүйц зорилтыг тодорхойлох.
- Банксүлжээ системийн тасралтгүй ажиллагааны төлөвлөгөө, гамшгийн дараах нөхөн сэргээх зохицуулалтыг тогтмол туршиж, туршилтыг системийн хэмжээнд жилд нэгээс доошгүй удаа хийх (бүх оролцогч болон холбогдсон бүх төлбөр тооцооны системүүдийг хамруулан хийх).

- Шийдвэрлэх нөхцөлд мэдээлэл солилцох төлөвлөгөө боловсруулж баримтжуулах, оролцогч талуудыг бүрэн хамруулах.
- Банксүлжээ системийн үйл ажиллагааг хариуцсан ажилтнуудын тоог нэмэгдүүлэх талаар шаардлагатай арга хэмжээг авах.

Багана III. Жижиглэнгийн төлбөр тооцооны системүүд

20. Зах зээлийн эдийн засгийн үед харилцагчийн хэрэгцээг хангах олон төрлийн төлбөрийн хэрэгсэл байх нь чухал. Жижиглэнгийн гүйлгээнд найдвартай, үр ашигтай төлбөрийн хэрэгсэл, системүүдийг ашиглах нь иргэдийн дотоодын мөнгөн тэмдэгтэд итгэх итгэлийг бий болгох үндсэн суурь болдог. Түүнчлэн, төлбөрийн хэрэгслийн зохистой хэмжээний нийлүүлэлт нь эцсийн дүндээ эдийн засгийн хөгжил, өсөлтөд нөлөө үзүүлдэг. Бэлэн мөнгө буюу төлбөрийн цаасан хэрэгслээс цахим төлбөрийн хэрэгсэлд шилжиж байгаа нь эдийн засагт эерэг нөлөөтэй гэдгийг нийтээр хүлээн зөвшөөрч байна. Цахим төлбөрийн хэрэгслийн энгийн жишээ нь кредит болон дебит шилжүүлэг, төлбөрийн карт зэрэг юм. Сүүлийн жилүүдэд хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагын дагуу олон, шинэ дэвшилтэт төлбөрийн хэрэгсэл, механизм бий болсоор байна. Цахим мөнгө, интернет банк, мобайлаар хийх төлбөрүүд нь уламжлалт банкны данс эсвэл тусгай шийдэл бүхий уламжлалт бус дансыг ашиглан хувь хүмүүсийн хоорондын шилжүүлэг хийх, биллингийн буюу хэрэглээний төлбөр төлөх, энгийн орлого, зарлага хийх зэргээр төлбөрийн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж байна. Эдгээр хөгжил дэвшил нь үйлчилгээний цэгүүдийг нэмэгдүүлэх, зардал багатай бизнесийн шинэ загваруудыг нэвтрүүлэх замаар одоо байгаа төлбөрийн хэрэгслүүдийн хэрэглээг өргөжүүлэх боломжийг олгодог.

21. Жижиглэнгийн төлбөр тооцооны системүүд, хэрэгсэл, үйлчилгээний талаарх төв банкны бодлогыг олон улсын санхүүгийн байгууллагуудын хэд хэдэн баримт бичигт тусгасан байдаг. ТЗЗДБХ-ноос 2003 онд гаргасан жижиглэнгийн төлбөр тооцооны талаар төв банкуудад зориулсан бодлогын асуудлууд гэсэн тайланд энэ чиглэлээр баримтлах төв банкны бодлого, арга хэмжээний талаар сайтар авч үзсэн байдаг. Дэлхийн банкнаас гаргасан Жижиглэнгийн төлбөр тооцооны цогц стратегийг боловсруулах удирдамж болон Жижиглэнгийн төлбөр тооцооны тухай Дэлхийн банкны багц баримт бичигт жижиглэнгийн төлбөр тооцооны системүүдийг шинэчлэх талаар олон тооны зөвлөмжүүдийг тусгасан байдаг. (Хавсралт 3-ыг харна уу). ТЗЗДБХ болон Дэлхийн банкнаас 2015 онд гаргаад удаагүй байгаа “Санхүүгийн үйлчилгээний хүртээмжийн төлбөрийн асуудал” тайлан нь үүний нэг жишээ юм.

Монгол Улс дахь төлбөрийн хэрэгслийн хэрэглээ:

22. Бэлэн бус төлбөрийн хэрэгслийн хэрэглээ сүүлийн жилүүдэд тогтмол өсөж ирсэн. Дэлхийн банкны Глобал Финдекс Мэдээллийн Сангийн 2014 оны судалгаанаас харахад Монгол Улсын 15-аас дээш настай хүн амын 91.8% нь банкны данстай гэсэн байна. Энэ нь хөгжиж буй улсуудын дотор хамгийн өндөр үзүүлэлт болж байгаа бөгөөд бага дунд орлоготой улсуудын дунджаас 2 дахин өндөр үзүүлэлт юм. Банкны дансыг цалин хөлс болон төрөөс олгож буй нийгмийн халамжийн орлогыг хүлээж авах, хэрэглээний төлбөр болон татвар төлөх, мөнгөн гуйвуулга хүлээн авах, илгээхэд ашиглаж байна.

23. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагууд төлбөрийг бэлнээр, цахим кредит шилжүүлэг, дебит шилжүүлэг, төлбөрийн картаар гүйцэтгэж байна. Бэлэн бус төлбөрийн хэрэгслүүдийн дотор кредит шилжүүлэг давамгайлдаг. 2014 оны эцсийн байдлаар банк хоорондын сүлжээгээр 1.1 их наяд төгрөгийн 18.5 сая ширхэг кредит шилжүүлэг хийгдсэн байна. Төлбөрийн карт нь нийт иргэдийн хувьд чухал төлбөрийн хэрэгсэл болж байна. 2014 оны төлбөрийн картын тоог хүн амын тоонд харьцуулсан харьцаа 1.24 болсон. АТМ, ПОС төхөөрөмжийн сүлжээ өргөжихийн хэрээр төлбөрийн карт хөдөө орон нутагт хурдацтай нэвтэрч байна. 2013 оны эцсийн байдлаар нийт 3.46 сая төлбөрийн карт гаргасны 1.1 саяыг нь орон нутгийн иргэд эзэмшиж байсан. АТМ, ПОС төхөөрөмжийн 23% орчим нь хөдөө орон нутагт байна.

24. Шинэ дэвшилтэт төлбөрийн хэрэгсэл болон хандалтын сувгаар дамжуулан үзүүлж буй үйлчилгээнүүдийн дотроос интернет банкны үйлчилгээ хамгийн хурдацтай хөгжиж байна. Интернет банкны хэрэглэгчдийн тоо 2014 онд 662,000 хүрсэн. Үүний зэрэгцээ 2014 онд мобайл банкны хэрэглэгчдийн тоо гурав дахин өсөж, 1.06 саяд хүрсэн байна. Гэвч эдгээр үйлчилгээнүүд орон нутагт бага нэвтэрсэн. Монгол улсад урьдчилсан төлбөрт карт болон цахим мөнгийг хэрэглэх хүрээ болон хэрэглээ хязгаарлагдмал байна.

25. Төлбөрийн хэрэгсэлтэй холбоотой дараах асуудлууд илэрсэн. Үүнд:

- Хөдөө орон нутагт бэлэн бус төлбөрийн хэрэгсэл болон төлбөрийн үйлчилгээний нэр төрөл нэмэгдэж байгаа хэдий ч хувь хүмүүс жижиглэнгийн төлбөр тооцоонд бэлэн мөнгө ашиглахыг илүүд үзсэн хэвээр байна.
- Төлбөрийн картаар хийгдсэн гүйлгээний зонхилох хэсгийг бэлэн мөнгө авах гүйлгээ эзэлж байна.
- Интернет, мобайл банкны үйлчилгээ орон нутагт хангалттай нэвтрээгүй байна.
- Монголбанкны баримт мэдээнд дурдсанаар залилан, луйврын гүйлгээ сүүлийн жилүүдэд буурсан үзүүлэлттэй (жишээлбэл, төлбөрийн картаар хийгдсэн төлбөр) байгаа боловч цаашид нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн стандартуудыг хэрэгжүүлэх, шилдэг туршлагад нийцүүлэх замаар жижиглэнгийн төлбөр тооцооны мэдээллийн аюулгүй байдлыг хангах, залилан, луйвраас хамгаалахад нэмэлт хүчин чармайлт шаардлагатай. Тухайлбал, EMV стандарт эсвэл интернетийн аюулгүй байдлын стандартыг дурдаж болно.
- Монгол Улсад IBAN стандартыг хараахан нэвтрүүлээгүй байна.

Монгол Улсын жижиглэнгийн төлбөр тооцооны системүүд:

26. Монголбанк нь жижиглэнгийн төлбөр тооцооны үндсэн дэд бүтцийг бий болгосон бөгөөд банкууд харилцагчдадаа цахим төлбөрийн үйлчилгээ үзүүлэх өөрсдийн дотоод системийг хөгжүүлсэн. Монголбанкны Үндэсний цахим гүйлгээний төв (ҮЦГТ) нь цахим кредит шилжүүлгийн Бага дүнтэй төлбөр тооцооны систем (БДТТС) болон Төлбөрийн картын нэгдсэн свитч буюу КНС-г ажиллуулдаг. Уг хоёр системийн гол онцлог нь төлбөрийн мэдээг 24/7 хуваариар тасралтгүй боловсруулдаг ба үр дүнгийн тооцооллын эцсийн төлбөр тооцоо нь дараагийн ажлын өдөр Банксүлжээ систем дээр хийгддэг. ҮЦГТ

нь 2014 онд 61,847 (ойролцоогоор 34 ам.доллар) төгрөгийн дундаж дүнтэй, нийт 18.5 сая ширхэг кредит шилжүүлгийн боловсруулалтыг хийсэн байна. БДТТС-ийн гишүүнчлэлд зөвхөн банкууд, Монголбанк, Сангийн яамны Төрийн сан, ҮЦТТТХТ ордог. Уг системд ББСБ, Хадгаламж зээлийн хоршоо (ХЗХ), брокер-дилерийн компаниуд банкаар дамжуулан шууд бусаар холбогдох боломжтой. КНС-ний оролцогчид нь зөвхөн банкууд байна.

27. Жижиглэнгийн төлбөр тооцооны дэд бүтэц нь тогтвортой, доголдолгүй ажилладаг хэдий ч үйлчилгээний хүрээ хязгаарлагдмал байгаагаас гадна эрсдэлийн удирдлагын зарим чухал элементүүд дутагдалтай байна. Энд дараах асуудлууд илэрсэн:

- БДТТС нь зөвхөн кредит шилжүүлгийн клирингийг хийдэг. Тус систем нь хэрэглээний төлбөр төлөх гэх зэрэг шууд дебит төлбөр болон шинэ дэвшилтэт төлбөрийн хэрэгслийг боловсруулж чаддаггүй. Олон банкууд шууд дебит төлбөрийн үйлчилгээг нэвтрүүлж эхэлсэн боловч зөвхөн банк дотроо хийж байна. Төлбөрийн хэрэгслийн өргөн хүрээний боловсруулалтыг хийх шаардлага нэмэгдэж байгаатай холбоотойгоор Монголбанк нь орчин үеийн шинэ АКТ (ACH)-ийг нэвтрүүлэх асуудлыг судалж байна.
- БДТТС-ийн дүрэмд үүргээ биелүүлэх боломжгүй болсон оролцогчдод торгууль ногдуулж, хариуцлага хүлээлгэхээс өөрөөр оролцогч хоорондын төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэл болон эрсдэлийн нөлөөллийг удирдах талаар тодорхой зохицуулалт байхгүй. БДТТС нь Тодорхой цагийн үр дүнгийн тооцооны систем юм. Систем гүйлгээг 24/7 хуваариар тасралтгүй боловсруулдаг бөгөөд хүлээн авагч банк нь ҮЦГТ-ээс боловсруулалт хийх төлбөрийн мессежийг хүлээж авсан даруй төлбөр хүлээн авч буй харилцагчийн дансанд төлбөрийг оруулдаг. Гэхдээ дараагийн өдөр оролцогчдын олон талын харилцан суутгах үр дүнгийн тооцоолол Банксүлжээ системд хийгдэх хүртэл төлбөр эцсийн болдоггүй. Энэ нь системийн оролцогчдод зээлийн болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэлийг учруулдаг. Системд эрсдэлийг хянах механизм байхгүй тохиолдолд цэвэр дебит позицтой нэг оролцогч нь төлөх боломжгүй болох үед клирингийн бүхэл бүтэн мөчлөгийг хойшлуулах эсвэл үр дүнгийн тооцооллыг буцаах эрсдэл үүснэ. Одоогоор оролцогчийн төлбөр түргэн гүйцэтгэх чадварын дутагдалд дэмжлэг үзүүлэхтэй холбоотой системд байгаа цорын ганц механизм зөвхөн Банксүлжээ системд байдаг. Энэ нь банкуудын зайлшгүй байх нөөцийг хангуулах зорилгоор Монголбанкинд байршуулдаг нөөц болон Монголбанкнаас олгодог өдөр дундын төлбөр түргэн гүйцэтгэх чадварт зориулсан зээл юм (Сүүлийнхийг нь барьцаа хөрөнгөд үндэслэн Монголбанкны саналаар олгодог). Үүнээс гадна банкууд банк хоорондын репо захаас зээл авах боломжтой. Оролцогч нь саатал, алдаа гаргах, хангалттай бус хэмжээний мөнгөн хөрөнгөтэй байх тохиолдлуудад системийн операторын зүгээс оролцогчид хариуцлага ногдуулж болно. Монголбанкны “Банк хоорондын бага дүнтэй төлбөр тооцооны журам”-д үүргээ биелүүлээгүй банк, буруутай ажилтан нь бүх хариуцлагыг хүлээж, учирсан торгуулийг төлөхөөр заасан. Гэвч уг заалтыг дүрэмд тодорхой тусгаагүй бөгөөд ямар ч тохиолдолд төлбөр тооцооны баталгааг хангаж чадахгүй юм.

- БДТТС-ийн нэгэн адил КНС-нд үүргээ биелүүлэх боломжгүй болсон оролцогчдын эрсдэлийг удирдах тодорхой механизм байхгүй.
- Оролцогчид нь байгаа мэдээллийг төлбөр түргэн гүйцэтгэх чадвараа удирдах зорилгодоо хангалттай ашигладаггүй. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын хэрэгцээгээ удирдахын тулд оролцогч нь БДТТС систем болон бусад клирингийн системүүдээс үүсэх цэвэр дебит позицийг урьдчилан мэдэж байх ёстой. Одоо байгаа практикаар ҮЦГТ нь 00:00 цагт гүйлгээ дамжуулах өдөр өндөрлөсний дараа олон талын үр дүнгийн тооцооллыг тооцоолдог бөгөөд оролцогчид дараагийн өдрийн 9:00-11:00 цагийн хооронд ҮЦГТ-ийн оператортой төлбөр тооцооны дүнг тохируулдаг. Дүрэмд төлбөр түргэн гүйцэтгэх чадваргүй болсон оролцогчид төлбөр түргэн гүйцэтгэх чадвараа хангах нэмэлт хугацаа олгох талаар тусгаагүй. Үүнээс гадна оролцогч нь 11:00 цагаас өмнө төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангах хангалттай хөрөнгө байгаа эсэхийг баталгаажуулж шалгадаггүй. Харин оролцогчид БДТТС-ийн позицийн төлбөр тооцооны үр дүнг шалгадаг байна.
- Бага дүнтэй төлбөр тооцооны систем ба КНС-ний үйл ажиллагааны дүрэм, журамд маргаан шийдвэрлэх тухай нарийвчилсан зохицуулалт байхгүй.
- ҮЦГТ нь Гамшгийн дараа нөхөн сэргээх хоёр нөөц төв, харилцаа холбооны нөөц шугам, онц чухал мэдээллийг давтамжтайгаар нөөцлөх горим, тасралтгүй ажиллагааны төлөвлөгөө зэргийг нэвтрүүлсэн боловч эдгээрийг тогтсон хуваарийн дагуу туршиж шалгадаггүй. Системийн дүрэмд тасралтгүй ажиллагааны төлөвлөгөөг жилд нэг удаа туршина гэж заасан. Гэвч уг туршилт нь зөвхөн холболтын хэмжээнд хийгддэг байна. Тасралтгүй ажиллагааны төлөвлөгөө болон Гамшгийн дараа нөхөн сэргээх нөөц төвтэй холбох туршилтыг бүх оролцогчдыг хамруулан хийж байгаагүй. Цаашлаад, нөөц төвийн системийн программ хангамж, тоног төхөөрөмжийг банкуудын зүгээс хоцрогдсон гэж үзэж байна.

Алсын хараа: Монгол Улсын жижиглэнгийн төлбөр тооцооны системүүд нь үр ашигтай, найдвартай бөгөөд олон төрлийн төлбөрийн хэрэгсэл болон үйлчилгээг дэмжиж чадахуйц, харилцан зохицолдоо сайтай байх.

Хэрэгжүүлэх стратеги

Стратеги #4: Бэлэн бус төлбөрийн хэрэгслийн хэрэглээг дэмжих. Харилцан зохицолдоо, стандартчлал, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг дэмжих.

- Кредит болон шууд дебит шилжүүлэгт зориулсан орчин үеийн АКТ (ACH)-ийг нэвтрүүлэх. АКТ нь шинэ дэвшилтэт төлбөрийн хэрэгслийн клирингийг хийх чадвартай байх.
- Шинэ АКТ нь холбогдох стандартыг (тухайлбал, ISO20022) мөрдөж, Банксүлжээ системд зохицсон байх.
- Монгол Улсын бүх банкуудад IBAN стандартыг нэвтрүүлэх асуудлыг авч үзэх.
- Корпорацид зориулсан гарц бий болгох.
- КНС-г сайжруулан, цахим худалдааны гүйлгээ, интернэт болон мобайлаар хийх төлбөр зэрэг шинэ дэвшилтэт төлбөрийн хэрэгслүүдийг дэмжих.

- Зөвлөлдсөний үндсэн дээр цахим төлбөрийн механизмыг дэмжих, жижиглэнгийн төлбөрийг хүлээж авах дэд бүтцийг өргөтгөх, хөдөө орон нутагт нэвтрүүлэх хөшүүрэг бий болгох арга замыг судлах.
- ҮЦГТ-ийг Монголбанкнаас тусгаарлан, бие даасан байгууллага хэлбэрээр зохион байгуулах боломжийг судлах.
- Хэрэглэгчдийн цахим төлбөрийн хэрэгслийн ашиг тусын талаарх мэдлэгийг сайжруулах.

Стратеги #5: Жижиглэнгийн төлбөр тооцооны системүүдийн эрсдэлийн удирдлагыг бэхжүүлэх

- Жижиглэнгийн төлбөр тооцооны системүүдийн үйл ажиллагааны дүрэм, журмыг боловсронгуй болгох. Цэвэр дебит хязгаар тогтоох, хөрөнгийн нөөц буюу барьцаатай холбоотой зохицуулалт хийх, оролцогчдыг цаг үеийн мэдээллээр хангах зэргээр БДТТС, КНС-ний төлбөр тооцооны эрсдэлийг бууруулах механизм нэвтрүүлэх.
- Тухайн өдөр дамжсан төлбөрийн үр дүнгийн тооцооллыг өдөрт нь багтаан гүйцэтгэх механизмыг БДТТС буюу шинэ АКТ дээр нэвтрүүлэх.
- Тасралтгүй ажиллагааны төлөвлөгөө, гамшгийн дараах нөхөн сэргээх зохицуулалтыг тогтмол турших, системийн оролцогчидтой хамтарсан туршилтыг жилд нэг удаа хийх. Шийдвэрлэх нөхцөлд мэдээлэл солилцох төлөвлөгөө боловсруулах.
- Жижиглэнгийн төлбөр тооцооны системүүдийн маргаан шийдвэрлэх процессыг боловсронгуй болгох.

Стратеги #6: Залилантай холбоотой болон мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн удирдлагыг сайжруулах

- Монголбанкнаас төлбөрийн хэрэгслүүдэд зориулсан мэдээллийн аюулгүй байдлын суурь стандартыг тодорхойлж, мөрдүүлэх.

Багана IV. Засгийн газрын төлбөрүүд

28. Бүх улс оронд төрийн сектор нь Үндэсний төлбөрийн системийнхээ томоохон хэрэглэгч болж байдаг. Засгийн газар олон тооны төлбөр (татвар, цалин хөлс, бараа үйлчилгээний худалдан авалт гэх мэт) хийж, бас хүлээж авч байдаг. Засгийн газрын төлбөрийн хэмжээ, далайц, ач холбогдол нь улс орны жижиглэнгийн төлбөр тооцооны дэд бүтцийг хөгжүүлэх, шинэчлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Засгийн газрын төлбөрүүдэд цахим төлбөрийн хэрэгсэл ашигласнаар үндэсний эдийн засгийн бүхий л түвшинд зардлыг ихээхэн хэмжээгээр бууруулах боломжийг олгодог. Засгийн газрын төлбөрүүд нь бэлэн бус цахим төлбөрийн хэрэгслийг банкнаас гадуур хүрээнд тэлэх замаар санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх боломжтой. Гэвч олон улс оронд төлбөрийн хэрэгслийг үр ашигтай ашиглах тал дээр төрийн сектор нь хувийн секторын ард хоцорч, банкны салбартай үр ашигтайгаар хамтарч чадаагүй байдаг. Сүүлийн жилүүдэд энэ асуудалд илүү их анхаарал хандуулах болсон бөгөөд зарим улс орны Засгийн газар өнөө

үеийн төлбөрийн дэд бүтэц (ACH, RTGS, уламжлалт картын төлбөрүүд) болон шинэ технологи (урьдчилсан төлбөрт карт)-ийг үр ашигтайгаар хэрэглэх болсон. Дэлхийн банкнаас 2012 онд гаргасан Засгийн газрын төлбөрийн хөтөлбөрийг хөгжүүлэх Ерөнхий удирдамжид олон улсын шилдэг туршлагад суурилсан хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдах өргөн хүрээтэй аргачлалыг тусгасан.

29. Монгол Улсын Засгийн газрын төлбөр тооцоо нь ерөнхийдөө цахим төлбөрт суурилсан бөгөөд одоо байгаа цахим төлбөрийн дэд бүтцийг сайн ашиглаж байна. Төрийн албан хаагчдын цалин, тэтгэвэр, нийгмийн халамжийн мөнгийг БДТТС-ээр дамжуулан банкны дансанд шилжүүлдэг. Татварыг банкнаас шилжүүлэх буюу банкны салбарт очиж бэлнээр эсвэл интернет буюу мобайл банкаар дамжуулан төлөх боломжтой. Монголбанк болон Сангийн яамны Төрийн сангийн газрын зүгээс Засгийн газрын төлбөрүүд дэх бэлэн мөнгөний ашиглалтыг бууруулахын төлөө чармайн ажиллаж байна. Жишээлбэл, Монголбанк нь Засгийн газраас олгож буй хүүхдийн мөнгө, малчдын урамшууллыг БДТТС-ээр дамжуулан олгох тусгай системийг ажиллуулж байна. Гэсэн хэдий ч иргэд цалин хөлс, нийгмийн халамжийн мөнгийг АТМ-аас шууд бэлэн мөнгөөр авч, Засгийн газарт шилжүүлж буй төлбөрүүдийг ихэвчлэн банкны салбаруудаар дамжуулан бэлэн мөнгөөр хийж байна. Түүнчлэн гадаадын зээл, тусламж зэрэг Засгийн газрын төлбөрүүдийг Үндэсний төлбөрийн системээр төвлөрсөн байдлаар хийхгүй байна.

Алсын хараа: Засгийн газрын орлого, зарлагыг Монгол улсын Үндэсний төлбөрийн системд бүрэн нэгтгэсэн байх.

Хэрэгжүүлэх стратеги

Стратеги #7: Засгийн газрын гүйлгээнд цахим төлбөрийг нэвтрүүлэх ажлыг дэмжиж зохион байгуулах

- Засгийн газрын төлбөрт зориулсан интернет портал (төрийн цахим үйлчилгээ)-ыг нэвтрүүлж, төрийн үйлчилгээний онлайн төлбөрийг нэмэгдүүлэх.
- Засгийн газрын орох, гарах бүх төлбөрийг цахим төлбөрийн хэрэгсэлд шилжүүлэх.

Багана V. Үнэт цаасны хадгаламжийн төв, клиринг, төлбөр тооцооны зохицуулалт

30. Улс орны санхүүгийн салбарт үнэт цаасны зах зээл чухал үүрэг гүйцэтгэдэг. Нээлттэй зах зээлийн үйл ажиллагаагаар дамжуулан мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхэд үнэт цаас, тэр дотроо ихэвчлэн Засгийн газрын үнэт цаасыг өргөнөөр хэрэглэдэг. Түүнчлэн төлбөрийн болон бусад зорилгоор барьцаа хөрөнгийг хугацаанд нь нийлүүлэхэд үнэт цаасны төлбөр тооцооны систем чухал байдаг. Иймд, санхүүгийн зах зээлийг хөгжүүлэхэд үнэт цаасны найдвартай, үр ашигтай Санхүүгийн зах зээлийн дэд бүтэц чухал юм. ТЗЗДБХ болон ҮЦХОУБ-ын СЗЗДБЗ-д үнэт цаасны үйл ажиллагаа явуулдаг дараах дэд бүтцийг системийн хувьд чухал гэж тодорхойлсон байдаг. Үүнд Үнэт цаасны төлбөр тооцооны систем (ҮЦТТС), Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв (ҮЦТХТ), Үнэт цаасны зуучлагч (ҮЦЗ) орно.

31. Үнэт цаасны хувьд Санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн үйл ажиллагааны аюулгүй, найдвартай, тодорхой байдал нь дараах хүчин зүйлсээс хамаардаг. Үүнд: үнэт цаас болон холбогдох төлбөрийг хадгалах, шилжүүлэх, барьцаалах, зээлдүүлэх тухай хууль тогтоомж, дүрэм журам ба тэдгээрийн ил тод, хэрэгжихүйц байдал. Үнэт цаасны зах зээл, ялангуяа гадаад хөрөнгө оруулалтыг татах сонирхол бүхий хөгжиж буй зах зээлийг хөгжүүлэхэд төлбөр ба үнэт цаасны эзэмших эрхийн шилжүүлгийг эцэслэх байдал, барьцаа хөрөнгийн хууль ёсны хамгаалалт, түүнчлэн үнэт цаасны Санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн зээлийн, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын, кастодианы, төлбөр тооцооны болон системийн эрсдэлүүдийг бууруулахад чиглэсэн эрсдэлийн удирдлагын механизм хамгийн чухал хүчин зүйлс болдог. Энд үнэт цаасыг биетээр эргэлтэд оруулалгүй хөдөлгөөнгүй байлгах буюу биет бус болгох, үнэт цаасны шилжүүлгийг цахим бүртгэлийн үндсэн дээр хийх, төлбөр тооцооны богино мөчлөгтэй байх, төлбөр тооцоонд ТэН (DvP)-ийн зарчмыг хэрэгжүүлэх, зээлийг барьцаа хөрөнгөтэй байлгах, оролцогч үүргээ биелүүлж чадахгүй болох нөхцөл, маржин, хоёр талын болон олон талын зээлийн хязгаар, алдагдал хуваалцах гэрээ зэргийг удирдах зохицуулалт, тодорхой дүрэм, оролцогчдод тавих шалгуур үзүүлэлт, мөнгөн хөрөнгөөр хийх төлбөр тооцоонд эрсдэл багатай хөрөнгийг хэрэглэх (төв банкин дахь мөнгөн хөрөнгийг давуу ашиглах), Санхүүгийн зах зээлийн дэд бүтцийг сэргээх болон шийдвэр гаргахад шаардлагатай эх үүсвэрийн хуваарилалт, зохицуулалтын тодорхой дүрэм зэрэг хамаарна.

32. Хууль, эрх зүйн зохицуулалтын тогтолцоонд үнэт цаасны клиринг, төлбөр тооцооны дэд бүтцийг зохицуулах, хяналт тавих, шалгалт хийхтэй холбоотой үүрэг хариуцлагын хуваарилалтыг тодорхой тусгах явдал чухал юм. ТЗЗДБХ болон ҮЦХОУБ-аас гаргасан СЗЗДБЗ-д үнэт цаасны гүйлгээний клиринг, төлбөр тооцоонд зориулсан Санхүүгийн зах зээлийн дэд бүтцийг хянах, зохицуулах, шалгах эрх бүхий байгууллагуудын үүрэг хариуцлагыг тодорхойлсон байдаг. Энэ чиг үүрэг нь үнэт цаасны зах зээлийн ерөнхий зохицуулалтын болон хяналт шалгалтын чиг үүргийн нэгэн хэсэг болж байдаг ч клиринг, төлбөр тооцооны зохицуулалтад тусгайлан анхаарал хандуулдаггүй. Тиймээс клирингийн болон төлбөр тооцооны зохицуулалтыг тогтмол хянах, тэдгээрийг СЗЗДБЗ-тай нийцэж буй эсэхэд үнэлэх асуудлуудыг хууль, эрх зүйн хүрээнд тодорхой тусгах нь чухал юм.

33. Үнэт цаасны зохицуулагч байгууллага нь системийн операторуудын мөрдвөл зохих зөвлөмжийг гаргах эрхтэй байх ёстой. Зохицуулагч байгууллага (тухайлбал, үнэт цаасны хороо) нь ҮЦТХТ, Клирингийн төв, Хөрөнгийн бирж зэрэг өөрийгөө зохицуулагч байгууллага (ӨЗБ)-ыг зохицуулж, хяналт тавьж байдаг улс орнуудын хувьд ӨЗБ-ууд нь оролцогчидтойгоо ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг ч зохицуулагч байгууллагын зүгээс тухайн ҮЦТХТ, Клирингийн төв, Хөрөнгийн биржид ӨЗБ-ын тусгай зөвшөөрөл олгох бүрэн эрхтэй байх бөгөөд тэдгээрийн дүрэм, журмыг нь хянаж, батлах ёстой. Системийн оператор нь ӨЗБ болохын хувьд дүрэм журам боловсруулж, оролцогчдодоо мөрдүүлэх эрхтэй байх ёстой. Түүнээс гадна ӨЗБ-аас гаргасан дүрэм журам нь системийн тогтвортой, үр ашигтай ажиллагааг хангаж, зах зээлийн бүх оролцогчдод тэгш, шударга нөхцөлийг олгож байгаа эсэхийг үнэт цаасны зохицуулагч хянаж байх ёстой. Үнэт цаасны зохицуулагч нь тодорхой давтамжтайгаар шалгалт хийх, мэдээлэл цуглуулах, үнэт цаасны хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах эрх мэдэлтэй байх ёстой. Үнэт цаасны зах зээлийн зохицуулагч, Төв банк, холбогдох бусад эрх бүхий байгууллагуудын хоорондын

хамтын ажиллагаа нь, энд ялангуяа Төв банкны ажиллуулж буй ҮЦТХТ, ҮЦТТС болон үнэт цаасны гүйлгээтэй холбоотой мөнгөн хөрөнгийн шилжүүлгийн дэд бүтэц, төлбөр тооцооны банкуудыг хамарч буй тохиолдолд, тэдгээр байгууллагуудын хувьд өөрсдийн бодлогоор тодорхойлсон зорилтдоо хүрэхэд нь чухал ач холбогдолтой байдаг.

Монгол Улсын үнэт цаасны зах зээл, клиринг, төлбөр тооцооны зохицуулалтууд:

34. Монгол Улсын үнэт цаасны зах зээл хөгжиж байгаа хэдий ч харьцангуй жижиг байна. Үнэт цаасны зах зээл дээр арилжаалагдаж буй үндсэн бүтээгдэхүүн нь Засгийн газрын үнэт цаас, Төв банкны үнэт цаас, компанийн хувьцаа, бонд байна. Бүх төрлийн үнэт цаасыг биет бус хэлбэрээр гаргаж, төвлөрсөн хадгаламжийн төвд цахим бүртгэлийн хэлбэрээр бүртгэж байна. 2014 оны эцсийн байдлаар 3.05 их наяд төгрөгийн Засгийн газрын үнэт цаас, ихэвчлэн ЗГ-ын богино хугацаат үнэт цаас, 350 тэрбум төгрөгийн Төв банкны үнэт цаас байсан. 2014 онд Монголын хөрөнгийн бирж дээрх үнэт цаасны зах зээлийн үнэлгээ 1.44 их наяд төгрөг байсан. (ДНБ-ий 7 хувьд хүрэхгүй).¹¹ Засгийн газрын үнэт цаас болон Төв банкны үнэт цаасны хоёрдогч зах зээлийн үйл ажиллагаа доогуур хэвээр байна. Хөрөнгийн биржийн зах зээл хөгжиж байгаа хэдий ч тогтвортой бус байгаагаас гадна сүүлийн 3 жил дараалан хөрөнгийн хэмжээ болон дүн буурсан үзүүлэлттэй байна.

35. Үнэт цаасны зах зээлийн клирингийн болон төлбөр тооцооны дэд бүтцийг бий болгож, хууль, эрх зүйн зохицуулалтын тогтолцоог боловсронгуй болгож байна. Монголбанк нь Төв банкны үнэт цаасны хувьд ҮЦТХТ-ийн болон ҮЦТТС-ийн үүрэг гүйцэтгэдэг. Засгийн газрын үнэт цаас, компанийн хувьцаа болон бондууд нь эдгээрийн ҮЦТТС-ийг ажиллуулдаг ҮЦТТХТ-д хадгалагддаг. ҮЦТТХТ нь биржийн бус зах зээл дээр арилжаалагдаж буй Засгийн газрын үнэт цаасны клиринг, төлбөр тооцоог давхар гүйцэтгэдэг. Засгийн газрын шийдвэрээр ҮЦТТХТ-ийг дараах 2 компани болгон хуваах тогтоол гарсан: хөрөнгийн биржээр арилжаалагддаг үнэт цаасны клирингийг хийх чиг үүрэг бүхий компани, төвлөрсөн хадгаламжийн чиг үүргийг гүйцэтгэх компани. Энэ өөрчлөлтийн гол зорилго нь үнэт цаасны гүйлгээний клирингийн болон төлбөр тооцооны эрсдэлийн удирдлагыг сайжруулахад оршино. Одоогоор Монголын хөрөнгийн бирж (МХБ) дээр арилжаалагддаг үнэт цаасны мөнгөн хөрөнгөөр хийх төлбөр тооцоог Төлбөр тооцооны 4 банк болон Монголбанкаар дамжуулан гүйцэтгэж байна. Төлбөр тооцооны мөчлөг нь зах зээлийн төрөл болон үнэт цаасны төрлөөс хамаарч Т+0-ээс Т+3 хүртэл хугацаагаар ТэН (DvP) зарчмын дагуу хийгддэг. Ихэнх арилжааны төлбөр тооцоо Т+1 хугацаагаар хийгдэж байна. Санхүүгийн зохицуулах хороо нь 2013 онд батлагдсан Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн дагуу үнэт цаасны зах зээлийг зохицуулдаг. Санхүүгийн зохицуулах хорооноос брокер-дилер, хөрөнгө оруулалтын компани, кастодиан, клирингийн төв, ҮЦТТС, ҮЦТХТ-ийн зөвшөөрлийг олгодог. МХБ болон ҮЦТТХТ нь өөрийгөө зохицуулагч байгууллага бөгөөд гишүүн байгууллагуудад мөрдүүлэх дүрэм, зөвлөмжийг гаргадаг.

¹¹ Эх сурвалж: МХБ ба Монголбанк. 2014 оны ДНБ-ний урьдчилсан дүр зураг.

36. Монгол Улсын үнэт цаасны клиринг болон төлбөр тооцооны тухай өнөөгийн зохицуулалтуудад дараах сул талууд байна:

- Төв банкны үнэт цаастай холбоотойгоор Монголбанкны гүйцэтгэж буй ҮЦТТС болон ҮЦТХТ-ийн чиг үүргийн талаарх дүрэм, журам тодорхой бус байна. ТБҮЦ-ны хувьд ҮЦТХТ/ҮЦТТС нь бүрэн автомат болоогүй.
- Төв банкны болон банк хоорондын репо арилжаанд Засгийн газрын үнэт цаасыг ашиглах үйл ажиллагааг бүрэн автоматжуулаагүй.
- Хөрөнгийн биржээр арилжаалагддаг үнэт цаасны мөнгөн хөрөнгө талын клиринг болон төлбөр тооцоо нь үр ашигтай бус.
- Хууль, эрх зүйн зохицуулалтын тогтолцоонд төлбөр тооцооны эцэслэлт болон барьцаа хөрөнгийг хамгаалахтай холбоотой асуудлуудыг тусгаагүй.
- Мэдээллийн технологийн (MIT) системийн үйл ажиллагаа, ҮЦТТТХТ буюу шинэ байгуулагдсан компаниудын эрсдэлийн удирдлага, тасралтгүй ажиллагааны төлөвлөгөөний зохицуулалтууд болон оролцогчийн үүргээ биелүүлэх боломжгүй болох нөхцөлийн удирдлагад дүн шинжилгээ хийх шаардлагатай.
- Банксүлжээ системийн үйл ажиллагааны дүрэм болон Монголбанкны овейрнайт зээлийн журмын зарим заалтууд хоорондоо зөрчилдсөн байна.

Алсын хараа: Үнэт цаасны хадгаламж, клиринг, төлбөр тооцооны систем нь аюулгүй, өндөр үр ашигтай, олон улсын стандартад нийцсэн, Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжсэн байх.

Хэрэгжүүлэх стратеги

Стратеги #8: Төв банкны үнэт цаасны клиринг, төлбөр тооцооны систем, дүрэм журмыг боловсронгуй болгох

- Монголбанкны нээлттэй захын үйл ажиллагаа, Монголбанкны өдөр дундын болон овернайт зээл, банк хоорондын захыг хөгжүүлэхийн тулд Төв банкны үнэт цаасны бүрэн автоматжуулсан ҮЦТТС, ҮЦТХТ-ийг бий болгох. ҮЦТТС/ҮЦТХТ-ийг Банксүлжээ системтэй бодит цагийн горимд холбох. ҮЦТТС/ҮЦТХТ-ийн Банксүлжээ системтэй бүрэн холбогдсон байдалд үнэлгээ хийх.
- Төв банкны үнэт цаасны клиринг, төлбөр тооцооны зохицуулалтын тогтолцоо, эрсдэлийн удирдлагыг сайжруулах.
- Засгийн газрын үнэт цаасны репо арилжааг бүрэн автоматжуулах.
- Монголбанкны байнгын хэрэгслүүд, банк хоорондын репо арилжааг дэмжихийн тулд Төв банкны үнэт цаас болон Засгийн газрын үнэт цаасны репо арилжаанд зориулагдсан ҮЦТТС/ҮЦТХТ-ийг бүрэн автоматжуулах.

Стратеги #9: Бирж дээр арилжаалагдаж байгаа үнэт цааснуудын ҮЦТТС, ҮЦТХТ-ийн эрсдэлийн удирдлага, үр ашгийг сайжруулах

- ҮЦТТТХТ хуваагдсанаар бий болсон санхүүгийн зах зээлийн шинэ дэд бүтэц нэг бүрт зориулсан бодлого, зарчим, журмыг боловсруулах (арилжааны төлбөр тооцоо

ба төвлөрсөн хадгаламжийн төв).

- Үнэт цаасны болон мөнгөн хөрөнгийн клиринг, төлбөр тооцоотой холбоотойгоор МХБ, шинээр байгуулагдах арилжааны төлбөр тооцоо, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн дүрэм журам, эрсдэлийн удирдлагын механизмыг нягтлан үзэж, сайжруулах.
- Үндэсний төлбөрийн системийн тухай хууль болон холбогдох журам зэрэг хууль, эрх зүйн зохицуулалтын тогтолцоонд үнэт цаасны клиринг, төлбөр тооцоотой холбоотой бүхий л асуудлыг тусгах.
- Арилжааны төлбөр тооцоо, ҮЦТХТ болон Монголбанкны дүрэм, журамд биржийн бус зах зээл дээр арилжаалагдаж буй Засгийн газрын үнэт цаасны клиринг, төлбөр тооцооны тухай тодорхой тусгах.
- ҮЦТТС, ҮЦТХТ-ийн системийн үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын тогтолцоо, ялангуяа Тасралтгүй ажиллагааны төлөвлөгөө, Гамшгийн дараах нөхөн сэргээх зохицуулалтыг олон улсын жишигт нийцүүлэн бэхжүүлэх.

Багана VI. Валютын арилжаа, банк хоорондын мөнгөний зах зээл

37. Мөнгөний зах зээл болон гадаад валютын арилжаа, клиринг, төлбөр тооцооны үр ашигтай механизм нь эдгээр зах зээлийг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ. Банк хоорондын мөнгөний зах зээлийг хөгжүүлэх гол элементүүд нь автоматжуулсан арилжааны платформ, мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлгийг банк хооронд цаг алдалгүй эцэслэн гүйцэтгэх, үр ашигтай их дүнтэй төлбөр тооцооны систем, автоматжуулсан ҮЦТХТ, үнэт цаасны эзэмшлийн бичилт, бүртгэлийг хийх үнэт цаасны цахим бүртгэлийн төлбөр тооцооны систем зэрэг юм. Боловсронгүй үйл ажиллагаатай мөнгөний зах зээл нь банк хоорондын хүүгийн түвшний ил тод байдлыг хангаж, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын удирдлагыг сайжруулах боломжийг бий болгон, мөнгөний бодлогыг дамжуулах механизмыг дэмждэг. ТэН (DvP) болон ТэТ (PvP)-ийн зарчимд суурилсан төлбөр тооцооны зохицуулалт нь мөнгөний зах зээл болон валютын арилжааны зах зээл дээрх төлбөр тооцооны эрсдэлийг бодитойгоор бууруулдаг.

38. Монгол Улсын гадаад валютын зах зээл дээр Монголбанк болон банкуудын хооронд хийгдэх гүйлгээ давамгайлдаг. Ийм үйл ажиллагааны зорилго нь ихэвчлэн зах зээлийн ам.доллараар илэрхийлэгдсэн төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжих, төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн тогтвортой байдлыг хадгалахад оршдог. Монголбанк нь гадаад валютын дуудлага худалдаанд зориулсан дуудлага худалдааны системийг ажиллуулж байна. Банкууд Монголбанкинд ам.долларын болон хятадын юанийн дансыг нээж, түүгээр дамжуулан төлбөр тооцоог хийдэг. Гэхдээ гадаад валютын арилжааны худалдаж авч буй валютын төлбөр тооцооны процессыг автоматжуулаагүй. Валют арилжаатай холбоотой төгрөгийн гүйлгээний төлбөр тооцоо нь Банксүлжээ системээр хийгддэг. Банкуудын хоорондоо хийж буй валютын арилжааны гүйлгээний хувьд гадаад валютаар илэрхийлэгдэх төлбөр тооцоо нь нэг бол гадаад дахь корреспондент банкаар дамжиж эсвэл Монголбанкинд байрших ам.долларын болон хятадын юанийн дансаар хийгддэг.

39. Монгол Улсын мөнгөний зах зээл, гадаад валютын арилжааны төлбөр тооцооны зах зээлд дараах асуудлууд байна.

- Мөнгөний зах зээл дээрх арилжааны төлбөр тооцоо нь ТэН (DvP) зарчмын дагуу хийгддэг боловч Банксүлжээ систем, үнэт цаасны клиринг, төлбөр тооцооны системийн тухай хэсгүүдэд тайлбарласанчлан энэ процесст гар ажиллагаа ордог.
- Монголбанк болон банкуудын хоорондын гадаад валютын арилжааны төлбөр тооцоо автоматаар хийгддэггүй. Төгрөгөөр хийх төлбөр тооцоо Банксүлжээ системээр хийгддэг бол ам.доллар эсвэл хятад юаний дансны хооронд шилжүүлэг хийхийн тулд банкууд Монголбанкинд цаасан төлбөрийн даалгавар хүргүүлэх шаардлагатай болдог.
- Банкууд хоорондын валютын арилжааны төлбөр тооцоо ТэТ (PvP) зарчмаар хийгддэггүй.

Алсын хараа: Банк хоорондын мөнгөний зах зээлийг бүрэн хөгжүүлж, төлбөр тооцооны системтэй нягт уялдуулах. Валютын арилжааны төлбөр тооцоог Төлбөрийн эсрэг төлбөр (PvP) зарчмын дагуу хийдэг болгох.

Хэрэгжүүлэх стратеги

Стратеги #10: Валютын арилжааны хэцэлийн клиринг, төлбөр тооцоог бүрэн автоматжуулах. Валютын арилжааны төлбөр тооцоог ТэТ (PvP) зарчмын дагуу хийх.

Багана VII. Олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээ

40. Дэлхий нийтийн хэмжээнд эдийн засгийн интеграцлал, улс орнуудын харилцан хамаарал, хүн амын шилжилт хөдөлгөөн нэмэгдэж байгаатай холбоотойгоор олон улсын мөнгөн гуйвуулгын ач холбогдол нэмэгдсээр байна. Гэвч, ихэвчлэн бага орлоготой ажилчид, бага дүнтэй мөнгө (ихэнхдээ нэг удаад хэдхэн зуун доллар буюу түүнээс хэтрэхгүй дүнгээр) шилжүүлдэг учраас мөнгөн гуйвуулгын үйлчилгээний шимтгэл өндөр байх талтай байдаг. Түүнчлэн тухайн улсын хэлийг мэддэггүй эсвэл шаардлагатай бичиг баримтгүй цагаачдын хувьд мөнгөн гуйвуулгын үйлчилгээ авахад хүндрэлтэй байх, нөгөө талаас санхүүгийн дэд бүтэц хөгжөөгүй улс оронд хүлээн авагч шилжүүлгийг авахад хүндрэл учрах тохиолдлууд их бий. Зарим зах зээл дээр мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өрсөлдөөн байхгүй эсвэл зохицуулалтын саад хориг байх тохиолдол бий.

41. Дэлхийн хэмжээнд мөнгөн гуйвуулгын үйлчилгээний үр ашигтай, шударга байдлыг нэмэгдүүлэх санаачлага өрнөж байна. 2007 онд Дэлхийн банкнаас ТЗЗДБХ-той хамтран Олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээний Ерөнхий зарчмуудын тухай тайлан гаргасан. (Хавсралт 4-ийг харна уу). Тухайн бүс нутгийн эрх бүхий байгууллагууд, оролцогч олон талууд, үйлчилгээ үзүүлэгчдийн үйл ажиллагааг Ерөнхий зарчмууд болон Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага буюу FATF (Financial Action Task Force)-ын Тусгай зөвлөмжийн дагуу зохицуулдаг. Их 8 болон Их 20 улсуудын зүгээс

мөнгөн гуйвуулгын үйлчилгээний дундаж өртгийг 5 жилийн хугацаанд 5%-иар бууруулах (5х5 зорилт) зорилт дэвшүүлсэн. Уг зорилтыг хэрэгжүүлснээр цагаачид болон тэдний гэр бүл жилд 16 тэрбум доллар хэмнэх боломжтой гэсэн тооцоо гарсан: Уг хөрөнгө нь цагаачдын амжиргааны түвшинг дээшлүүлэх, цагаачдын улс орны ядуурлын түвшинг бууруулахад ихээхэн хувь нэмэр оруулах боломжтой юм. Дэлхийн банкны зүгээс дэлхий даяар хийгдэж буй мөнгөн гуйвуулгын үйлчилгээний үнийн (<https://remittanceprices.worldbank.org>) веб сайтаар дамжуулан энэхүү чухал зорилтын хэрэгжилтийн явцыг хянадаг. 5х5 зорилтын хэрэгжилтийг хангахын тулд Дэлхийн банкнаас дэвшүүлсэн шилдэг туршлагын орон нутгийн түвшин дэх үр ашигтай байдлыг турших, нотлох зорилго бүхий “Project Greenback 2.0” санаачлагыг Дэлхийн банк Гэйтс сантай хамтран саяхан эхлүүлсэн.

Монгол Улсын олон улсын мөнгөн гуйвуулгын зах зээл:

42. Монгол Улс нь гадаадад ажиллаж буй иргэдээс мөнгөн гуйвуулга хүлээж авдаг төдийгүй илгээдэг улс юм. Хэдийгээр мөнгөн гуйвуулгын орох урсгал нь Монгол Улсын эдийн засагт маш бага хувь (ДНБ-ий 2%-иас ч бага) эзэлдэг боловч ойролцоогоор хүн амын 10% нь гадаадад ажиллаж, амьдарч ар гэртээ мөнгө шилжүүлдэг гэсэн тооцоо бий. Түүнчлэн, Монгол Улсад уул уурхайн салбар хөгжиж байгаатай холбоотойгоор хөрш орнуудаас ирж ажиллан, Монгол Улсаас гадагшаа чиглэсэн мөнгөн гуйвуулга хийх цагаачдын тоо нэмэгдэж байна.

43. Илгээж байгаа болон хүлээн авч буй улс орноос хамаараад олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээний үнэ хөлс харилцан адилгүй байдаг. Зарим орнуудын хувьд (БНХАУ, Япон, Өмнөд Солонгос) мөнгөн гуйвуулга илгээгч, хүлээн авагчийн зардлыг бууруулах, төлбөрийн дэд бүтцийн хөшүүргийг бий болгох (жишээ нь: төлбөрийн картын дэд бүтэц) зорилгоор тусгай зохицуулалтыг нэвтрүүлсэн байдаг. Гэтэл зарим тохиолдолд тухайлбал, олон улсын Мөнгөн гуйвуулгын операторын хувьд үйлчилгээний өртөг дэлхийн дунджаас давсан байдаг.¹² Энд банкуудтай хийсэн гэрээнд тусгай шаардлага байдаггүй. Мөнгөн гуйвуулгын хамгийн чухал асуудал нь мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өртөг хэт өндөр байгаагийн улмаас албан бус сувгийг ашиглах хандлага гардаг. Жишээ нь: АНУ-аас Монгол Улс руу мөнгө шилжүүлж байгаа байдал. Корреспондент банкаар дамжуулан данснаас данс руу мөнгө шилжүүлэх нь илүү удаанаас гадна өндөр өртөгтэй.

44. Монгол Улсад мөнгөн гуйвуулгын үйлчилгээний үнийн мэдээллийг авч байгаа яам, агентлаг байхгүй байна. Монголбанкны Зах зээлийн газар нь мөнгөн гуйвуулгын орох, гарах урсгалын статистикийн мэдээг нэгтгэдэг. СЗХ нь Олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлдэг компаниудад (“мөнгөн гуйвуулгын компаниуд” гэж нэрлэгддэг) зөвшөөрөл олгодог бөгөөд сар бүр тайлан авдаг. Гэвч эдгээр компаниуд арилжааны зорилгоор мөнгө шилжүүлдэг бөгөөд гэр бүлийн мөнгөн гуйвуулга хийдэггүй. Монголбанк эсвэл СЗХ-ноос олон улсын Мөнгөн гуйвуулгын операторыг шууд зохицуулалтаар хангадаггүй; гэхдээ Монголбанк тэдгээрийн үйл ажиллагааг банкуудаар дамжуулан хянадаг.

¹² See Remittance Prices Worldwide at <http://remittanceprices.worldbank.org>

Алсын хараа: Монгол Улсад олон улсын мөнгөн гуйвуулга болон бусад хил дамнасан төлбөр тооцоог саадгүй, түргэн шуурхай гүйцэтгэх, эцсийн хэрэглэгчийн хувьд тус үйлчилгээг өртөг зардал багатай байлгах.

Хэрэгжүүлэх стратеги

Стратеги #11: Үр ашигтай олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээг дэмжих

- Мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлдэг банк бус болон бусад санхүүгийн байгууллагуудаас мөнгөн гуйвуулгын үйлчилгээний тухай мэдээллийг тогтмол авч байх орчин бүрдүүлэх.
- Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний үнэ төлбөрийг (илгээсэн, хүлээж авсны шимтгэл, валютын арилжааны ханш, хэрэглэгчид ногдох бусад зардлыг оролцуулан) нийтлэх замаар ил тод байдлыг сайжруулах. Гуйвуулгын шимтгэлийн мэдээллийн сан байгуулах.
- Дэлхийн банк-ТЗЗДБХ-ны ерөнхий зарчмын дагуу Монгол Улс дахь мөнгөн гуйвуулгын зах зээлийн албан ёсны үнэлгээг эхлүүлэх.

Багана VIII. Хяналтын тогтолцоо

45. Төлбөр тооцооны системүүдээр хийгдэж буй гүйлгээний тоо хэмжээ өсөж, шинэ дэвшилтэт төлбөрийн хэрэгсэл нэвтэрч байгаатай холбоотойгоор Монголбанкнаас клирингийн болон төлбөр тооцооны дэд бүтцэд үр дүнтэй хяналт тавих, төлбөрийн зохицуулалтыг бэхжүүлэх шаардлагатай болж байна. Улс орны санхүүгийн тогтвортой байдлыг хангах, үндэсний валютад итгэх олон нийтийн итгэлийг хадгалах Төв банкны өргөн хүрээний үүрэг хариуцлагын нэг хэсэг болох Үндэсний төлбөрийн системийн хяналтын чиг үүргийн ач холбогдлыг Монголбанк хүлээн зөвшөөрөөд байна. Төлбөр тооцооны системүүд нь эдийн засгийн үндсэн элемент юм. Эдгээр системийн саатал нь санхүүгийн зах зээлийг доголдоход хүргэдэг. Жижиглэнгийн төлбөр тооцооны үр ашиггүй байдал нь хэрэглэгчдэд ногдох зардлыг нэмэгдүүлж, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг өргөжүүлэхэд саад бэрхшээл үүсгэдэг. Төв банкны хяналтын чиг үүрэг нь системүүдийг болзошгүй эрсдэлээс найдвартай хамгаалах, системийн үр ашигтай ажиллагааг хангах, иргэн, аж ахуйн нэгж, санхүүгийн бөөний зах зээл хоорондын хөрөнгийн урсгалыг найдвартай, түргэн шуурхай гүйцэтгэх нөхцөлийг баталгаажуулахад чиглэгдэнэ. Аливаа улс орон ҮТС-ийн цогц шинэчлэлийг хийх үед Төв банкны хяналтын чиг үүргийн асуудал хамгийн чухлаар тавигддаг.

46. Төлбөрийн системийн хяналт болон санхүүгийн байгууллагуудын хяналт шалгалт хоёр ялгаатай. Төлбөрийн болон төлбөр тооцооны системүүдийн хяналт нь одоо байгаа болон төлөвлөж буй системд хяналт шинжилгээ (мониторинг) хийх замаар системийн найдвартай, үр ашигтай ажиллагааг хангах, системд үнэлгээ хийх, шаардлагатай үед өөрчлөлт оруулах зорилготой Төв банкны чиг үүрэг юм.¹³ Банкны хяналт шалгалт хийх эрх бүхий байгууллага нь тодорхой байгууллагыг хянан шалгаж,

¹³ Төв банкнаас төлбөрийн болон төлбөр тооцооны системд хяналт тавих тухай ТЗЗДБХ-ны тайлан, 2005 оны 5 сар: Дотоодын болон олон улсын түвшинд үр дүнтэй хяналтыг хэрэгжүүлэх зарчмуудыг тодорхойлсон.

зохицуулдаг бол төлбөрийн системийн хяналт нь бүхий л системүүд, тэдгээрийн оролцогчид, төлбөрийн хэрэгслүүдийг хамардаг. Хяналт тавих аргачлалын хувьд мөн ялгаатай: банкны хяналт шалгалт нь төлбөрийн чадвар, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар талаас авч үзсэн, журамд суурилсан, байгууллагад суурилсан аргачлалтай байдаг бол төлбөрийн системийн хяналт нь системийг бүхэлд нь өргөн хүрээнд хамардаг утгаараа төлбөрийн системтэй холбоотой асуудлуудыг ихэвчлэн удирдамжид суурилсан, тушаал шийдвэрт суурилсан аргачлалаар шийдвэрлэдэг.

Монгол Улсын төлбөрийн системийн хяналт:

47. Монголбанкны зүгээс Төв банкуудын хяналтын зохицуулалтад хэрэглэгддэг ерөнхий зарчмуудад нийцүүлэх зорилгоор төлбөрийн системийн хяналтын чиг үүргээ бататгах хэд хэдэн алхмыг хийгээд байна. Төлбөрийн системийн хяналт болон хяналтын чиг үүргийг үр дүнтэй хэрэгжүүлэх зарчмуудын талаар ТЗЗДБХ-ноос 2005 онд гаргасан Төв банкны төлбөр тооцооны системийн хяналтын тайлан, ТЗЗДБХ болон ҮЦХОУБ-аас 2012 онд гаргасан Санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн зарчмууд: Санхүүгийн зах зээлийн дэд бүтцэд хамаарах Төв банкууд, зах зээлийн зохицуулагчид, бусад холбогдох эрх бүхий байгууллагуудын үүрэг хариуцлага тайланд тодорхой тусгасан (Хавсралт 2-ыг харна уу). Монголбанкны Төлбөр тооцоо, бүртгэлийн газрын бүтцэд төлбөрийн системийн хяналт хариуцсан Төлбөрийн бодлого, зохицуулалтын хэлтсийг байгуулсан бөгөөд тус хэлтсээс Төлбөрийн системийн хяналтын бодлогын баримт бичгийг батлуулж, газар дээр хяналт шалгалт хийх журмыг боловсруулаад байна. Түүнчлэн Төлбөрийн бодлого, зохицуулалтын хэлтсээс СЗЗДБЗ-ын дагуу Банксүлжээ системийн үнэлгээг хийж эхлээд байна. Төлбөрийн бодлого, зохицуулалтын хэлтэс нь ТТҮЗ-ийн ажлын албаны чиг үүргийг гүйцэтгэхийн зэрэгцээ 2015-2020 онд хэрэгжүүлэх Үндэсний төлбөрийн системийн стратегийг боловсруулах үндсэн бүрэлдэхүүн болж байна.

48. Төлбөрийн системийн хяналттай холбоотойгоор цаашид дараах асуудлуудад анхаарал хандуулах шаардлагатай:

- Хууль, эрх зүйн зохицуулалтын тогтолцоонд Төв банкны төлбөрийн системийн хяналтын чиг үүргийг ерөнхий байдлаар тусгах. Үр дүнтэй зохицуулалт, хяналтыг бий болгохын тулд Төв банкнаас төлбөрийн систем, төлбөрийн хэрэгсэл, төлбөрийн үйлчилгээ (үүнд банк бус төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдийг хамруулах)-нд хяналт тавих бүрэн эрх болон үүрэг хариуцлагыг хэрэгжүүлэхэд шаардлагатай эрх мэдлийг тодорхой тусгах хэрэгтэй. Үүнд өөрийн хяналтанд байгаа байгууллагуудаас шаардлагатай мэдээллийг цаг тухайд нь олж авах, шаардлагатай тохиолдолд өөрчлөлт хийх эрх мэдэл болон зохистой арга хэрэгслүүд хамаарна. Хууль, эрх зүйн зохицуулалтын асуудлуудыг Үндэсний төлбөрийн системийн тухай хууль, холбогдох журмуудад тодорхой тусгах шаардлагатай.
- Монголбанкны Төлбөрийн системийн хяналтын бодлогын баримт бичгийг шинэчлэх шаардлагатай. Төлбөрийн системийн хяналтын стратегийн орчинг дараах байдлаар тогтоох нь зүйтэй: (i) Дээд түвшинд тодорхойлогдсон хяналтын бодлогын зорилго буюу хяналтын стратегийн зорилтууд; (ii) Хяналтын чиг үүргийн хамрах хүрээ, өөрөөр хэлбэл хамаарах систем болон үйлчилгээний төрлүүд; (iii) Бодлогын стратегийн зорилтод хүрэхэд тодорхой системүүдэд шаардлагатай стандарт буюу

удирдамж; (iv) Хяналтын үйл ажиллагаа болон хяналтын арга хэрэгслүүд; (v) Хяналтан дахь байгууллагуудаас авч байгаа болон нийтэлж буй мэдээллийн төрөл.

- Төлбөрийн системийн хяналт хариуцсан ажилтнуудын тоог нэмэгдүүлж, чадавхыг бэхжүүлэх хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай. Үндэсний төлбөрийн системийн стратегид тусгасны дагуу хяналтын чиг үүрэг нарийн төвөгтэй болж, хариуцлага нэмэгдэж байгаа учраас одоо байгаа ажилтнуудын тоо хангалтгүй юм. Төлбөрийн болон төлбөр тооцооны системүүдийн хяналт нь байнгын үргэлжлэх процесс байх бөгөөд шинэ системүүдийн хөгжүүлэлт, шинэ дэвшилтэт төлбөрийн хэрэгслүүдийн зэрэгцээ ҮЦТТС, мөнгөн гуйвуулга болон төлбөрийн хэрэгслийн нэгдсэн хяналтын чиг үүрэг нь уг процессыг төвөгтэй болгож, одоо байгаа хүний нөөцөд нэмэлт ачаалал бий болгоно. Төлбөрийн системийн хяналтын нэгжид ҮТС-ийн Стратегийн хэрэгжилтийг хариуцсан ажилтан нэмэх шаардлагатай.
- Хяналтын горим, арга хэрэгслийг үйл ажиллагааны бүх төрлийн хувьд зохих түвшинд баримтжуулаагүй. Жижиглэнгийн төлбөр тооцооны системүүдийн хяналтын стандартыг тодорхой болгох шаардлагатай.
- Одоогийн байдлаар хяналт хэрэгжүүлэгч нэгжийн зүгээс Банксүлжээ системийг олон улсын стандартад нийцэж буй эсэхэд үнэлгээг хийж эхлээд байна. Монголбанк нь Монгол Улсын системийн хувьд чухал бүхий л системийн болон хяналтад хамаарах бусад системүүдийн байнгын үнэлгээг тогтсон хуваарийн дагуу хийх төлөвлөгөөг боловсруулах шаардлагатай. Шаардлагатай гэж үзвэл ийм үнэлгээг Монголбанкны бусад газар болон бусад эрх бүхий байгууллагуудтай (тухайлбал СЗХ) хамтарч хийнэ. Монголбанк дотроо Төлбөрийн системийн хороог үүсгэн байгуулснаар дотоодын уялдаа, хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэх боломжтой болно.
- Монголбанкны зохион байгуулалтын одоогийн бүтцээр хяналтын үйл ажиллагаа болон Банксүлжээ системийн үйл ажиллагааг зохих түвшинд тусгаарлаж чадаагүй. Төлбөрийн системийн хяналтыг хэрэгжүүлдэг нэгжийн ажилтны ажлын байрны тодорхойлолтод хяналт тавихтай холбоотой чиг үүргийг тодорхой тусгасан хэдий ч Монголбанкны зохион байгуулалтын бүтцээр тус нэгжийг албан ёсоор тусгаарлаагүй. Иймд, Төлбөрийн системийн хяналтын нэгжийг Төлбөрийн систем хариуцсан газарт бие даасан хэлтэс болгон зохион байгуулах шаардлагатай.
- Монголбанкны төлбөрийн системийн хяналтыг хэрэгжүүлэх нэгжийн ил тод байдал, хариуцлагыг сайжруулахын тулд Төлбөрийн системийн хяналтын тайланг жил тутам нийтэлж байх нь зүйтэй юм.

Алсын хараа: Төлбөрийн болон үнэт цаасны төлбөр тооцооны системийн хяналт, шалгалтын тогтолцоог нарийвчлан тодорхойлж, Монголбанкнаас зохицуулалтын болон хяналтын чиг үүрэг бүхий бусад байгууллагуудтай хамтран ажиллаж, хяналтын бүрэн эрхээ хэрэгжүүлэх.

Хэрэгжүүлэх стратеги

Стратеги #12: Монгол Улсын үндэсний төлбөрийн системийг бүхэлд нь үр дүнтэй хянах

- Үндэсний төлбөрийн систем, үүнд төлбөрийн үйлчилгээ, төлбөрийн хэрэгсэл, төлбөрийн үйлчилгээ үзүүлж буй ББСБ-ыг хамруулан бүхэлд нь хянах Монголбанкны хууль ёсны бүрэн эрх, эрх мэдлийг маш тодорхой томъёолон тогтоох (Үндэсний төлбөрийн системийн тухай шинэ хуулиар дамжуулан).
- Зорилт, хамрах хүрээ, стандарт, арга хэрэгслийг цогц байдлаар тусгах замаар хяналтын бодлогын баримт бичгийг шинэчлэх.
- Хяналтын чиг үүргийн горим, журмыг албан ёсны болгох. Хяналт тавих арга хэрэгслийг боловсруулж, баримтжуулах.
- Холбогдох системүүдэд үнэлгээ хийхэд зориулсан удирдамж боловсруулах. Жижиглэнгийн төлбөр тооцооны системүүд, төлбөрийн хэрэгслийн стандартыг тодорхойлох. Шинэ дэвшилтэт төлбөрийн схемийн эрсдэлийг үнэлэх суурь бүтцийг боловсруулах.
- СЗЗДБЗ-ын хэрэгжилтийг хангуулахын тулд холбогдох системийн үнэлгээг тогтмол хийж байх. Үүнд Банксүлжээ систем, системийн хувьд чухал жижиглэнгийн төлбөр тооцооны системүүд, Төв банкны үнэт цаасны ҮЦТХТ, ҮЦТТС болон арилжааны төлбөр тооцооны төв, түүнчлэн Засгийн газрын үнэт цаас болон компанийн үнэт цааснуудын ҮЦТТС, ҮЦТХТ хамаарна.
- Төлбөрийн системийн хяналтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий нэгжийг Банксүлжээ системийн үйл ажиллагаанаас албан ёсоор тусгаарлах зохион байгуулалтын оновчтой зохицуулалтыг бий болгох.
- Төлбөрийн системийн хяналтын ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг нарийвчлан боловсруулах, чадавхыг бэхжүүлэх сургалтад хамруулах замаар хяналтын нэгжийг чадавхжуулах.
- Монголбанк дотроо Төлбөрийн системийн хороог үүсгэн байгуулах асуудлыг анхаарч үзэх.

Стратеги #13: Төв банкнаас тавих төлбөрийн системийн хяналтын ил тод байдал, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх

- Төлбөрийн системийн хяналтын тайланг тогтмол нийтлэх. Уг тайланг санхүүгийн тогтвортой байдлын тайлантай нэгтгэн гаргаж болно. Төлбөрийн системийн үйл ажиллагаа, төлбөрийн хэрэгслийн талаар улирал тутам мэдээлэх.

Багана IX. Хамтын ажиллагаа

49. Санхүүгийн зах зээлийн дэд бүтцийг зохицуулах, хянан шалгах, хяналт тавих эрх бүхий байгууллагуудын хооронд үр ашигтай хамтын ажиллагааг бий болгох шаардлагатай. Хамтарсан хяналтын болон мэдээлэл хуваалцах зохицуулалтыг институцын түвшинд бүрдүүлснээр өөр өөр байгууллага хооронд мэдээлэл солилцохтой холбоотой бэрхшээл, хамтын ажиллагаан дахь санал зөрөлдөөн зэрэг үүсэж болзошгүй эрсдэлийг бууруулах боломжтой болно. Хяналтын чиг үүргийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд дараах байгууллагуудтай тууштай, зохион байгуулалттай хамтын ажиллагааг бий болгох шаардлагатай:

- Төлбөр, гүйлгээ, клиринг болон төлбөр тооцооны системүүдтэй холбоотой хяналтын зарим үүрэг хариуцлагыг Төв банкттай хамтран хүлээсэн бусад зохицуулагч байгууллагууд; эдгээр нь Төв банкинд харьяалагддаг байгууллага эсвэл бие даасан өөр байгууллага байж болно.
- ТТҮЗ-өөс хяналт хийхээр тодорхойлсон системийн операторууд болон томоохон оролцогч нар;
- Олон улсын хэмжээнд хэрэглэгдэж байгаа хяналтын бодлого, стандартыг хамтран боловсруулах шаардлагатай бусад Төв банкууд болон олон улсын байгууллагууд.

50. Монголбанк нь Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөр дамжуулан Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-той хамтарч ажилладаг. Монголбанк, Сангийн яам, СЗХ хамтарч санхүүгийн өрсөлдөөнтэй, найдвартай дэд бүтцийг хөгжүүлэх, санхүүгийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах замаар эдийн засгийн тогтвортой өсөлтөд хувь нэмэр оруулах эрхэм зорилгын үндсэн дээр Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийг үүсгэн байгуулсан. Хамтын ажиллагааны механизмд гол төлөв уулзалт, санал бодол солилцох үйл явц хамаардаг. Тус зөвлөл нь жилд хэд хэдэн удаа хурал хийдэг боловч хэлэлцэх асуудлын жагсаалтад төлбөрийн системтэй холбоотой асуудлууд ордоггүй.

51. ТТҮЗ нь Монгол Улсын ҮТС-тэй холбоотой эрх бүхий байгууллагууд болон хувийн хэвшлийн хоорондын хамтын ажиллагааны үндсэн форум юм. 2008 онд батлагдсан ТТҮЗ-ийн үйл ажиллагааны журам, мөн 2008 онд батлагдсан ТТҮЗ-ийн дүрэмд зааснаар Зөвлөлийн хурал нь хагас жилдээ нэг удаа тогтмол болдог ч Зөвлөлийн түвшинд эсвэл тус Зөвлөлд тайлагнадаг таван ажлын хэсгийн хүрээнд хэлэлцэж шийдвэрлэсэн бодлого эсвэл өөрчлөлтийн томоохон асуудал цөөхөн байна. Шаардлагатай тохиолдолд Монголбанк оролцогч талуудын удирдлагын түвшинд уулзалт зохион байгуулдаг.

Алсын хараа: Үндэсний төлбөрийн системийн хэмжээнд үр дүнтэй, зохион байгуулалттай, үр ашигтай хамтын ажиллагааг бий болгох

Хэрэгжүүлэх стратеги

Стратеги #14: Эрх бүхий байгууллагууд болон салбарын бусад байгууллагуудтай хамтран ажиллах зохицуулалтыг сайжруулах

- СЗХ болон холбогдох бусад байгууллагатай төлбөр болон төлбөр тооцоотой холбоотой асуудлаар хамтран ажиллах тухай Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурах (эсхүл, өмнө байгуулсан санамж бичигт нэмэлт өөрчлөлт оруулах). Монголбанкны зүгээс Санхүүгийн зохицуулах хороотой төлбөр тооцооны системд хийсэн үнэлгээний үр дүнг солилцох.
- ТТҮЗ-ийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, хөгжүүлэх. Жижиглэнгийн төлбөр тооцооны системүүд болон Банксүлжээ систем тус бүр дээр Ажлын баг үүсгэн байгуулах.

Хавсралт 1.**Хэрэгжүүлэх төлөвлөгөө**

Монгол Улсын ҮТС-ийг хөгжүүлэх төлөвлөгөөнд ирэх 5 жилийн хугацаанд (2020 он хүртэл) хэрэгжүүлэх стратегийн хөтөлбөрүүдийг үе шаттайгаар тусгах нь зүйтэй юм. Үе шат тус бүрт хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг бодитойгоор тусгана. Төлөвлөгөөний үе шатыг тодорхойлохдоо Монгол Улсын ҮТС-ийн өнөөгийн нөхцөл байдлын үнэлгээ болон хэрэгжүүлэх стратегийн зорилтуудын ач холбогдлын дарааллыг үндэслэсэн. Зарим стратегийн зорилтуудыг богино хугацаанд хэрэгжүүлэх боломжтой бол зарим зорилтуудыг 4-5 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр байна. Стратегийн зорилтуудыг 3 үе шатад хуваасан: (i) Нэг жилийн дотор хэрэгжүүлэх ойрын хугацааны зорилтууд. Зарим үйл ажиллагааг Монголбанк хэрэгжүүлээд эхэлсэн байгаа. (ii) Богино хугацааны зорилтуудыг 2-3 жилийн хугацаанд хэрэгжүүлэх төсөөлөл дэвшүүлсэн. (iii) Дунд хугацааны зорилтуудыг ирэх 4-5 жилийн хугацаанд хэрэгжүүлнэ.

Монгол Улсын ҮТС-ийг хөгжүүлэх стратегийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг эмхэтгэн дараах хүснэгтэд тусгасан болно.

Ойрын хугацааны зорилтууд (2016 онд хэрэгжүүлэх)

Багана	Санал болгох зорилтууд	Хариуцах байгууллага
I. Хууль, эрх зүйн тогтолцоо	Стратеги #1: Төлбөрийн болон төлбөр тооцооны систем, төлбөрийн хэрэгсэл, төлбөрийн үйлчилгээний хууль, эрх зүйн зохицуулалтын орчинг бэхжүүлэх • UTC-ийн тухай хуулийн төслийг боловсруулах, холбогдох байгууллагуудтай хамтарсан Ажлын хэсэг байгуулах • Төлбөрийн хууль, эрх зүйн зохицуулалтын тогтолцоог бий болгох Ажлын хэсгийг Монголбанкинд байгуулах. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Төлбөр тооцоо, бүртгэлийн газар (хяналт, үйл ажиллагаа хариуцсан нэгжүүд), Хууль, эрх зүйн газар, Зах зээлийн газар, Мэдээллийн технологийн газар болон бусад холбогдох нэгжийн төлөөллийг оролцуулах. • Төлбөрийн болон төлбөр тооцооны систем, төлбөрийн хэрэгсэл, төлбөрийн үйлчилгээтэй холбоотой бүхий л харилцаа, асуудлыг цогц байдлаар зохицуулах Үндэсний төлбөрийн системийн тухай иж бүрэн хуулийн төслийг боловсруулах ажлыг ахлан боловсруулж эхлэх. • Төлбөрийн системд хяналт тавих журам, мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлгийн журам, агент банкны үйлчилгээний журам, заавар зэрэг UTC-ийн тухай шинэ хуулийг хэрэгжүүлэх журмуудын төслийг боловсруулж эхлэх. • БДТТС ба КНС-ний журам, үйл ажиллагааны дүрэм, системийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж, эрсдэлийн удирдлага, оролцогчдод тавих шаардлага, маргаан шийдвэрлэх тухай зүйл заалтуудыг тодорхой болгох. Цахим худалдааны гүйлгээ, шинэ төлбөрийн хэрэгслүүдийн гүйлгээний боловсруулалт хийх тухай журмын төсөл боловсруулах. Шууд дебит гүйлгээг зохицуулах журмын төсөл боловсруулах. • Төв банкны үнэт цаасны хувьд ҮЦТТС ба ҮЦТХТ болж байгаа Монголбанкны чиг үүргийг журамд тусгах ажлыг эхлүүлэх. • СЗХ, Монголбанк, Сангийн яам, ҮЦТХТ, Арилжааны төлбөр тооцоо зэрэг байгууллагууд хамтран Засгийн газрын үнэт цаасны клиринг, төлбөр тооцоотой холбоотой зохицуулалтын тогтолцоо, журам дүрмийг шинэчлэх.	Монголбанк Монголбанк Монголбанк Монголбанк Монголбанк Монголбанк СЗХ, Монголбанк, Сангийн яам, Арилжааны төлбөр тооцооны төв, ҮЦТХТ

II. Их дүнтэй бөгөөд хугацааны хувьд чухал төлбөрүүдэд зориулсан төлбөр тооцооны механизм	Стратеги #2: Банксүлжээ системийн эрсдэлийн удирдлага, үр ашгийг сайжруулах • Банксүлжээ систем болон жижиглэнгийн төлбөр тооцооны системүүд хоорондын харилцан хамаарлаас үүдэлтэй эрсдэлийг үнэлэх. Банксүлжээ системд СЗЗДБЗ-ын хэрэгжилтийг хангуулах үнэлгээний хүрээнд уг үнэлгээг хийх боломжтой. Жижиглэнгийн төлбөр тооцооны системүүдээс үүсэх олон талын үр дүнгийн позицгийн төлбөр тооцооны улмаас бий болж байгаа, зээлийн болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварт нөлөөлөх дүнг барьцаатай болгох сонголтод дүн шинжилгээ хийх. • Банксүлжээ системийн ажиллах цагийг байнга сунгаж байгаа шалтгааныг анхаарч, залруулах арга хэмжээ авах. Үйл ажиллагааны алдаа, саатлыг бууруулахад чиглэсэн санхүүгийн хөшүүргийг нэвтрүүлэх (тухайлбал, төлбөрийн эрт шилжүүлэх хөшүүргийг бий болгох үүднээс торгуулийн болон үнийн бодлого нэвтрүүлэх) • Банксүлжээ систем (мөн Бага дүнтэй төлбөр тооцооны системд зориулсан)-ийн Хэрэглэгчдийн Групп үүсгэх. Стратеги #3: Банксүлжээ системийн үйл ажиллагааны найдвартай, аюулгүй байдлыг нэмэгдүүлэх • Аливаа тасалдлын дараа системийг дахин эхлүүлэх, нөхөн сэргээх хэмжигдэхүйц зорилтыг тодорхойлох, нөхөн сэргээх хугацааг багасгах. Нөөц төвд хангалттай эх үүсвэр байршуулах. Засвар үйлчилгээний гэрээг сайжруулах. • Тасралтгүй ажиллагааны төлөвлөгөө болон Гамшгийн дараах нөхөн сэргээх зохицуулалтын дагуу туршилтыг тогтмол хийх, олон төрлийн сценарыг хамруулах. • Банксүлжээ системийн үйл ажиллагааг хариуцсан ажилтнуудын тоог нэмэгдүүлэх талаар шаардлагатай арга хэмжээ авах.	Монголбанк, Монголбанк, оролцогчид Монголбанк, оролцогчид Монголбанк, оролцогчид Монголбанк Монголбанк
III. Жижиглэнгийн төлбөр тооцооны системүүд	Стратеги #4: Бэлэн бус төлбөрийн хэрэгслийн хэрэглээг дэмжих. Харилцан зохицолдоо, стандартчлал, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг дэмжих. • Шинэ Автоматжуулсан клирингийн төвийг нэвтрүүлэх Төсөл хэрэгжүүлэх нэгжийг байгуулж, үйл ажиллагааны болон техникийн шаардлагыг тодорхойлох. • Монголын банкуудад IBAN стандартыг нэвтрүүлэх боломжийг судлах Стратеги #5: Жижиглэнгийн төлбөр тооцооны системүүдийн эрсдэлийн удирдлагыг бэхжүүлэх • Жижиглэнгийн төлбөр тооцооны системүүдийн үйл ажиллагааны дүрэм, журмыг сайжруулах. Цэвэр дебит хязгаар тогтоох, хөрөнгийн нөөц буюу барьцаатай холбоотой зохицуулалт хийх, оролцогч талуудад цаг тухайд нь мэдээлэл	Монголбанк, Монголбанк, оролцогчид Монголбанк, оролцогчид

	хүргэх зэргээр БДТТС, КНС-ний төлбөр тооцооны эрсдэлийг бууруулах боломжийг судлан, дүн шинжилгээ хийх. БДТТС буюу шинэ Автоматжуулсан клирингийн төвдөөр хийгдсэн төлбөрүүдийн үр дүнгийн тооцооллын төлбөр тооцоог тухайн өдөрт нь гүйцэтгэх асуудлыг судалж үзэх. Энэ төрлийн механизмыг шинэ Автоматжуулсан клирингийн төвийн дүрэмд тусгах. - Тасралтгүй ажиллагааны төлөвлөгөө болон Гамшгийн дараах нөхөн сэргээх зохицуулалтын дагуу тогтмол туршилт хийх төлөвлөгөөг хэрэгжүүлэх. Тасралтгүй ажиллагааны төлөвлөгөө болон Гамшгийн дараах нөхөн сэргээх зохицуулалтыг туршиж эхлэх. - Жижиглэнгийн төлбөр тооцооны системүүдийн маргаан шийдвэрлэх ажиллагааг боловсронгуй болгох, бэхжүүлэх.	Монголбанк, оролцогчид Монголбанк, оролцогчид
IV. Засгийн газрын төлбөрүүд	Стратеги #7: Засгийн газрын гүйлгээнд цахим төлбөр нэвтрүүлэх ажилд дэмжлэг үзүүлэх - Төрийн үйлчилгээний төлбөрийг онлайнаар хийх интернет портал үүсгэх тухай Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх. - Монголбанкны дэмжлэгтэйгээр Засгийн газар болон банкууд нь Засгийн газрын төлбөрүүдээс авах шимтгэлийн оновчтой бүтцийг судалж, тохиролцох. - Төсвийн орлого бүрдүүлэхэд (татварын албаны болон гаалийн системээр дамжуулан) зориулагдсан цахим-засаг системийн нэвтрүүлэлтийг дэмжих. Эдгээр системүүдийг нэвтрүүлэхэд учирч буй саад бэрхшээлийг арилгахын тулд холбогдох хууль тогтоомжийг сайжруулах. - Засгийн газрын гадаад өр, буцалтгүй тусламжтой холбоотой төлбөрийг цахим төлбөрт шилжүүлэх.	СЯ, Монголбанк СЯ, Монголбанк, банкууд СЯ, Монголбанк СЯ
V. Үнэт цаасны хадгаламжийн төв, клиринг, төлбөр тооцооны зохицуулалт	Стратеги #8: Төв банкны үнэт цаасны клиринг, төлбөр тооцоотой холбоотой журам, системийг боловсронгуй болгох - Төв банкны үнэт цаасны клиринг, төлбөр тооцооны журмыг бататгах. Журамд Төв банкны үнэт цаасны хувьд ҮЦТХТ, ҮЦТТС болж буй Монголбанкны чиг үүргийг тодорхой тусгах. Стратеги #9: Бирж дээр арилжаалагдаж байгаа үнэт цааснуудын ҮЦТТС, ҮЦТХТ-ийн эрсдэлийн удирдлага, үр ашгийг сайжруулах - Монгол Улсын үнэт цаасны зах зээлийн онцлогт нийцүүлэн үнэт цаасны клиринг, үнэт цаасны хадгаламж, эзэмших эрхийн бүртгэлийн үйл ажиллагааг тодорхойлох. - Үнэт цаасны клиринг, төлбөр тооцоо, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн шинэ байгууллагуудын зарчим, бодлого, үйл ажиллагааны журмыг боловсруулах. - МХБ, Арилжааны төлбөр тооцоо болон ҮЦТХТ зэрэг байгууллагуудын зүгээс Монголын хөрөнгийн бирж дээр арилжаалагдаж буй үнэт цааснуудын мөнгөн хөрөнгийн клиринг, төлбөр тооцоотой холбоотой эрсдэлийн удирдлагын зохицуулалт болон дүрэм журмыг боловсронгуй болгох.	Монголбанк СЗХ, Монголбанк, Арилжааны төлбөр тооцоо, ҮЦТХТ СЗХ, Монголбанк, Арилжааны төлбөр тооцоо, ҮЦТХТ

VII. Олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	Стратеги #11: Олон улсын мөнгөн гуйвуулгын үр ашигтай үйлчилгээг дэмжих Гадаад ажиллаж буй иргэдийн олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээний зохицуулалтыг нягтлан үзэж, нөхцөл байдлын үнэлгээг эхлүүлэх.	Монголбанк, СЗХ
VIII. Хяналтын тогтолцоо	Стратеги #12: Монгол Улсын Үндэсний төлбөрийн системийг бүхэлд нь үр дүнтэйгээр хянах - Хяналтын зорилт, хамрах хүрээ, стандарт, арга хэрэгслийг цогц байдлаар тусгаж, хяналтын бодлогыг шинэчлэх. - Хяналт шинжилгээний аргачлал боловсруулах. Хяналтын чиг үүргийн горимыг албан ёсны болгох, тухайлбал, дүн шинжилгээ хийх зорилгоор цуглуулах шаардлагатай мэдээ мэдээлэл болон системийн үнэлгээ, хяналтын тайлан, нийтлэлийн хэлбэр, давтамж. - СЗЗДБЗ-ын хэрэгжилтийг хангуулах зорилгоор Банксүлжээ системд хийсэн үнэлгээг гүйцэтгэж дуусгах. Төв банкны үнэт цаасны хувьд ҮЦТТС/ҮЦТХТ-ийн үнэлгээг эхлүүлэх. - Арилжааны төлбөр тооцоо, ҮЦТТС, ҮЦТХТ-ийг СЗЗДБЗ-ын дагуу үнэлж эхлэхэд нь СЗХ, компанийн болон Засгийн газрын үнэт цаасны Арилжааны төлбөр тооцоо, ҮЦТХТ-д дэмжлэг үзүүлэх. Үнэлгээг Монголбанкттай хамтарч хийж болно. - Төлбөрийн системд хяналт тавих нэгжийн ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг нарийвчлан боловсруулах, чадавхыг бэхжүүлэх сургалтын хөтөлбөр хамруулах замаар хяналтын нэгжийг чадавхжуулах. Төлбөрийн хяналтын нэгжийн нэг ажилтныг хуулийн чиглэлээр сурган мэргэшүүлэх асуудлыг шийдвэрлэх.	Монголбанк, СЗХ Монголбанк Монголбанк Монголбанк, СЗХ Монголбанк
IX. Хамтын ажиллагааны хамрах хүрээ	Стратеги #14: Эрх бүхий байгууллагууд болон салбарын бусад байгууллагатай хамтран ажиллах зохицуулалтыг сайжруулах - Эрх бүхий бусад байгууллагууд болон Монголбанкны бусад газруудтай Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурах (Санхүүгийн зохицуулах хороотой байгуулсан санамж бичгийг сайжруулах) замаар хамтарсан хяналтыг бататгах тухай хэлэлцүүлэг эхлүүлэх. Төв банкны үнэт цаасны хувьд ҮЦТТС, ҮЦТХТ болж байгаа Монголбанкны үнэт цаасны төлбөр тооцооны систем болон төвлөрсөн хадгаламжийн төвийн үнэлгээг хийхийн тулд ВЭЗГ-тай Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурах буюу ижил төрлийн арга хэмжээ авах. - ТТҮЗ-ийн ажиллагааг идэвхжүүлэх, хөгжүүлэх. Бага дүнтэй төлбөр тооцооны систем, Банксүлжээ системийг хариуцсан Ажлын хэсэг байгуулах.	Монголбанк, СЗХ, Сангийн яам Монголбанк, гишүүд

50	ХАВСРАЛТ 1. ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ	МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙГ ХӨГЖҮҮЛЭХ СТРАТЕГИ
----	------------------------------------	--

Богино хугацааны зорилтууд (2018 он хүртэл хэрэгжүүлэх)

Багана	Санал болгох үйл ажиллагаа	Хариуцах байгууллага
I. Хууль, эрх зүйн тогтолцоо	Стратеги #1: Төлбөрийн болон төлбөр тооцооны систем, төлбөрийн хэрэгсэл, төлбөрийн үйлчилгээний хууль, эрх зүйн зохицуулалтын орчинг бэхжүүлэх - Төлбөрийн болон төлбөр тооцооны систем, төлбөрийн хэрэгсэл, төлбөрийн үйлчилгээтэй холбоотой бүхий л харилцаа, асуудлыг цогц байдлаар зохицуулах Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийг нэвтрүүлэх. - ҮТС-д бүхэлд нь хяналт тавих Монголбанкны бүрэн эрхийг ойлгомжтой тодорхойлох зорилгоор ҮТС-ийн тухай хуульд нийцсэн Төлбөрийн системд хяналт тавих журмыг нэвтрүүлэх. Тус журмыг газар дээр хяналт шалгалт хийх тухай одоо үйлчилж буй журамтай нэгтгэх. - Цахим төлбөрийн хэрэгслээр дамжуулан гүйцэтгэсэн шилжүүлгийг хүчин төгөлдөр болгох, холбогдох эрх үүргийг зохицуулах зорилготой мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлгийн тухай журмыг нэвтрүүлэх. - Агент банкны үйлчилгээний тухай журам/зааврыг нэвтрүүлэх. - Төв банкны үнэт цаасны хувьд ҮЦТТС, ҮЦТХТ болж буй Монголбанкны чиг үүргийг тодорхой тусгасан журмыг нэвтрүүлэх. - Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (AML/CFT) шаардлагыг бүх төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч болон төлбөрийн операторт таниулах.	УИХ Монголбанк Монголбанк Монголбанк Монголбанк Монголбанк
II. Их дүнтэй бөгөөд хугацааны хувьд чухал төлбөрүүдэд зориулсан төлбөр тооцооны механизм	Стратеги #2: Банксүлжээ системийн эрсдэлийн удирдлага, үр ашгийг сайжруулах - Монголбанкны өдөр дундын төлбөр түргэн гүйцэтгэх чадварын хэрэгсэл (ILF)-ийн хүсэлт гаргахад хийгдэж буй гар ажиллагааг халах. Зөвшөөрөгдсөн барьцаа хөрөнгийг үндэслэн оролцогч талуудад төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангуулах зээлийг шууд олгох. - Жижиглэнгийн төлбөр тооцооны системүүдээс үүсэж буй олон талын үр дүнгийн позицйн төлбөр тооцоог хийх үед оролцогчдын хооронд болон оролцогч СЗЗДБ-ийн хооронд үүсэж болзошгүй зээлийн болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэлээс хамгаалах барьцаа байршуулах механизмыг нэвтрүүлэх. - Банксүлжээ системд зориулсан эрсдэлийн удирдлагын цогц баримт бичгийг боловсруулах.	Монголбанк Монголбанк Монголбанк

	Стратеги #3: Банксүлжээ системийн үйл ажиллагааны найдвартай, аюулгүй байдлыг нэмэгдүүлэх • Үйл ажиллагааны тасалдлын олон төрлийн сценарийг шийдвэрлэхийн тулд тасралтгүй ажиллагааны төлөвлөгөө (BCP)-г сайжруулах. • Бүх оролцогчид, холбогдсон системүүдийг хамарсан системийн хэмжээний туршилтыг хийх. Системийн хэмжээнд ачаалал даах туршилт (stress test)-ыг тогтмол орчныг бүрдүүлэх. • Шийдвэрлэх нөхцөлд мэдээлэл солилцох төлөвлөгөө боловсруулж баримтжуулах, оролцогч талуудыг бүрэн хамруулах.	Монголбанк, оролцогчид Монголбанк, оролцогчид Монголбанк, оролцогчид
III. Жижиг-лэнгийн төлбөр тооцооны системүүд	Стратеги #4: Бэлэн бус төлбөрийн хэрэгслийн хэрэглээг дэмжих. Харилцан зохицолдоо, стандартчлал, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг дэмжих. • Кредит болон шууд дебит шилжүүлгийн орчин үеийн Автоматжуулсан клирингийн төв (АКТ)-ийг нэвтрүүлэх. Шинэ АКТ нь шинэ дэвшилтэт төлбөрийн хэрэгслийн клирингийг хийх хүчин чадалтай байх. • Банксүлжээ системтэй нийцтэй байхын тулд Шинэ АКТ-д холбогдох стандартуудыг (тухайлбал, ISO20022) нэвтрүүлэх. • Монгол Улсын бүх банкуудад IBAN стандартыг нэвтрүүлэх асуудлыг анхаарч үзэх. • Шинэ АКТ-ийн шаардлагад нийцэхийн тулд банкууд програм хангамждаа шаардлагатай тохируулга хийх. • Корпорациудад зориулсан гарц (gateway)-ыг хөгжүүлэх • КНС-г боловсронгуй болгож цахим худалдааны гүйлгээ, интернэтээр болон мобайлаар хийх төлбөр зэрэг шинэ дэвшилтэт төлбөрийн хэрэгслүүдийг дэмжих. • Салбарын хэмжээнд зөвлөлдсөний үндсэн дээр цахим төлбөрийн механизмыг нэвтрүүлэх, жижиглэнгийн төлбөрүүдийг хүлээж авах дэд бүтцийг өргөтгөх, хөдөө орон нутагт хүрч ажиллах хөшүүрэг бий болгох арга замыг эрэлхийлэх. • Цахим төлбөрийн хэрэгслийн ашиг тусын талаарх хэрэглэгчдийн мэдлэгийг дээшлүүлэх. Стратеги #5: Жижиглэнгийн төлбөр тооцооны системүүдийн эрсдэлийн удирдлагыг бэхжүүлэх • Цэвэр дебит хязгаар тогтоох, хөрөнгийн нөөц буюу барьцаатай холбоотой зохицуулалт хийх, оролцогчид цаг тухайд нь мэдээлэл хүргэх зэргээр БДТТС, КНС-ний төлбөр тооцооны эрсдэлийг бууруулах механизмыг нэвтрүүлэх. • БДТТС/ шинэ АКТ-өөр тухайн өдөр дамжсан төлбөрүүдийн үр дүнгийн тооцооллыг өдөрт нь багтаан гүйцэтгэх механизмыг хэрэгжүүлэх.	Монголбанк, оролцогчид Монголбанк Монголбанк, оролцогчид Оролцогчид Монголбанк, оролцогчид Монголбанк Монголбанк Монголбанк, оролцогчид Монголбанк, оролцогчид Монголбанк, оролцогчид

	- Бүх оролцогчдыг хамруулсан системийн хэмжээний ачаалал даах туршилтыг хийж эхлэх. Ийм туршилт (stress test)-ыг жилд нэг удаа хийж байх. - Шийдвэрлэх нөхцөлд мэдээлэл солилцох төлөвлөгөө боловсруулах. - Интернетээр болон мобайлаар хийсэн төлбөрийн маргааныг шийдвэрлэх процессыг боловсронгуй болгох. Стратеги #6: Залилантай холбоотой болон мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн удирдлагыг сайжруулах. - Монголбанкнаас NFC картад зориулсан мэдээллийн аюулгүй байдлын минимум стандартыг тогтоож мөрдүүлэх. - Төлбөрийн картын EMV стандартад шилжих зохицуулалтыг бий болгох.	Монголбанк, оролцогчид Монголбанк, оролцогчид Монголбанк, оролцогчид Монголбанк Монголбанк, оролцогчид
IV. Засгийн газрын төлбөрүүд	Стратеги #7: Засгийн газрын гүйлгээнд цахим төлбөр нэвтрүүлэх ажилд дэмжлэг үзүүлэх - Засгийн газрын интернет портал ашиглан хийх үйлчилгээнд оруулах төрийн үйлчилгээний тоог аажмаар нэмэгдүүлэх. - Одоо байгаа болон цаашид нэвтрүүлэх төлбөрийн дэд бүтцийг (Банксүлжээ болон АКТ) нийгмийн халамж, тэтгэврийн олголтод үр ашигтайгаар ашиглах.	СЯ, Монголбанк СЯ, Монголбанк
V. Үнэт цаасны хадгаламжийн төв, клиринг, төлбөр тооцооны зохицуулалт	Стратеги #8: Төв банкны үнэт цаасны клиринг, төлбөр тооцооны системүүд болон дүрэм журмыг боловсронгуй болгох - Монголбанкны нээлттэй зах зээлийн үйл ажиллагаа, өдөр дундын болон овернайт зээл, банк хоорондын зах зээлийг хөгжүүлэхийн тулд Төв банкны үнэт цаасны бүрэн автоматжуулсан ҮЦТТС, ҮЦТХТ-ийг бий болгох. Одоо байгаа системийг солих эсхүл сайжруулах асуудлыг авч хэлэлцэх. Банксүлжээ системтэй холбогдох ҮЦТТС, ҮЦТХТ-ийн сонголтод үнэлгээ хийх. - Төв банкны үнэт цаасны клиринг, төлбөр тооцооны зохицуулалтын орчин, эрсдэлийн удирдлагыг боловсронгуй болгох (Стратеги #1)-ийг харна уу. - Монголбанкны байнгын хэрэгслүүд, банк хоорондын репог дэмжихийн тулд төв банкны үнэт цаасны ҮЦТТС/ҮЦТХТ-ийг бүрэн автоматжуулах (Стратеги #2-ыг харна уу). Стратеги #9: Бирж дээр арилжаалагдаж байгаа үнэт цааснуудын ҮЦТТС, ҮЦТХТ-ийн эрсдэлийн удирдлага, үр ашгийг сайжруулах - ҮТС-ийн тухай шинэ хуулийн дагуу үнэт цаасны клиринг, төлбөр тооцоотой холбоотой бүхий л асуудлыг шийдвэрлэдэг байхаар үнэт цаасны клиринг, төлбөр тооцооны зохицуулалтын орчинг сайжруулахад МХБ, Арилжааны төлбөр тооцоо, ҮЦТХТ-д дэмжлэг үзүүлэх.	Монголбанк Монголбанк СЗХ, Монголбанк, Арилжааны төлбөр тооцоо, ҮЦТХТ, төлбөр тооцооны банкууд СЗХ, Монголбанк, Арилжааны төлбөр тооцоо, ҮЦТХТ.

	- Арилжааны төлбөр тооцоо, ҮЦТХТ, Монголбанкны дүрэм, журамд биржийн бус зах зээл дээр арилжаалагдаж буй Засгийн газрын үнэт цаасны клиринг, төлбөр тооцооны горимын тухай тодорхой тусгах. Процессыг бүрэн автоматжуулах. - Үнэт цаасны клиринг, төлбөр тооцооны систем, ҮЦТХТ-ийн үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын тогтолцоо, ялангуяа, Тасралтгүй ажиллагааны төлөвлөгөө, Гамшгийн дараа нөхөн сэргээх зохицуулалтыг олон улсын жишгийн дагуу бэхжүүлэх.	СЗХ, Монголбанк, Арилжааны төлбөр тооцоо, ҮЦТХТ, төлбөр тооцооны банкууд
VI. Валютын арилжаа, банк хоорондын мөнгөний зах зээл	Стратеги #10: Валютын арилжааны зах зээлийн гүйлгээнүүдийн клиринг, төлбөр тооцоог бүрэн автоматжуулах. Валютын арилжааны төлбөр тооцоог ТэТ (PvP) зарчмаар хийх. Валютын арилжааны төлбөр тооцоог ТэТ (PVP) зарчмаар хийх боломжийг судлах.	Монголбанк, банкууд
VII. Олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	Стратеги #11: Олон улсын үр ашигтай мөнгөн гуйвуулгын үйлчилгээг дэмжих - Мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлдэг банк бус болон бусад санхүүгийн байгууллагуудаас гуйвуулгын үйлчилгээний тухай мэдээллийг тогмол авч байх орчинг бүрдүүлэх. - Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний үнэ тарифын мэдээллийн сан үүсгэх боломжийг судлах. - ТЗЗДБХ-Дэлхийн банкнаас гаргасан Ерөнхий зарчмуудын дагуу Монгол Улсын мөнгөн гуйвуулгын зах зээлийн албан ёсны үнэлгээг эхлүүлэх.	Монголбанк, СЗХ Монголбанк, СЗХ Монголбанк, СЗХ, СЯ
VIII. Хяналтын тогтолцоо	Стратеги #12: Монгол Улсын Үндэсний төлбөрийн системийг бүхэлд нь үр дүнтэйгээр хянах - Төв банкны үнэт цаасны ТТС/ТХТ-ийн үнэлгээг хийх. - Шинэ Автоматжуулсан клирингийн төв болон төлбөрийн картын свитчийн үнэлгээг хийх. - ҮЦТТС, Арилжааны төлбөр тооцоо, ҮЦТХТ-ийг СЗЗДБЗ-ын дагуу үнэлэхэд СЗХ, компанийн болон Засгийн газрын үнэт цаасны Арилжааны төлбөр тооцоо, ҮЦТХТ-д дэмжлэг үзүүлэх. - Жижиглэнгийн төлбөр тооцооны системд мөрдөх стандартыг боловсруулах, хяналтын бодлогыг шинэчлэх. - Шинэ АКТ болон КНС-ний холбогдох стандартад нийцэж буй эсэх үнэлгээг хийх. - Төлбөрийн системд хяналт тавихтай холбоотойгоор оролцогчид, бусад зохицуулагч, Монголбанкны дотоод системээс мэдээллийг цуглуулах, нэгтгэх ажиллагааг автоматжуулах платформыг бий болгох. - Шинэ дэвшилтэт төлбөрийн схемийн эрсдэлийн үнэлгээний орчинг боловсруулах.	Монголбанк Монголбанк СЗХ, Монголбанк Монголбанк Монголбанк Монголбанк

	- Төлбөрийн систем хариуцсан газрын бүтцэд төлбөрийн системийн хяналтыг хариуцах бие даасан хэлтсийг үүсгэн байгуулах замаар төлбөрийн системийн хяналтын чиг үүргийг Банксүлжээ системийн үйл ажиллагаанаас албан ёсоор тусгаарлах. - Төлбөрийн системийн хяналтын хэлтсийн ажилтнуудын чадавхыг бэхжүүлэх, сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх. Стратеги #13: Төв банкнаас тавих төлбөрийн системийн хяналтын ил тод байдал, хариуцлагыг нэмэгдүүлэх - Шинэчилсэн хяналтын бодлогын баримт бичгийг олон нийтэд мэдээлэх. - Хяналтын тайланг нийтэлж эхлэх.	Монголбанк Монголбанк Монголбанк Монголбанк
IX. Хамтын ажиллагааны хамрах хүрээ	Стратеги #14: Эрх бүхий байгууллагууд болон салбарын бусад байгууллагатай хамтран ажиллах зохицуулалтыг сайжруулах - Төв банкны үнэт цаасны ТТС, ТХТ-ийн үнэлгээг хийх зорилгоор Монголбанк дотроо ВЭЗГ-тай хамтын ажиллагааг бий болгох, СЗХ-той Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурах (өмнөх санамж бичгийг сайжруулах). - Төлбөрийн болон төлбөр тооцооны системд хийсэн үнэлгээний үр дүнг СЗХ-той хуваалцах.	Монголбанк, СЗХ Монголбанк, СЗХ

Дунд хугацааны зорилтууд (2020 он дуустал хэрэгжүүлэх)

Багана	Санал болгох үйл ажиллагаа	Хариуцах байгууллага
I. Хууль, эрх зүйн тогтолцоо	Стратеги #1: Төлбөрийн болон төлбөр тооцооны систем, төлбөрийн хэрэгсэл, төлбөрийн үйлчилгээний хууль, эрх зүйн зохицуулалтын орчинг бэхжүүлэх.	
II. Их дүнтэй бөгөөд хугацааны хувьд чухал төлбөрүүдэд зориулсан төлбөр тооцооны механизм	Стратеги #2: Банксүлжээ системийн эрсдэлийн удирдлага, үр ашгийг сайжруулах - Банксүлжээ системд төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хадгалах механизм нэвтрүүлэх асуудлыг авч үзэх. - СЗЗДБЗ-ын дагуу өөрийгөө-үнэлэх үнэлгээний явцад илэрсэн дутагдлуудыг шийдвэрлэх. Стратеги #3: Банксүлжээ системийн үйл ажиллагааны найдвартай, аюулгүй байдлыг нэмэгдүүлэх - Банксүлжээ системийг урьдчилж тогтоосон хуваарийн дагуу тогтмол туршиж байх.	Монголбанк, системийн оролцогчид Монголбанк Монголбанк, системийн оролцогчид
III. Жижиглэнгийн төлбөр тооцооны системүүд	Стратеги #4: Бэлэн бус төлбөрийн хэрэгслийн хэрэглээг дэмжих. Харилцан зохицолдоо, стандартчлал, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг дэмжих. - Цахим төлбөрийн хэрэгслийн ашиг тусын талаарх хэрэглэгчдийн мэдлэгийг нэмэгдүүлэх. - ҮЦГТ-ийг Монголбанкнаас тусдаа бие даасан байгууллага хэлбэрээр зохион байгуулах боломжит гарцыг эрэлхийлэх. Стратеги #5: Жижиглэнгийн төлбөр тооцооны системүүдийн эрсдэлийн удирдлагыг бэхжүүлэх - СЗЗДБЗ-ын дагуу АКТ болон КНС-нд хийсэн, өөрийгөө-үнэлэх үнэлгээгээр илэрсэн дутагдлуудад анхаарал хандуулах. - Урьдчилан тогтоосон хуваарийн дагуу ачаалал даах туршилт (stress test)-ыг тогтмол хийх. - Шийдвэрлэх нөхцөлд мэдээлэл солилцох төлөвлөгөөг турших. Стратеги #6: Залилантай холбоотой болон мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн удирдлагыг сайжруулах - Бүх картууд болон холбогдох дэд бүтцийг EMV стандартад шилжүүлэх.	Монголбанк, системийн оролцогчид Монголбанк Монголбанк Монголбанк, системийн оролцогчид Монголбанк, системийн оролцогчид Монголбанк, системийн оролцогчид
IV. Засгийн газрын төлбөрүүд	Стратеги #7: Засгийн газрын гүйлгээнд цахим төлбөр нэвтрүүлэх ажилд дэмжлэг үзүүлэх Засгийн газрын бүх үйлчилгээг хамруулан төрийн үйлчилгээний төлбөрийг онлайнаар хийхэд зориулагдсан интернет порталыг нэвтрүүлэх ажлыг бүрэн хэрэгжүүлэх.	СЯ, Монголбанк

	- Засгийн газрын төлбөрүүдийг цахим төлбөрийн хэрэгслээр хийхтэй холбоотой Засгийн газрын бусад төсөл, хөтөлбөрүүдийг дэмжих. - Засгийн газрын бүх төрлийн төлбөрийг цахим төлбөрийн хэрэгсэлд шилжүүлэх ажлыг дуусгавар болгох. Банксүлжээ систем, шинэ АКТ, КНС-ээр дамжуулан клиринг, төлбөр тооцооны үр ашигтай зохицуулалтыг хангах.	СЯ, Монголбанк СЯ, Монголбанк
V. Үнэт цаасны хадгаламжийн төв, клиринг, төлбөр тооцооны зохицуулалт	Стратеги #8: Төв банкны үнэт цаасны клиринг, төлбөр тооцоотой холбоотой дүрэм журам, системийг боловсронгуй болгох - Төв банкны үнэт цаасны ТТС/ТХТ-д СЗЗДБЗ-ын дагуу хийсэн, өөрийгөө-үнэлэх үнэлгээний явцад илэрсэн дутагдлуудыг арилгах. Стратеги #9: Бирж дээр арилжаалагдаж байгаа үнэт цааснуудын ҮЦТТС, ҮЦТХТ-ийн эрсдэлийн удирдлага, үр ашгийг сайжруулах - Бирж дээр арилжаалагдаж буй үнэт цааснуудын ҮЦТТС, ҮЦТХТ-д СЗЗДБЗ-ын дагуу хийсэн, өөрийгөө-үнэлэх үнэлгээгээр илэрсэн дутагдлуудыг арилгах.	Монголбанк Монголбанк, СЗХ
VI. Валютын арилжаа, банк хоорондын мөнгөний зах зээл	Стратеги #10: Валютын арилжааны зах зээл дээр хийгдэж буй гүйлгээний клиринг, төлбөр тооцоог бүрэн автоматжуулах. Валютын арилжааны төлбөр тооцоог ТэТ (PvP) зарчмаар хийх. Валютын арилжааны төлбөр тооцоонд ТэТ (PvP) зарчмыг хэрэгжүүлэх.	Монголбанк, банкууд
VII. Олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	Стратеги #11: Олон улсын үр ашигтай мөнгөн гуйвуулгын үйлчилгээг дэмжих - ТЗЗДБХ-Дэлхийн банкнаас гаргасан Ерөнхий зарчмын дагуу Монгол Улсын мөнгөн гуйвуулгын зах зээлийг үнэлсэн албан ёсны үнэлгээгээр илэрсэн дутагдлуудыг арилгах. - Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний үнэ тарифын мэдээллийн сангаар дамжуулан ил тод байдлыг нэмэгдүүлэх.	Монголбанк, СЗХ, СЯ Монголбанк, СЗХ
VIII. Хяналтын тогтолцоо	Стратеги #12: Монгол Улсын Үндэсний төлбөрийн системийг бүхэлд нь үр дүнтэйгээр хянах - Мэдээлэл цуглуулах платформыг бүрэн ажиллагаанд оруулах. - Төлбөрийн болон төлбөр тооцооны бүхий л системийн үнэлгээг тогтмол хийх. Стратеги #13: Төв банкнаас тавих төлбөрийн системийн хяналтын ил тод байдал, хариуцлагыг нэмэгдүүлэх - Хяналтын тайлан, статистикийн тайлан, хөгжлийн дүн шинжилгээний үр дүнг тогтмол нийтлэх.	Монголбанк Монголбанк Монголбанк

IX. Хамтын ажиллагааны хамрах хүрээ	Стратеги #14: Эрх бүхий байгууллагууд болон салбарын бусад байгууллагатай хамтран ажиллах зохицуулалтыг сайжруулах • Төлбөр тооцооны үндэсний зөвлөлийг дэмжих. Үйл ажиллагааг хянаж, шаардлагатай нэмэлт өөрчлөлтийг оруулах. • СЗХ болон бусад эрх бүхий байгууллагатай хамтран ажиллах зохицуулалтыг тогтмол нягталж, шинэчлэх.	Монголбанк, гишүүд Монголбанк, СЗХ
--	--	--

Хавсралт 2.**ТЗЗДБХ-ҮЦХОУБ-аас гаргасан Санхүүгийн зах зээлийн
дэд бүтцийн зарчмууд (СЗЗДБЗ)****Ерөнхий бүтэц****Зарчим 1: Эрх зүйн зохицуулалт**

Санхүүгийн зах зээлийн дэд бүтэц (СЗЗДБ)-ийн тухайн улс орон дахь үндсэн үйл ажиллагаа нь эрх зүйн тодорхой, ил тод, хэрэгжихүйц зохицуулалттай байна.

Зарчим 2: Засаглал

СЗЗДБ нь үйл ажиллагааныхаа найдвартай, үр ашигтай байдлыг хангаж, санхүүгийн тогтвортой байдлыг дэмжсэн, олон нийтийн эрх ашиг, холбогдох этгээдийн зорилго, зорилтод нийцсэн тодорхой, ил тод засаглалттай байна.

Зарчим 3: Эрсдэлийн удирдлагын нэгдсэн тогтолцоо

СЗЗДБ нь хууль эрх зүйн, зээлийн, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын, үйл ажиллагааны болон холбогдох бусад эрсдэлийг цогцоор нь удирдах эрсдэлийн удирдлагын нэгдсэн тогтолцоотой байна.

Зээлийн болон Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэлийн удирдлага**Зарчим 4: Зээлийн эрсдэл**

СЗЗДБ нь оролцогчдод олгосон зээлийн хүндрэл болон төлбөр тооцоо, клирингийн үйл ажиллагаанаас бий болж болзошгүй зээлийн эрсдэлийг бодитоор үнэлж, хянаж, удирдах шаардлагатай. СЗЗДБ нь оролцогч бүрт олгосон зээлийн хүндрэлээс найдвартай хамгаалах санхүүгийн хангалттай эх үүсвэртэй байх шаардлагатай юм. Түүнчлэн, илүү эрсдэл бүхий үйл ажиллагаатай эсхүл олон улс оронд системийн талаас нэн чухал үүрэг гүйцэтгэдэг Арилжааны төлбөр тооцооны төв (ССР)-ийн хувьд болзошгүй нөхцөл байдлаас гарах санхүүгийн хангалттай нэмэлт эх үүсвэртэй байх ёстой. Тухайлбал, зах зээлийн онцгой нөхцөл байдлын улмаас Арилжааны төлбөр тооцооны төв (ССР)-д хамгийн том зээлийн эрсдэл учруулж болохуйц хоёр томоохон оролцогч болон тэдний охин компаниуд үүргээ биелүүлэх боломжгүй болох нөхцөл үүсэж болох юм. Бусад бүх Арилжааны төлбөр тооцооны төв (ССР)-ийн хувьд зах зээлийн онцгой нөхцөл байдлын улмаас хамгийн том зээлийн эрсдэл учруулж болохуйц томоохон оролцогч болон түүний охин компаниуд нь үүргээ биелүүлээгүйгээс үүсэх эрсдэлийг даван туулах хангалттай санхүүгийн эх үүсвэртэй байх шаардлагатай.

Зарчим 5: Барьцаа хөрөнгө

СЗЗДБ нь өөрийн болон оролцогчдынхоо зээлийн хүндрэлийг удирдах зорилгоор барьцаа хөрөнгө байршуулахыг, шаардлагатай бол зээлийн, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын, зах зээлийн эрсдэл багатай барьцаа хөрөнгийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй. Түүнчлэн, дэд бүтэц нь барьцаа хөрөнгийн үнэлгээний хорогдуулалтын тогтвортой хувь (haircuts) болон хөрөнгө төвлөрлийн хязгаар тогтоож, мөрдөх шаардлагатай.

Зарчим 6: Маржин

Арилжааны төлбөр тооцооны төв (ССР) нь эрсдэлд суурилсан, хяналт, үнэлгээнд тогтмол хамрагддаг, үр дүнтэй маржины систем ашиглан оролцогчдод олгосон зээлийн эрсдэлийг удирдана.

Зарчим 7: Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэл

СЗЗДБ нь төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэлээ бодитоор үнэлж, хянаж, удирдах шаардлагатай. Дэд бүтэц нь зах зээлийн онцгой нөхцөл байдлын үед төлбөрийн томоохон үүрэг хүлээсэн оролцогч, түүний охин компаниуд үүргээ биелүүлэх боломжгүй болох зэрэг болзошгүй нөхцөл байдал үүссэн үед ч тухайн өдөр боловсруулсан гүйлгээний төлбөр тооцоог аль болох өдөрт нь багтаан найдвартай хийхийн тулд төлбөр тооцоонд ашиглагдаж буй валют бүрээр хангалттай хэмжээний түргэн хөрвөх эх үүсвэр байршуулах нь зүйтэй.

Төлбөр тооцоо**Зарчим 8: Төлбөр тооцоог эцэслэх**

СЗЗДБ нь төлбөр тооцоог хамгийн багадаа л тухайн өдрийн эцэс гэхэд гүйцэтгэсэн байх ёстой. Шаардлагатай эсхүл боломжтой тохиолдолд төлбөр тооцоог тухайн өдөрт нь багтаан эсхүл бодит цагийн горимоор гүйцэтгэж байх нь зүйтэй.

Зарчим 9: Мөнгөн хөрөнгөөр хийх төлбөр тооцоо

СЗЗДБ нь аль болох төв банкин дахь мөнгөн хөрөнгөө ашиглан төлбөр тооцоог гүйцэтгэнэ. Төв банкин дахь мөнгөн хөрөнгийг ашигладаггүй тохиолдолд арилжааны банкин дахь мөнгөн хөрөнгөө ашигласнаас үүсэж болзошгүй зээлийн болон төлбөрийн чадварын эрсдэлийг бууруулж, хатуу хяналт тавих шаардлагатай.

Зарчим 10: Биет нийлүүлэлт

СЗЗДБ нь биет бараа, бүтээгдэхүүнийг нийлүүлэхтэй холбоотойгоор гүйцэтгэх үүргийг тодорхой зааж, үүнээс учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлж, хянаж, удирдана.

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв болон хөрөнгийн дүнгээр солилцох төлбөр тооцооны систем**Зарчим 11: Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв (ҮЦТХТ)**

ҮЦТХТ нь үнэт цаасны бүрэн бүтэн байдлыг хангах, тэдгээрийг найдвартай хадгалах, хамгаалах, шилжүүлэхтэй холбоотой эрсдэлийг бууруулах, удирдах үйл ажиллагааг зохицуулсан дүрэм, журамтай байна. Түүнчлэн, ҮЦТХТ нь үнэт цаасны шилжүүлгийг цахим бүртгэлээр хийж, үнэт цаасыг биетээр эргэлтэд оруулалгүй, биет бус хэлбэртэйгээр хадгалж байх ёстой.

Зарчим 12: Хөрөнгийн дүнгээр солилцох төлбөр тооцооны систем

Хэрэв СЗЗДБ нь санхүүгийн хоёр талт үүрэг хариуцлагатай холбогдсон гүйлгээ (жишээлбэл, үнэт цаас, гадаад валютын арилжааны гүйлгээ)-г боловсруулдаг бол холбогдох гүйлгээний төлбөр тооцоо хийгдсэн тохиолдолд л тухайн гүйлгээний төлбөр тооцоог хийж үндсэн эрсдэлээс зайлсхийх шаардлагатай.

Үүргээ биелүүлэх боломжгүй болох үеийн удирдлага**Зарчим 13: Оролцогч үүргээ биелүүлэх боломжгүй болсон үед дагаж мөрдөх дүрэм, журам**

СЗЗДБ нь оролцогч үүргээ биелүүлэх боломжгүй болсны улмаас үүсэх нөхцөл байдлыг зохицуулах тодорхой дүрэм, журамтай байна. Эдгээр дүрэм, журам нь хохирол алдагдлыг хязгаарлаж, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын хүндрэлд орохоос зайлсхийсэн цагаа олсон арга хэмжээг авах, хүлээсэн үүргээ цаашид биелүүлэх бололцоог тухайн СЗЗДБ-д олгоход чиглэгдсэн байна.

Зарчим 14: Харилцагчийн позиц, барьцаа хөрөнгийг тусгаарлан бүртгэх, шилжүүлэх

Арилжааны төлбөр тооцооны төв нь оролцогчийнхоо харилцагч этгээдийн позиц, түүнтэй холбогдуулан байршуулсан барьцаа хөрөнгийг тусгаарлан бүртгэх, шилжүүлэх ажиллагааг зохицуулсан дүрэм, журамтай байна.

Бизнесийн болон үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага**Зарчим 15: Бизнесийн эрсдэл**

СЗЗДБ нь бизнесийн эрсдэлээ тодорхойлж, хянаж, удирдаж, томоохон алдагдал хүлээсэн тохиолдолд үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн, үйлчилгээгээ үзүүлсээр байхын тулд өөрийн хөрөнгөөс бүрдсэн түргэн хөрвөх хангалттай, цэвэр хөрөнгөтэй байна. Түүнчлэн, түргэн хөрвөх цэвэр хөрөнгө нь голлох үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой саатал гарсан зэрэг системийг сэргээн засварлаж, үйлчилгээгээ хэвийн үзүүлэхэд ямар ч үед хүрэлцэхүйц байх ёстой.

Зарчим 16: Кастодианы үйлчилгээ болон хөрөнгө оруулалтын эрсдэлүүд

СЗЗДБ нь өөрийн болон оролцогчдынхоо хөрөнгийг найдвартай хамгаалж, тэдгээрийг удирдахад хугацаа алдсанаас үүсэх эрсдэлийг бууруулна. СЗЗДБ нь зээлийн, зах зээлийн, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэл хамгийн багатай хэрэгслүүдэд хөрөнгө оруулалт хийх ёстой.

Зарчим 17: Үйл ажиллагааны эрсдэл

СЗЗДБ нь үйл ажиллагааны эрсдэлийн дотоод, гадаад боломжит хүчин зүйлсийг тодорхойлж, оновчтой бодлого, журам, систем, хяналтын механизмаар дамжуулан тэдгээрийн үр дагаврыг бууруулна. Систем нь аюулгүй байдал, үйл ажиллагааны найдвартай байдлыг өндөр түвшинд хангахаар төлөвлөгдсөн байхын зэрэгцээ ачаалал даан ажиллах хангалттай хүчин чадалтай байна. Бизнесийн тасралтгүй байдлын төлөвлөгөө нь өргөн хүрээтэй томоохон саатал гарсан үед ч гэсэн тухайн СЗЗДБ-д үйл ажиллагааг цаг алдалгүй сэргээж, үүргээ биелүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдсэн байна.

Оролцоо**Зарчим 18: Оролцогчид тавигдах шаардлага, шалгуур**

СЗЗДБ нь оролцогчдод шударга, нээлттэй оролцоог дэмжсэн, эрсдэлд суурилсан, олон нийтэд ил тод шаардлага, шалгуурыг тавина.

Зарчим 19: Шууд бус оролцогчтой холбоотой зохицуулалт

СЗЗДБ нь шууд бус оролцогчидтой холбоотой зохицуулалтаас үүсэж болзошгүй эрсдэлүүдийг тодорхойлж, хянаж, удирдана.

Зарчим 20: СЗЗДБ-ийн хамтын ажиллагаа

Бусад СЗЗДБ-тэй хамтын ажиллагаа бүхий СЗЗДБ нь хамтын ажиллагаатай холбоотой эрсдэлийг тодорхойлж, хянаж, удирдана.

Үр ашигтай байдал**Зарчим 21: Үр ашигтай ба үр дүнтэй байдал**

СЗЗДБ нь оролцогчдын болон тухайн зах зээлийн хэрэгцээ шаардлагыг хангахдаа үйл ажиллагааныхаа үр ашигтай, үр дүнтэй байдлыг хадгалах ёстой.

Зарчим 22: Харилцаа холбооны стандарт ба горим

СЗЗДБ нь төлбөр тооцоо, клиринг, бүртгэлийн үйл ажиллагааныхаа үр ашигтай байдлыг хангахын тулд мэдээлэл харилцаа холбооны олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандарт, горимуудыг ашиглах буюу тэдгээрт нийцэн ажиллах шаардлагатай.

Ил тод байдал**Зарчим 23: Дүрэм, журам, мэдээллийн ил тод байдал**

СЗЗДБ нь тодорхой, цогц дүрэм, журамтай байх шаардлагатай бөгөөд оролцогчдод учирч болзошгүй эрсдэл, үйлчилгээний шимтгэл, хураамж болон бусад томоохон зардлын талаарх үнэн зөв ойлголт өгөх үүднээс хангалттай мэдээллээр хангана. Түүнчлэн, холбогдох дүрэм, журмуудыг олон нийтэд нээлттэй, ил тод байлгах ёстой.

Зарчим 24: Арилжааны мэдээллийн сан (TR) дахь мэдээллийн ил тод байдал

Арилжааны мэдээллийн сан (TR) нь холбогдох эрх бүхий байгууллага, олон нийтийг тэдний хэрэгцээ шаардлагад нийцсэн, цагаа олсон, үнэн зөв мэдээллээр хангана.

Санхүүгийн зах зээлийн дэд бүтэцтэй холбоотойгоор Төв банк, зах зээлийн зохицуулагчид болон бусад байгууллагуудын хүлээх үүрэг хариуцлагууд

Хариуцлага А: СЗЗДБ-ийн зохицуулалт, хяналт, шалгалт

СЗЗДБ нь төв банк, холбогдох бусад эрх бүхий байгууллагын оновчтой, үр дүнтэй хяналт, шалгалт, зохицуулалтад хамрагдах ёстой.

Хариуцлага В: Зохицуулалт, хяналт, шалгалтын бүрэн эрх, нөөц бололцоо

Төв банк, холбогдох бусад эрх бүхий байгууллага нь СЗЗДБ-ийг хянан шалгах, хяналт тавих, зохицуулалтаар хангах үүрэг хариуцлагаа үр дүнтэй гүйцэтгэхэд шаардлагатай бүрэн эрх, нөөц бололцоотой байна.

Хариуцлага С: Бодлогын ил тод байдал

Төв банк, холбогдох бусад эрх бүхий байгууллага нь СЗЗДБ-тэй холбоотой хяналт, шалгалт, зохицуулалтын бодлогоо ойлгомжтой тодорхойлж, нийтэд ил тод болгоно.

Хариуцлага D: СЗЗДБЗ-ын хэрэглээ

Төв банк, холбогдох бусад эрх бүхий байгууллага нь ТТСХ болон ҮЦХОУБ-аас гаргасан “СЗЗДБ-ын зарчмууд”-ыг баримталж, нийцүүлэн мөрдүүлнэ.

Хариуцлага E: Бусад эрх бүхий байгууллагатай хамтран ажиллах

Төв банк, холбогдох бусад эрх бүхий байгууллага нь СЗЗДБ-ийн найдвартай, үр ашигтай ажиллагааг дэмжин үндэсний болон олон улсын түвшинд хамтран ажиллана.

Хавсралт 3.

Жижиглэнгийн төлбөр тооцооны цогц стратегийг боловсруулах удирдамж

Улс орнуудад жижиглэнгийн төлбөр тооцооны цогц стратегийг хөгжүүлэхэд ашиглах суурь бүтцийг Дэлхийн банкнаас боловсруулаад байна. Тус суурь бүтцийг Дэлхийн банк, ТЗЗДБХ, бусад олон улсын болоод үндэсний байгууллагуудын өнгөрсөн хугацаанд хийсэн судалгаануудыг нэгтгэх замаар, 100 гаруй улс орны төлбөрийн системийн шинэчлэлд дэмжлэг үзүүлэх явцдаа хуримтлуулсан Дэлхийн банкны олон улсын туршлагад үндэслэн боловсруулсан.

Энэхүү суурь бүтэц нь Үндэсний төлбөрийн системийн нийтлэг зорилгоос гадна жижиглэнгийн төлбөр тооцоотой холбоотой олон янзын төрийн бодлого, зорилтын хүрээг өргөжүүлэх бололцоог бий болгож байна. Авч хэрэгжүүлэх гэж буй төрийн бодлого зорилтын богино жагсаалт нь:

- Төлбөрийн үйлчилгээний хүртээмжийн хялбар, хямд төсөр байдлыг дэмжих;
- Жижиглэнгийн төлбөр тооцооны хэрэгцээ шаардлагад нийцсэн төлбөрийн хэрэгслүүд болон механизмуудыг хөгжүүлэх үр ашигтай дэд бүтцийн хөгжлийг дэмжих;
- Нийгмийн хувьд хамгийн тохиромжтой төлбөрийн хэрэгслийн хэрэглээг дэмжих.

Эдгээр төрийн бодлого, зорилтод хүрэхийн тулд дараах удирдамжийг санал болгож байна:

Удирдамж I: Жижиглэнгийн төлбөр тооцооны зах зээл нь ил тод, төлбөр төлөгч болон хүлээн авагчийн ашиг сонирхлыг зохистой түвшинд хамгаалсан, зардал багатай байх шаардлагатай.

Удирдамж II: Жижиглэнгийн төлбөр тооцоо нь тодорхой санхүүгийн, харилцаа холбооны болон бусад төрлийн дэд бүтцүүдийг шаардана; эдгээр дэд бүтцийг жижиглэнгийн төлбөр тооцооны үр ашгийг өсгөх зорилгоор бий болгох нь зүйтэй. Шаардлагатай дэд бүтцэд банк хоорондын цахим шилжүүлгийн систем, зээлийн хороо, мэдээлэл солилцох платформ, банк хоорондын их дүнтэй нэг бүрчилсэн төлбөр тооцооны систем, найдвартай харилцаа холбооны болон үндэсний хэмжээний дэд бүтцийн бэлэн байдал зэрэг орно.

Удирдамж III: Жижиглэнгийн төлбөр тооцоо нь тодорхой, ойлгомжтой, үл ялгаварласан мөн тэнцүү хууль, эрх зүйн зохицуулалтын тогтолцоотой байна.

Удирдамж IV: Жижиглэнгийн төлбөр тооцооны салбарт хамтын ажиллагаа болон өрсөлдөөний зохистой тэнцвэрийг хангахын зэрэгцээ өрсөлдөөнт зах зээлийн нөхцөлүүдийг дэмжинэ.

Удирдамж V: Жижиглэнгийн төлбөр тооцоо нь зохистой засаглал болон эрсдэлийн удирдлагын тогтолцоотой байна.

Удирдамж VI: Төрийн эрх бүхий байгууллагууд нь жижиглэнгийн төлбөр тооцооны зах зээлийг үр дүнтэй хянаж, шаардлагатай тохиолдолд шууд оролцож болно.

Хавсралт 4.**Олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээний
ерөнхий зарчмууд**

Үндсэн зарчим нь олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээний найдвартай, үр ашигтай байдлыг хангахад чиглэсэн төрийн бодлого, зорилтыг хэрэгжүүлэх зорилготой. Энэ ч утгаараа, энэ үйлчилгээний зах зээл нь ил тод, нээлттэй, найдвартай, өрсөлдөөнтэй байна.

Ил тод байдал ба хэрэглэгчийг хамгаалах

Ерөнхий зарчим 1. Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний зах зээл нь ил тод байхаас гадна хэрэглэгчийг хангалттай түвшинд хамгаална.

Төлбөрийн системийн дэд бүтэц

Ерөнхий зарчим 2. Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний үр ашгийг дээшлүүлэх боломж бүхий төлбөрийн системийн дэд бүтцийн хөгжлийг дэмжиж ажиллана.

Хууль, эрх зүйн зохицуулалтын орчин

Ерөнхий зарчим 3. Холбогдох улс орон дахь мөнгөн гуйвуулгын үйлчилгээ нь тогтвортой, урьдчилан мэдэх боломжтой, үл ялгаварласан, тэнцвэртэй хууль, эрх зүйн зохицуулалтын тогтолцоотой байна.

Зах зээлийн бүтэц, өрсөлдөөн

Ерөнхий зарчим 4. Мөнгөн гуйвуулгын салбарт дотоодын төлбөр тооцооны дэд бүтцэд нэвтрэх гэх зэрэг өрсөлдөөнт зах зээлийн нөхцөлүүдийг дэмжинэ.

Засаглал, эрсдэлийн удирдлага

Ерөнхий зарчим 5. Зохистой засаглал болон эрсдэлийн удирдлагын туршлагаар мөнгөн гуйвуулгын үйлчилгээг дэмжинэ.

**МӨНГӨН ГҮЙВУУЛГЫН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИД БОЛОН ТӨРИЙН
БАЙГУУЛЛАГУУДЫН ҮҮРЭГ**

А. Мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэгчдийн үүрэг. Мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэгчид нь ерөнхий зарчмуудыг хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцох ёстой.

В. Төрийн байгууллагуудын үүрэг. Төрийн байгууллагууд нь ерөнхий зарчмуудыг хэрэгжүүлэх замаар төрийн бодлого, зорилтдоо хүрэхийн тулд ямар арга хэмжээ авах шаардлагатайг үнэлнэ.

Хавсралт 5.**Үр дүнтэй хяналтын ерөнхий зарчмууд**

1. Төв банк нь өөрийн хяналтын бодлогоо олон нийтэд мэдээлэх ёстой ба ингэхдээ систем бүрт тавигдах бодлогын шаардлага эсвэл стандартууд мөн аль системд хамаарахыг тогтоох шалгуурууд зэргийг оруулна.
2. Төв банк нь төлбөр тооцооны системүүдэд, хамааралтай тохиолдолд, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг мөрдүүлэх ёстой.
3. Төв банк нь хяналтын үүрэг хариуцлагаа үр дүнтэй хэрэгжүүлэх бүрэн эрх, чадавхтай байх ёстой.
4. Төв банкны ажиллуулдаг системүүд, адилтгах төлбөрийн болон төлбөр тооцооны системүүдэд хяналтын стандартуудыг тогтмол мөрдүүлэх ёстой.
5. Төлбөрийн болон төлбөр тооцооны системүүдийн аюулгүй, үр ашигтай байдлыг дэмжихийн тулд төв банк нь бусад төв банкууд болон эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллах ёстой.

Хавсралт 6.**Төлбөрийн системийг хөгжүүлэх ерөнхий удирдамж*****А. Банкны систем***

Удирдамж 1. Төв банк гол үүрэгтэй байх: үндэсний валютын тогтвортой байдлыг хангах ерөнхий үүргийнхээ дагуу төв банк нь үр ашигтай төлбөрийн хэрэгсэл болох мөнгөний хэрэглээг хөгжүүлэхэд гол үүргийг гүйцэтгэнэ.

Удирдамж 2. Банкны системийн тогтвортой байдлыг хангах: банкууд болон бусад ижил төстэй санхүүгийн байгууллагуудаас эцсийн хэрэглэгчид үзүүлж буй төлбөрийн данс, хэрэгсэл, үйлчилгээ нь хоорондоо өрсөлдөх хэдий ч системийнхээ хувьд үргэлж хамтран ажиллах шаардлагатай.

В. Төлөвлөлт

Удирдамж 3. Үндэсний төлбөрийн системийг цогцоор нь авч үзэх: төлөвлөлт нь үндэсний төлбөрийн системийн гол бүрэлдэхүүн хэсгүүд болон түүний хөгжилд нөлөөлөх үндсэн хүчин зүйлсийн бүх талын ойлголцолд суурилсан байх ёстой.

Удирдамж 4. Эрэлт хэрэгцээг голчлон анхаарах: үндэсний төлбөрийн системийн бүх хэрэглэгчийн төлбөрийн хэрэгцээ, эдийн засгийн боломжийг тодорхойлж, тэдгээрт нийцсэн үйл ажиллагаа явуулна.

Удирдамж 5. Эн тэргүүний зорилтуудыг тодорхойлох: үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэх эн тэргүүний зорилтуудыг тодорхойлж, стратегийн арга барилаар төлөвлөнө.

Удирдамж 6. Гол нь хэрэгжүүлэх: стратеги төлөвлөлтийг үр дүнтэй хэрэгжүүлэх баталгаатай байх ёстой.

С. Эрх зүйн орчин

Удирдамж 7. Зах зээлийн хөгжлийг дэмжих: төлбөрийн үйлчилгээний зах зээлийн зохицуулалтыг бэхжүүлэх, өргөжүүлэх нь үндэсний төлбөрийн системийн хөгжлийн гол хэсэг болдог.

Удирдамж 8. Холбогдох бүх талуудыг хамруулах: үндэсний төлбөрийн системийн холбогдох бүх талууд бүтээлчээр зөвлөлдөн хэлэлцэхийг дэмжинэ.

Удирдамж 9. Хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд хамтран ажиллах: төв банкны зүгээс төлбөрийн системийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд бусад эрх бүхий байгууллагатай хамтран ажиллах шаардлагатай.

Удирдамж 10. Хууль, эрх зүйн тодорхой байдлыг хангах: үндэсний төлбөрийн системийн талаар тодорхой, иж бүрэн, ил тод хуулийн тогтолцоог бий болгох шаардлагатай.

D. Дэд бүтэц

Удирдамж 11. Жижиглэнгийн төлбөр тооцооны үйлчилгээний хүртээмжийг өргөжүүлэх: жижиглэнгийн төлбөр тооцооны дэд бүтцийг сайжруулж, өргөжүүлэх замаар хэрэглэгч, аж ахуй нэгж, засгийн газрын байгууллагад үзүүлэх үйлчилгээ, үр ашигтай, найдвартай бэлэн бус төлбөрийн хэрэгслийн сонголт, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Удирдамж 12. Их дүнтэй төлбөрийн системийг хөгжүүлэх: банк хоорондын, хугацааны хувьд чухал төлбөрийн өсөлт, санхүүгийн зах зээлийн хэрэгцээнд үндэслэн их дүнтэй төлбөрийн системийг хөгжүүлэх.

Удирдамж 13. Төлбөрийн болон үнэт цаасны системийг хамтад нь хөгжүүлэх: санхүүгийн системийн үр ашигтай, аюулгүй байдлыг хангахын тулд үнэт цаасны болон их дүнтэй төлбөрийн системүүдийг нийцүүлэн хөгжүүлэх ёстой.

Удирдамж 14. Жижиглэнгийн, их дүнтэй болон үнэт цаасны системийн төлбөр тооцоог зохицуулах: Үндсэн системүүдийн төлбөр гүйцэтгэх чадварын харилцан хамааралтай хэрэгцээ болон тэдгээрийн хоорондын төлбөр тооцооны эрсдэлийг үр дүнтэй удирдахын тулд төлбөр тооцоог гүйцэтгэх ажиллагааг зохицуулах ёстой.

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙГ ХӨГЖҮҮЛЭХ СТРАТЕГИ	ТЭМДЭГЛЭЛ	67
---	-----------	----

68	ТЭМДЭГЛЭЛ	МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙГ ХӨГЖҮҮЛЭХ СТРАТЕГИ
----	-----------	---

